

**АЙМЩИГ**



Р.М. Стайн  
**АНХНЫ  
БОЛЗОО**

Анхны болзоо  
Зохиолч: Р.Л Стайн  
Орчуулагч: Ж. Сарантуяа

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

Челси Ричардс бол даруухан, ганцаардмал, хайр сэтгэлийг хүссэн сурагч охин. Хэн нэг нь түүнийг болзоонд уриасай хэмээн тэр мөрөөддөг. Гэтэл Уилл, Спаркс хэмээх бүр хоёр ч хөвгүүн гарч ирлээ. Тэдний нэг нь солиотой алуурчин. Хөөрхий Челси! Түүний анхны болзоо эцсийх нь болно гэж үү?.

## 1-р бүлэг

Гадаа юу болж байгаа нь бидэнд харагдахгүй байна, биднийг ч хүн харахгүй байна гэж охин түүний мөрийг налан хэллээ.

Бид хоёр яг өөрийн гэсэн тусдаа ертөнцөд байгаа юм шиг. Хөвгүүн инээмсэглэн охиныг бие рүүгээ татаад үнсэж эхэллээ. Охин зовхио буулгалаа, харин залуу цантаж цагаан нөмрөгөөр бүтээчихсэн мэт харагдах машины салхины шил рүү нүдээ томоор нээж харлаа. Энэ машин дотор ямар халуун байх юм бэ? гэж тэр охиныг үнсэнгээ бодлоо. Бүр амьсгалах агааргүй болчихож. Цэвэр агаар амьсгалъя.

Тэгэхгүй бол үхэх нь. Охин толгойгоо өргөснөө мөрөөдөнгүй инээмсэглээд

Жо хэмээн шивнэв. Хөвгүүн машины цонх руу ширтсэн чигээрээ цаана нь байгаа шөнө, чийгтэй өндөр өвс, бараантсан моднуудыг санаандаа төсөөлнө. “Амьсгалж болохгүй нь. Агаар дутагдаж байна”. Охин духаараа түүний цээжийг налснаа санаа алдлаа. Түүний үснээс жүржний үнэр ханхлав. Хүүгийн уруул дээр охины чихэрлэг мөртлөө бас исгэлэндүү уруулын будагны амт үлджээ. За байз, энэний нэрийг хэн гэсэн билээ?

Урьд нь би хэзээ ч энд эрэгтэй хүүхэдтэй хамт машинаар ирж зогсож байгаагүй гэж охин түүний савхин хүрэмд нүүрээ наалдуулан хэллээ.

“Энэ чинь намайг багалзуурдах нь шив” гэж тэр бодлоо.

Би бүтэж үхэх нь ээ. Яахаараа ийм бүгчим байдаг байна?”

Залуу гараа охины мөрөн дээрээс аваад сунгаж машины цонх онгойлгож эхлэв.

Үгүй. Хэрэггүй. Биднийг харчихаж мэднэ. Гэхдээ энд бид хоёулханаа байна шүү дээ хэмээн тэр татгалзлаа.

– Бид хоёр ч азтай юм аа. Өнөөдөр энд өөр машин алга байна.

– Тэр сэрүүн агаар гүн амьсгалж аваад шилээ дээшлүүллээ.

– Гадна талд бүдэгхэн саарал сарны хэлтэрхий бүр доор ёлтойж байлаа.

Кенди түүний гарыг мөрөн дээрээ буцааж тавин

Чи надад их таалагдаж байна шүү, Жо хэмээн эрхлэнгүй

хэллээ. Чи ч гэсэн надад таалагдаж байна гэж хүү амыг нь дагуулж хэлснээ тэр дор нь үгээ сэтгэлийнхээ угаас хэлээгүйгээ мэдрээд чих рүү нь үнслээ. “Би хөлөрч байна. Гэхдээ... Одоо аравдугаар сар болж байхад би хөлөрч байдаг. Удахгүй бүр бүтэж үхэх нь. Энэ охин намайг багалзуурдаж алах нь ээ”. Надад буржгар хар үстэй хөвгүүд их таалагддаг гээд охин түүний үсийг энхрийлэн илж хэллээ. “Би ингүүлэх ёстой дургүй. Ээж бас урд нь яг тэгдэг байсан”

гэж тэр бодлоо. Машины хаалга руу гараа дахин явуулаад

Жаахан зугаалъя гэж санал болголоо. Мэдэхгүй юм аа. Аюулгүй биз?

– Түүний хар нүд сэтгэл догдолсноосоо болж гялалзаж байлаа. Тэрбээр мөрөө хавчив.

Би ч гэсэн энд өдөр бүр ирээд байдаггүй шүү дээ.

РейнерсПойнт бол Централ Хай сургуулийн хүүхдүүдийн болзоонд ирэх дуртай газар байлаа. Нарийхан зам өндөр хадат цохионы ирмэгийн дэргэдэх зүлэгтэй ойн цоорхой руу ирдэг байлаа. Цаашаагаа ой мод шигүү ургажээ.

Эргэн тойронд нам гүм, зөвхөн моддын дунд салхи зугаална.

Явья гээд тэр охины гарыг атган дуудав.

Би чамайг хамгаална. Кенди хөхрөв. Залуу машины хаалгыг түлххэд тэр хоёрыг нүд гялбасан шар гэрэл бүрхлээ. Хүлээж бай, Жо. Охин тонгойсноо машины шалан дээрээс ямар нэг зүйл авав.

– Чи хэтэвчээ унагаачихлаа. А, баярлалаа гээд гараа сарвайснаа хэтэвч нээгдэж байгааг ажив. Дараа нь охины нүд том болохыг харлаа. Кенди түүний жолоочийн үнэмлэхийг харж байна.

Жо? хэмээн тэр асуусан байдалтай харлаа. “Эхэллээ дээ” гэж залуу бодоод түүний зүрх хүчтэй цохиллоо.

Охин түүний жолоочийн үнэмлэхийг дахин харснаа Жо Хож. Чи чинь өөрийгөө Жо Хож гэдэг гэсэн шүү дээ. Гэтэл жолоочийн үнэмлэх дээр чинь Лонни Мейес гэж бичсэн байх юм.

Энэ миний үнэмлэх биш ээ, гэж тэр бувгнав. “Яагаад надад агаар дутагдаад байна? Яагаад би бүтэх гээд байна? Хаалга онгорхой байтал би бүтэх гээд л байх юм. Намайг битгий багалзуурдаад байгаач, Кенди. Чамд хэллээ шүү. Бүү ингэ!”

Охин урт хүрэн үсээ арагш нь болгосон боловч үс нь буцаад л хуучин байснаараа болчихлоо. Харин нүүрэн дээр нь түгшүүр тодров.

Гэхдээ энд чиний цээж зураг байна шүү дээ гэж тэр жолоочийн үнэмлэхийг урд нь үзэж байгаагүй юм шиг түүнд харууллаа.

Залуу санаа алдлаа. “Ямар ичгүүртэй юм бэ. Яагаад намайг багалзуурдах гээд байга юм бэ? Яагаад намайг буруутгаад байгаа юм?” гэж тэр бодлоо.

Би үнэмлэхээ гээчихсэн юм гэж тэр үнэмлэхээ булааж авангаа хэллээ.

Тийм болохоор л би үүнийг хэрэглэж байгаа юм.

Тэр хэтэвчээ хүрэмнийхээ халаас руу чихчихэв. Тэгвэл чи Жо Хож юм уу? Чи Лонни Мейес

биш юм уу? хэмээн Кенди духаа үрчийлгэн шалгаасаар байлаа. Ямар гутамшиг вэ? хэмээн хүү бодлоо. “Гутамшиг, гутамшиг, гутамшиг” Тэр хаалгаа дэлгээд машинаас гарав. Босоод гараа хүрэмнийхээ халаасанд хийснээ суниалаа. Дараа нь гүнзгий амьсгаа аваад машин луу тонгойн охин өөд тайвшруулсан байдалтайгаар инээмсэглэлээ. За алив, Кенди! Жаахан зугаалья. Ялимгүй жаахан. Энд ямар сайхан байна. Тэгээд энд өнөөдөр хэн ч алга. Ойр орчимд ганц ч хүн алга. “Ганц ч хүн алга” хэмээн тэр дотроо давтаж хэллээ. Толгой дотор зүсэн бүрийн бодол орж ирээд, булчингууд чангарч байв. “Хэдэн бээр газарт ганц ч хүн алга”. Гэнэт тэр сэртхийгээд явчихлаа. “Яг тохиромжтой үе”. Охин машинаас гараад хаалгыг нь тас хийтэл нь хаалаа. Машины гэрэл унтарч тэр хоёрыг түнэр харанхуйд үлдээлээ. Залуу болгоомжтойгоор том том алхлан ойн цоорхойн цаана гарлаа. Өндөр ургасан зүлэгний шүүдэр гутал дээр дусалж байна. Хадан цохионы ирмэгт ирж зогсоод доошоогоо харав. Кенди ойртож ирэд хажууд зогссоноо гараас нь барилаа.

Түүний алга нь бүлээн, чийгтэй юм шиг байв. Нүдээ доошлуулж доошоогоо харснаа:

Буцацгаасан нь дээр юм биш үү! Би өндрөөс айдаг юм гэж шивнэн гуйлаа.

Тэгэлгүй яахав гэж хүү хариулаад, Кендигийн гарыг чанга атган зүлгэн дээгүүр ой мод руу хөтөлж аваачив. “Ямар ичмээр юм бэ. Ямар ичмээр юм бэ?”.

Чи хэдэн настай вэ? гэж гэнэт тэр асууснаа өөрөө өөртөө дотроо “Би хорьтой” гэж сануулав.

Арван долоотой, гэж тэр хариуллаа. Гэхдээ чи яаж яваад жолооныхоо үнэмлэхийг хаячихсан юм? Аваар осолд орсон юм уу, эсвэл өөр ямар нэг юм болсон юм уу?

“Харин чи ч ёстой жинхэнэ аваар осолд орно доо. Гай дагуулсан осолд. Уг нь чи намайг багалзуурдах гэж оролдсоны хэрэггүй байсан юм даа. Үс чинь... түүнийхтэй адилхан бараан өнгөтэй байсан нь ямар харамсалтай юм бэ” гэж залуу бодлоо”. Тэрбээр чангаар:

Үгүй ээ, зүгээр л хаячихсан юм гэлээ. Дараа нь охиныг модны доор аваачин мөрөн дээр нь гараа тавьж өөр лүүгээ татаад чихэнд нь:

Чи надад таалагддаг шүү, Кенди хэмээн шивнэн хэлээд түүний үснээс жүржний үнэр ханхалж байгааг дахин мэдэрлээ. Энэ охин үнэхээр түүнд таалагдаж байгаа юм болов уу? Түүнд худлаа хэлсэн юм болов уу? Үүнийг тэр яг сайн мэдэхгүй байлаа. Зөвхөн нэг юмыг л мэдэж байлаа. Охин үхэх гэж байгаа нь гутамшигтай байна. Жинхэнэ гутамшиг.

Хэдэн хормын дараа хөвгүүн машин луугаа аажуухан эргэж ирлээ. Ганцаараа. Түүний зүрх галзуу мэт цохилно, гэхдээ түүнд маш сайхан санагдаж байлаа.

“Хамаг зүйл маш сайхан боллоо. Түүнийг алах нь ямар хялбархан байваа”.

Савхин хүрмээ товчлоод залуу жолооны ард суув. Машин дорхноо аслаа. Халаагуураа асаагаад салхины шилэн дээр тогтсон цанг арилтал нь хүлээж суулаа. Дараа нь гэнэт чанга инээв.

Хөнгөмсгөөр. Сэтгэлд хөнгөхөн болохоор хүмүүс ингэж инээдэг дээ.

Цантсан цонх гийж эхлэв.

Жо Хож, хэмээн тэр чанга хэллээ. Би түүнд намайг Жо Хож гэдэг гээд хэлчихсэн юм.

Жинхэнэ нэрээ хэлж яах юм? Эцсийн эцэст энэ бол анхны болзоо байсан шүү дээ.

Анхны болзоо. Уг нь өнөөдөр алахгүй байсан юм. Тэр охин таалагдаж байсан. Жинхэнээрээ таалагдаж байсан юм. Үгүй гэхэд бусадтайгаа адилгүй байсан. Үс нь л тийм байгаагүйсан бол. Урт хүрэн үс. Тиймээ, энэ удаагийн болзоонд залуу тийм ч бэлэн биш байлаа. Гэхдээ тэр яагаад багалзуурдах гээд байсан юм? Яагаад үсээ тэгж хойшлуулаад байсан юм? Яах гэж хүний жолооны үнэмлэхийг нээж харах хэрэгтэй байсан юм? Яах гэж тийм олон юм асууж шалгаагаад байсан юм? Тэгээд амьсгалах бололцоо яагаад өгөхгүй байсан юм? Үгүй, тэр бэлэн биш байлаа. Урдаас бэлтгэлээ хангах дуртай байсан хэдий ч.

“За яахав, одоо тэртэй тэргүй тэр үхчихсэн юм чинь. Түүнийг олдох үед нь би энд аль хэдийн байхгүй байна гэж залуу шийдлээ. Би энд ямар ч мөр үлдээгээгүй. Энд хэн ч байгаагүй. Надад ямар ч муу юм тохиолдохгүй гэж найдхаас даа. Үгүй ядаж одоо би чөлөөтэй амьсгалж болохтойгоо боллоо”.

Салхины шил цэвэр болжээ. Залуу урд талынхаа чийдэнгүүдийг асаагаад ухран зам дээр гарлаа.

“Өөр хот руу явъя. Тэртэй тэргүй цааш нь явах хэрэгтэй шүү дээ”.

Энэ нь тийм ч аятайхан санагдахгүй байлаа, гэхдээ ямар түүнд өөр сонголт байгаа биш дээ? Охидууд биеэ ингэж авч явж байхад ямар сонголт байх юм? Асуулт тавина. Амьсгаа авах боломж өгөхгүй.

Машиныхаа арааг “паркинг” дээр тавьж зогсоочихоод тэр нээлхийг онгойлголоо. Гар чичрэхгүй байна. Энэ ч сайн тэмдэг шүү. Тэр дахиад амьсгалж чадаж байна, гар ч чичрэхгүй байна.

Дараа нь гэрэл асааж замын газрын зураг гарган ирээд шийдэмгий гараар түүнийг болгоомжтой дэлгэв. Нүдээрээ түргэн гүйлгэж хараад Шейдисайд хэмээх ойролцоох хот дээр хараагаа тогтоолоо.

Хэд хэдэн удаа аяархан боловч тодоор: “Шейдисайд. Энэ л надад хэрэгтэй юм шиг байна” гэж хэллээ. Дараа нь үнгэгдэж үрчийсэн газрын зургаа байранд нь хийгээд, толгой дээрхи гэрлээ унтраачихаад араагаа “драйв” дээр тавиад хаазаллаа. Машин байрнаасаа хөдөлснөө сэрүүхэн, намуун шөнө дунд уусан алга боллоо.

## 2-р бүлэг

Саксофоноос муухай огцом, майлсан дуу гархад Челси Ричардс зэмсгээ дургүйлхан өөрөөсөө түлхэв.

Ийм амьдралаас би бүр залхаж гүйцлээ хэмээн тэр хайхрамжгүйгээр хэлэв.

Битгий л эхлээрэй дээ гэж ээж нь жижигхэн зочдын өрөөний цаад булангаас захин хэлж байна. Тэрбээр Челси өөд “Чиний наад байнгын гомдоллож хэлдэг урт жагсаалыг чинь сонсож байх хүсэл алга” гэж хэлэх харц чулуудаж болохуйцаар л сонингоо доошлуулжээ.

Челси саксофоныхаа товчлууур дээгүүр хуруунуудаараа гүйлгээд сууж байсан эвхдэг зөөлөн сандал дээрээ тонгойгоод нотныхоо тавиурыг толгойгоороо мөргөчихлөө.

Заримдаа би энэ гэр бүлийн гишүүн биш юм шиг санагдах юм хэмээн ээжийнхээ үг, харцыг үл тоомсорлон гомдоллож байлаа.

Намайг үрчилж авсан юм шиг л санагдах юм. Үрчилж авсан биш, өндөгнөөс гаргаж бойжуулсан юм хэмээн хатагтай Ричардс доогтойгоор хэлснээ дахиад л сонингийнхоо араар ороод нуугдана. Наад юман дээрээ тоглоод дуусчихлаа гэж найдаж болох нь уу? Намайг саксофон тоглоход та яасан дургүй юм бэ? хэмээн Челси буруутган хэлэхэд Саксофон дээр тоглох гэнэ шүү? Үгүй чи чинь саяхан л наадхыгаа элэг барьж доромжилж байсан биш үү? хэмээн хатагтай Ричардс хэлснээ инээв. Челси ээжийнхээ даруу төлөв хошигноход дассан байлаа.

Ингэх нь заримдаа түүний муухай аашлахыг засдаг байсан боловч энэ удаа тэгсэнгүй.

Хөгширч байгаа юм байлгүй дээ, тийм үү? хэмээн ууртай хэлээд “Ээжийн аятайхан гадаад төрх, тэгэх тусмаа түүний алиа хошин ааш зан нь ч надад байдаггүй хэмээн харуусан бодлоо. Дараа нь хөгжмийнхөө амгайвчийг сугалж аваад шүлсийг нь үлээж гаргаснаа:

Хэрэв намайг үрчилж аваагүй юм бол яахаараа та ийм өндөр чөргөр, харин би ийм тажгар бүдүүн байдаг билээ? гэхэд

Челси, болиоч! хэмээн эх нь уурлан дуу алдав. Сонингоо өвөр дээрээ буулган тавьснаа яахаараа чи нэг л юмаа давтаад байдаг юм бэ? хэмээн толгойгоо сэгсрэн хэллээ.

Гэхдээ яриа болж байгаа биз дээ гэж Челси улам бүр цухалдан эрс тас хэлэв. Голдуу бид бие бие рүүгээ яншиж яншиж байснаа дараа нь та ажил руугаа гүйгээд явчихдаг.

Охин минь, чи ч өнөөдөр түмэн зүйлд гомдоллож байх шив дээ гэж эх нь баталж хэллээ. Өршөөж хайрла гэхдээ эцэг бид хоёр чинь их ажиллах хэрэгтэй байдаг. Чи өөрөө наад саксофоноороо тоглоод бөөн мөнгө олдоггүй биз дээ.

Тийм л дээ, гэхдээ би аавын зоогийн газар ажиллаж хэрэгцээнийхээ мөнгийг олдог шүү дээ хэмээн Челси зөрөв. Тэгээд саксофоноос болж над руу дайрч давшлаад байхаа боль. Энэ чинь



надад баяр баясгалан авчирдаг цорын ганц зүйл. Тэгээд дотроо бас дахин “Цорын ганц. Золгүй амьдралын маань цорын ганц зүйл” гэж давтан хэллээ.

Хаанаас чи сүүлийн үед ингэтлээ өөрийгөө өрөвддөг болоов? гэж хатагтай Ричардс сонирхож асуугаад сонингоо кофены жижиг ширээн дээр тавиад охин луугаа дөхөж очлоо.

Хамгийн гол нь энэ шинэ хотод байгаа юм. Шейдисайдад. Тэгээд бас энэ хуучны, аймшиг төрүүлсэн байшинд.

Байшингаа голохоо болиоч гэм. Бид засвар хийчихнэ гэж хатагтай Ричардс уран гоолиг гараа өндөр захтай битүү цамцныхаа өмнө зөрүүлэн бариад Эцэг чинь өөрийн гэсэн зоогийн

газартай болох гэж хичнээн мөрөөддөг байсныг Челси, чи өөрөө мэдэж байгаа шүү дээ. Ийшээгээ нүүж ирсэн нь бидний өмнө өргөн боломж нээж өгч байгаа. Бидний бүгдийнх нь өмнө гэж хэлэв.

Хүүхдүүд сургууль дээр Аймшгийн энэ гудамжны тухай янз бүрийн юм яриад л байх юм. Энд янз бүрийн үл ойлгогдох зүйл болдог гэж баталдаг.

Үл ойлгогдох зүйл хаа сайгүй л болдог шүү дээ гэж ээж нь хөндийдүү хэлсэнээ цонх руу харлаа. Цаана нь армаг тармаг үүл хөвж харагдана. Өдөр дундын нар арайхийн цонхоор шагайна.

Челси зэмсгээ задалж дууслаа. Болгоомжтой гэгч нь гэрэнд нь, байр байранд нь шигтгэж хийгээд хаав.

Яагаад миний үс таных шиг шулуун биш юм бэ? гэж зогсох хэрэгтэй гэдгээ ойлгож байсан хирнээ яаж ч чадахгүй шаардангуй асуулаа. Яагаад миний үс ингэж долгионтоод, хаанаас ийм муухай хулганых шиг хүрэн өнгөтэй байдаг байна?

Үснийхээ өнгийг өөрчлөх гээ юу? Энэ чинь юухан байхав хэмээн хатагтай Ричардс гайхав.

Тэгвэл би нүүрээ яах юм? гэж Челси толь руу харж хашгираад тэрбум дахь удаагаа: Хамар маань хэтэрхий өргөн, эрүү дэндүү богинохон юм” гэж магадлан бодлоо.

Челси, чи чинь маш аятайхан охин шүү дээ гэж гараа урдаа зөрүүлсэн хэвээрээ эх нь хэлэв. Жаахан жингээ хасаад л уруулаа бага зэрэг будчихвал...

Челси ой гутран хашгираад сандал дээрээсээ босон харайв. Эх нь айгаад алхам ухарлаа.

Боль доо, ээжээ! Намайг аятайхан гэж л битгий хэлээрэй. Та дандаа л огт аятайхан биш хүмүүсийн тухай тэгж хэлдэг шүү дээ. Зүгээр л намайг сайхан сэтгэлтэй охин гээд хэлчих, тэгээд хоёулаа үүгээр дуусгавар болгоё. Царай муутай хүмүүсийн тухай л ингэж хэлдэг дээ. Бүгдээрэнг нь сайхан сэтгэлтэй гэж.

Минийхээр бол чи гайхамшигтай л харагдаж байна шүү дээ. Гэхдээ наад аашнаас чинь болж би солиорох нь гэж хатагтай Ричардс хошин шогийн жүжигчинг дуурайж хэллээ.

Ээж ээ! гэж орилохдоо Челси биеэ барьж чадахгүй байгаагаа ойлгож байв. Та хэзээ нэг тоглоом хийхээ болих юм бэ?

Хатагтай Ричардс ойртож ирээд охиноо эв хавгүйхэн тэвэрлээ. Ингэх нь огт санаанд оромгүй байлаа. Ээж нь хэзээ ч сэтгэл санаагаа нээн дэлгэж сураагүй билээ. Челси хэзээ сүүлчийн удаа ээждээ тэврүүлж байснаа санаж чадсангүй.

Уучлаарай, ээж ээ гэж хэлэхдээ Челси яагаад уучлалт гуйж байгаагаа ойлгож өгөхгүй байв.

Ш – ш – ш. Хатагтай Ричардс түүний уруулд хуруугаа хүргээд алхам ухарлаа. Хамаг буруу нь газар солигдсоноос л болж байгаа юм, хайрт минь гэж тэрбээр охиныхоо нүд рүү хараад тайвшруулах гэж оролдон хэллээ.

– Шинэ хотод хамаг бүхнээ шинээр эхлэх болдог юм. Шинэ сургуульд ч бас адилхан. Тийм болохоор л чи ийм... ууртай байгаа юм.

Челси эжийнхээ үгийг тунгаан бодож толгойгоо дохино.

Чи ч бас аавыгаа хамаг цагаа зоогийнхоо газар өнгөрөөж, чамтай хамт гэртээ сууж байхынхаа оронд би ч гэсэн эмчлүүлэгч нартайгаа эмнэлэгт байх болохоор дургүйцэж байгаа биз. Гэхдээ яах ч арга алга, Челси. Бидэнд дахиж ийм боломж олдохгүй. Ялангуяа аавд чинь. Зоогийн газар орлого орж эхлэх юм бол тэр баярлана даа. Тэгээд бид өрнөөсөө салж чадна. Хатагтай Ричардс гараа жинснийхээ халаасанд шургуулан жижигхэн өрөөн дотуураа нааш цааш нь холхин байж нэмэн: Тэсч үз. Би өөр юу ч гуйхгүй. Өөрийнхөө байж байгаа байдал, нүүх шаардлагатай болсонд гомдоллосны хэрэггүй. Гэхдээ өөртөө бүү эргэлз гэв.

Челси дахин нэг толь руу харснаа “Танд хэлэхэд амархан байлгүй яах юм. Та бол өндөр, царайлаг. Гэтэл би яг үнээ шиг” гэж бодсоноо

За, ээж ээ. Таны зөв. Уучлаарай хэмээн хуурамчаар хөгжилтэй царай гарган хэллээ.

Эх нь нүүрэн дэх түгшүүрээ нууж чадалгүй

Чи өөрөө нэг сайн найзтай болсон биз дээ, тийм үү? гэхэд Челси толгой дохин

Нина Дарвин гэв. Чи түүн лүү утасдвал яасан юм? гэж ээж нь санал болголоо.

– Сайхан сэтгэлтэй хүүхэд бололтой байсан. Түүнийг бүгдээрээ танина. Нина заавал чамайг бусад хүүхдүүдтэй танилцуулаад өгнө гэснээ цагаа хараад

– О, аймшигтай юм! Би хожигдож байна. Гүйхгүй бол болохгүй нь. Ээж нь Челсигийн духанд шүргэн алдаж хурдхан шиг үнсчихээд, түлхүүр хэтэвчээ аваад гэрээсээ гүйн гарлаа.

Челси санаа алдсанаа: Ээжийн зөв шүү. Өөрийгөө өрөвдөхөө болих хэрэгтэй хэмээн шийдлээ.

Тэрбээр саксофоноо өрөөндөө аваачиж шүүгээндээ хураав. Дараа нь гэнэт халуун, эвгүй

санагдсан биеийн тамирын битүү цамцаа тайлчихаад арай дэгжин хувцас хайж эхэллээ. Хайрцагнаас шар ногоон өнгөтэй богино ханцуйтай цамцаа гарган ирж байхдаа: “Би зүгээр л гэрээсээ гарах хэрэгтэй юм байна. Нинатай уулзвал хөгжилтэй болж магадгүй” хэмээн сэтгэлээ.

Нина Дарвин тэдний гэрээс арван минут алхаад хүрэх газар амьдардаг билээ. Челси түүнтэй Шейдисайд хотын явуулын найрал хөгжмийн бэлтгэл хийж байх үед танилцсан юм. Хамаг зүйл огт санамсаргүй болсон.

Үүнээс илүү зугаатай уулзалт гэж юу байхав. Нина лимбэ, Челси саксофон тоглож яваад ташуурч мөргөлдчихсөн. Челсигийн хөгжим ялимгүй хонхойж, Нинагийн өвдөг бага зэрэг шалбарч билээ. Хэрэв түүнийг тооцохгүй бол хоёулаа гэмтэж бэртсэнгүй, гол нь сайн найз болж авсан. Дараагийн бэлтгэлүүдийн үеэр Нина шинэ найзаасаа холхон шиг алхдаг болсон хэдий ч тэрбээр хөгжилтэй ааш зантай, нимгэн цэвэр царайтай, намхавтар нуруутай цайвар үстэй охин билээ.

Заримдаа Челси: “Түүнийг харахад арван хоёртой гэмээр юм. Бид хоёрыг хамт байхад хүмүүс аягүй бол намайг ээж нь гэж боддог байхаа!” хэмээн боддог билээ. Челсиг бодвол тэр арай нүүрэмгий байсан бөгөөд сэтгэлээр унадаггүй, маш олон найзтай юм шиг байсан.

Тэсч үзээрэй. Нина сайн найз. Шейдисайдад ирээд найзалсан цорын ганц охин хэмээн Челси ээжийнхээ зөвлөгөөг дагахаар шийдэн өөртөө чангаар хэллээ. Тэгж бодсоноо өөртөө: Тийм болохоор түүнийг гоочлох гэсний хэрэггүй шүү гэж захив.

Нинагийнх руу очиж явах замдаа Челси сэтгэл сэргэж байгаагаа мэдэрч байлаа. Намрын цэлмэг өдөр байсан бөгөөд агаар хуурай, тунгалаг мэт байлаа. Модон дээрхи навчис дөнгөж шаргалтаж эхэлж байна. Аймшгийн гудамжин дахь зарим байшин хуучирч навсайсан харагдах боловч хүүхдүүдийн хов жив болгож ярьж байсан шиг муу ёрын биш санагдаж, айдас төрөхгүй байлаа.

Нинагийн амьдардаг гудамжинд Челсигийн хажуугаар дотор нь радио чанга орилсон, онгорхой цонхтой машин өнгөрөв. Зорчигчдынх нь дунд сургуулийнхаа зарим хүүхэд байхыг танилаа. Тэд нар инэлдэж дуулалдаад түүнийг огт анзаарсангүй бололтой.

Нинагийн амьдардаг эдлэн маягийн урт улаан тоосгон байшин нилээн эгц налуу замтай ойн цоорхойд байдаг. Намар болсон хэдий ч тэр хавийн зүлгийг саяхан тэгшилж зассан байлаа.

Челсиг төв хаалга руу очиж амжаагүй байтал онгойлоо. Нина, араас нь түүний найз Дуг Фредерикс хэмээх урт шаргал үстэй өндөр царайлаг хөвгүүн гарч ирэв. Түүний инээмсэглэл найрсаг, дур булаам байв.

Нина гайхаж амаа ангайлгав:

Челси! Чи хаанаас гараад ирвээ?

Гэрээсээ хэмээн тэр гараараа зангаж хаанаас ирснээ үзүүллээ. Сайн уу гэж, Дуг хэлээд

Нинаг түлхэж давхар шилэн хаалга хаав.

Би мэдсэнгүй... гээд Нинаг эхэлтэл түүнийг Челси таслан би утасдах хэрэгтэй байсан юм гэв. Бид нар яг Дугийн үеэлийнд очих гэж байна гэж Нина тайлбарлав. Бидэнтэй хамт явах уу? Хамт явья! гэж Дуг гялалзсан улаан “Тойота” руу алхангаа түүнийг дэмжиж Челсиг гараараа даллан.

– Бид нар жаахан чалчиж, сайн идэж авах гэсэн юм гэв. Би чадахгүй нь ээ. Баярлалаа. Дараа ирье гэж Челси хэллээ. За тэгээрэй хэмээн Нина мөрөө хавчина.

– Хэзээ ч хамаагүй ирээрэй. “Тэдэнтэй хамт яваач” гэж дотоод дуу хоолой нь Челсид хэлсэн боловч тэр дор нь “Тэнд олон хүн байна ш дээ” хэмээн зөрлөө. Тэгснээ сонсогдохоор чанга

Үгүй дээ, надгүй явцгаа гэв. Дуг машиндаа суугаад амжчихсан дуут дохиогий нь дарж байлаа. Нина замаар түүн лүү гүйж очив. Тэгээд хэдэн хоромын дараа Челси хөдөлж байгаа машиныг нь харцаараа үдэж байлаа. Гэртээ харих замдаа тэрбээр дахиад л өөрийгөө өрөвдөж эхэллээ. “Дугийг дохио өгөнгүүт л гүйгээд оччихож байгаа юм даа хэмээн харуусан бодож байлаа.

– Гэхдээ хэрвээ би найз залуутай байсан бол бас л тэгж гүйх байсан байлгүй. Найз залуутай болох сайхан шүү! Болзоонд явж үзэх юмсан! Би арван тавтай хирнээ ганц ч удаа болзоонд явж байсангүй.”

Гэтэл Челси ардаа машин тормослохыг сонслоо. Тэр цочин зогтусав. Машинаас нэг эрэгтэй хүүхэд Хүүш, болзооны тухай тохирох юм биш үү? гэж хашгирлаа.

### 3-р бүлэг

Челси огцом эргэж харвал хар “Хонда” дотор инээмсэглэсэн дөрвөн залуу сууж байлаа. Жолоочийн хажууд сууж байсан залуу олс шиг хүрэн үсээ ардаа адууны сүүл адил зангидаж боосон байлаа. Чихэнд нь гялалзсан ээмэг ёрдойж байна. Тэр залуу гараа машиныхаа онгорхой цонхоор охиныг барьж авах гэж байгаа мэт цухуйлган сарвайлаа.

Болзох юм биш үү? Машин өсгий дайрчих шахан дагаж байлаа.

Тэгээд яахав? Болзох юм биш үү?

Энд сул зай зөндөө их байна гэсэн өөр дуу сонсогдоно. Машин дотор сууж байгаа хүүхдүүд чанга инээлдэв. Челси алхаагаа түргэсгэлээ. Залуусын нэг нь чангаар үнсэж байгаа дуу гаргахад бусад нь дахиад л хөхрөлдлөө.

За алив! Бид нар ёстой догь хөвгүүд байхгүй юу, гэж нөгөөх үсээ адууны сүүл шиг боосон залуу гараа цонхноос авалгүй маасайн хэлнэ.

Бид нар гайхамшигтай хөвгүүд. Үнэхээр шүү, гэж арын суудлын залуу хашгирав.

Чи ч гэсэн догь охин гэж мөрийцөхөд бэлэн байна гэж хэн нэг нь түүнийг дэмжлээ. Дахиад л хөхрөлдөөн болов. Челси ууртайгаар эргэж харлаа. Тэрбээр хөвгүүд рүү харан

Намайг зөнд нь орхиоч, гэж шаардав. Чи тийм ч их найрсаг биш юмаа даа! Яагаад бидэнтэй найзлахгүй байгаа юм? гэж хөвгүүдийн нэг нь хэллээ. Машин дотор дахиад л хөхрөлдөөн болов.

Би та нарт урдьчилж хэллээ шүү... гээд Челсиг эхэлтэл жолооны ард сууж байсан нь:

Хараач, наадах чинь уурлаж байна гэж ажиглан хэллээ. Энэ ч нөхөрсөг биш байна шүү гэж бас нэг нь хажуунаас нь хэлж байна. Челси зүрхээ солиотой юм шиг дэлсэлж байгааг мэдэрлээ. Айхаасаа илүү уурлаж эхэлж байлаа. Тэд нар түүгээр зүгээр тоглоом хийж байгаа юм болов уу, эсвэл муу юм хийх гэж байгаа юм болов уу? Тэгээд эцсийн эцэст яваад өгөх нь үү, үгүй юу? Тэрбээр маасалзаж байгаа царайнуудыг ажиглаж харлаа. Тэд нарын хэнийг нь ч танихгүй юм байна, тэгээд ч тэд нар Шейдисайд руу яваагүй байна, энэ ч яг шүү. Алив тэгээд найзлая л даа гэж нөгөөх олс шиг үстэй залуу гараа сарвайсан чигээрээ гуйлаа. Жолооч нь бүр түүнийг бариад аваг гээд машинаа зогсоогоодхов. Үгүй! гэж охин түүнээс мултран хашгирлаа.

– Намайг зөнд нь орхиоч! Би тоглоогүй байна шүү! Хөвгүүдийн нэг нь Челси руу асаалттай янжуур чулуудлаа. Тэр нь түүний пүүз дээр ойчив. Охин хөлөөрөө янжуурыг өшиглөчихөөд гүйлээ.

Араас нь чанга, харгисаар инээлдэх сонсогдно.

“Адгууснууд. Жинхэнэ адгууснууд” гэж үглэн тэр бутнууд, намхан хашлагын чигт гүйлээ.

Гэхдээ амьсгаадан амаараа чанга чангаар агаар залгилахдаа араасаа хөөж байна уу хэмээн чих тавьж байлаа.

Гэвч жижигхэн машин хэд хэдэн удаа чагнаалдсанаа арилаад өгөв.

Челси амьсгаагаа дарах гэж зогслоо. Хөл нь чичирч, зүрх нь цээжнээсээ үсрээд гарах гэж байлаа. “Хонда” машин тормосоо хяхтнуулан булан тойроод явахыг хараад тэрбээр тайвширсан боловч бас өөрийгөө бүтэлгүй амьтан гэж нэрлэнэ.

“Надтай ямар нэг сайхан зүйл тохиолддог ч болоосой! Би өөртөө таалагдсан залуутай уулзах юм сан...” хэмээн тэр мөрөөдөж эхлэв.

Шейдисайдын сургуульд шинээр ирсэн сурагчийг түүний хажуугийн, арын эгнээний суудалд, хаягдал цаас хийдэг сагсны дэргэд суулгалаа. Тэнд ангийн ганц сул суудал байсан юм.

Челси түүнийг ширээнүүдийн урт эгнээгээр явж байхад нь бага зэрэг ажиж авсан билээ. Тэр хүү өмнөө үүргэвчээ бариад хэн лүү ч харахгүйг хичээн түргэн түргэн алхалж байлаа. Тэр савхин хүрэмтэй байв. “Түүнд одоохондоо шүүгээ гаргаж өгөөгүй юм байна” гэж Челси бодлоо.

Дунд зэргийн нуруутай, хар нүдтэй, буржгар бараан өнгийн үстэй хүү байна. Суухдаа хажуу дахь охин луугаа ичингүйрэн инээмсэглэхэд тэрбээр түүний биенийхээ бусад хэсгээс илүү хөгжсөн том харагдах хүчтэй, булчинлаг гарыг ажиглав.

Өөрийгөө ажиглах Челсигийн анхааралтай харцыг хараад шинэ сурагч толгойгоо түүн лүү ичингүйрэн эргүүллээ:

Уилл Блейкли. Ноён Картер ангид түүнийг яг тэгж танилцуулсан билээ. Челси түүнийг нууцаар харсан чигээрээ “Дажгүй юм аа хэмээн дүгнэлээ. Түүний хар нүд шал ширтсэн хэвээрээ, хацар нь ягаарна. “Тэгээд бас ичимхий юм шиг байна” гэж шийдэв. Тэрбээр түүнд “Сайн уу”, эсвэл “Тавтай морил” ч юм уу нэг тиймэрхүү юм хэлэх гэсэн боловч зүрхэлсэнгүй. “Би ч гэсэн ичимхий. Бурхан минь, ичимхий байх ямар дургүй хүрмээр юм бэ!” хэмээн Челси бодлоо.

Ноён Картер өглөөнийхөө зарлалуудыг ердийнх шигээ түргэн түргэн хэлж уншиж байна. Хором хиртэй зарлалуудтай хуудсаа цааш нь тавиад сул суудал хайж ангиа тойруулан харлаа.

За ингээд бүгдээрээ байр байрандаа, бүртгүүлсэн гэж хэлээд журнал дээр ирц бүртгэхэд нүдний шил нь урт хамрынх нь бүр үзүүрт гулсаж хүрлээ.

Өнөөдөр гал командынхны хичээл сургалт болно гэсэн. Хүүхдүүд та нарт маш таалагдана гэж бодож байна.”

Ноён Картер хошин шог зангүй билээ. Гэхдээ түүний хичээл дээр бүгдээрээ чанга ярилцаж, инээлддэг болохоор түүний ярьж байгааг ойлгоход бэрх байдаг.

Эхний цаг дуусч байгааг мэдэгдсэн хонх дуугарлаа. Челси Уилл руу зэрвэсхэн харсан боловч

тэрбээр нүдээ буурууллаа. Унтууцсан байдалтай үсээ илсэнээ сандал дороосоо үүргэвчээ татаж гаргав.

Челси босоод үүргэвчнийхээ мөрөвчийг үүрэх гэсэн боловч цочсондоо болоод хашгирчихав. Дэвтэр, ном, өдрийн хоол нь газраар нэг асгарчихлаа. Бор цаасан уут нээгдээд сэндвич, алимнууд газраар өнхөрнө. Үүргэвчнийхээ цахилгаан товчийг хаахаа мартсан байжээ.

Чангаар санаа алдаад Челси тонгойн юмнуудаа хамж эхлэв. Гайхалтай нь Уилл үүргэвчээ газар тавиад туслахаар хажууд нь тонгойлоо.

Ямар мангар юм болов оо тиймээ? гэж охин арайхийн хэлэв.

Уилл инээмсэглэлээ. Хацар нь урьдынхаасаа илүү ягаарсан харагдана. Тэр сэндвичийг нь буцааж цаасан уутанд хийчихээд өгөв.

Секунд хиртэй тэр хоёрын харц тулгарлаа. Уилл тэр дор нь нүдээ буруулав.

Энэ ч надаас илүү ичимхий юм гэж Челси дүгнэлт хийлээ. Дараа нь өөрийн эрхгүй түүний хүчирхэг булчингуудыг харж байгаагаа мэдээд даруйхан харцаа бууруулав. “Ямар нэг юм хэлээч. Үгүй чи ямар нэг юм хэлээч” гэж өөрийгөө загналаа.

Тусалсанд чинь баярлалаа, гэж арайхийн хэлэх үгээ олов. “Ёстой догь! Ямар гоё үг вэ!”

Уилл мөрөө хавчсанаа зориг муутайхан инээмсэглэлээ. Дараа нь үүргэвчээ аваад эргэж харахгүйгээр үүд рүү яаравчлав.

“Ичимхий байх ямар муухай юм бэ хэмээн Челси өөрийгөө зэмлэсээр байлаа. – Гэхдээ би өөрийгөө яаж ч чадахгүй юм.

Өөр охин байсан бол ямар нэг ухаалаг юм бодож олоод хошин үг хэлэх байсан юм. Нина ч лав түүнийг нулимсыг нь гартал инээлгэх байсан даа. Уиллыг юм хумаа ч авч амжаагүй байхад түүнийг уулзах гээд тохиролцуулчихсан л байгаа. Гэвч би яахаараа Нина шиг биш юм бэ? Яах вэ, би маргааш түүнтэй заавал ярьж үзнэ хэмээн дүүрэн хүнтэй шуугиантай хонгил руу гарахдаа өөртөө амлалаа. Өмнө маань бүтэн өдөр байна. Түүнд хэлэх үгээ бодож олно.

Шийдвэр гаргаснаасаа болоод Челсид хөнгөрөөд явчихлаа. Тэрбээр англи хэлний хичээл рүү очиж арын эгнээнд суудал эзэлж байхдаа бүр инээмсэглэж байлаа.

Тэр орой Олд Виллижийн нэг муу гудамжнуудын нэгэнд байрлах “Бүх одод” хэмээх хэтэрхий тод гэрэлтэй давчуухан эцгийнхээ зоогийн газар ажиллаж байхдаа Челси танхимд ганцаархнаа үлдсэн байлаа. Үнэн хэрэгтээ бол энд илүү ажиллах хүч хэрэггүй байсан юм. Гэхдээ энэ удаа тогоочийн ажил хийдэг Эрни утсаар өвдсөн гэж хэлсэн болохоор голдуу лангууны ард зогсдог эцэг нь гал тогооны өрөөнд шарах зуухны өмнө дүнсгэр царайтай зогсож байлаа.

Үйлчлүүлэгч маш цөөхөнтэй байлаа. Хижээл насны хоёр хүн лангууны буланд кофе ууж байлаа. Цаанаасаа хоёрдох тасалгаанд залуу бүсгүй хоёр, харахад тийм ч аятайхан биш

сэндвич идэж кокаколагаар даруулж байна.

Челси өөрийгөө Уиллын тухай үнэхээр мөрөөдөж байгаагаа мэдэрлээ. Тэрбээр түүнд юу гэж хэлэхээ шийдчихсэн байлаа. Эхлээд түүнийг ажил хийдэг үү гэж асууна. Дараа нь Шейдисайдад хэзээ ирсэн, хаана амьдардгийг нь сонирхоно.

Хижээл насны бас нэг хүн орж ирээд өмнө нь ирсэн нөгөөх хоёртойгоо нийллээ. Тэр хүн Челсиг аяга кофе авч ир гэж захиалав. Охин аяга аваад кофе буцалгагчаас аягалж аван үйлчлүүлэгч рүү аваачиж явахдаа санаан дотроо Уиллтэй ярилцахаа бэлтгэн ярилцаж байлаа.

О бурхан минь!

Хүнд шаазан аяга гарнаас мултарч унаад лангуу мөргөн шалан дээр унахдаа хагараад хаа сайгүй кофе цацаж орхилоо.

Челси эцгийгээ гал тогооны өрөөнөөс уурлан харж байгааг ажиглав.

Би цэвэрлээдэхье гэж охин түүнд хэллээ. Дараа нь шүүр тосгуур аваад хагарсан аяганы том том хэлтэрхийнүүдийг хамж авахаар тонгойлоо.

Харин босохдоо дөнгөж орж ирсэн залуутай мөргөлдөж орхив.

Өө, уучлаарай! хэмээн цочсондоо хашгирчихлаа. Залуу инээмсэглэн

Ингэх нь надад таалагдлаа гэж хошигнов. Гаднаас нь харахад тэр арван долоо найм орчим настай бололтой. Доогтой хар нүд, өндөр шанаатай царайлаг нүүр, өтгөн хар үстэй байв... Челси түүний халаасан дээрээ мөнгөн цахилгаан товчтой савхин хүрмийг хараад “Чанга гар бололтой юм” гэж бодлоо. Хар жинсэн өмднийх нь яндан түрүүний өвдгөн дээр нь цоорхой нүхнүүд онгойно. Энгэрийг нь хагас товчилсон хүрэмний цаана “Металлик”ийн пүүсийн тэмдэгтэй богино ханцуйтай бараан улаан өнгийн цамц харагдана. Уучлаарай, би таныг ороход чинь саад болсон байна гэж хэлэн Челси зам тавьж өгөхөд тэр чанга залуу “Ёстой замыг минь хаагаад үзээрэй!” гэсэн байдалтай түрэмгий алхлан лангууны цаад булан луу очлоо. Инээмсэглэхээ больчихсон чинь нүүр нь ширүүн, шийдэмгий болчихлоо. Челси хагархай аягаа хогийн сав руу хаячихаад шинэ үйлчлүүлэгчид цэс аваачиж өгөх гэж яаравчлав. Тэр эсэргүүцэн гараа өргөснөө:

Надад юу хэрэгтэй байгааг би мэдэж байна. Зөвхөн гамбургер, кокакола хоёр л танд гамбургер яаж өгөх вэ? гэж эцгийнхээ өмсч бай гэсэн урт цагаан хормогчинд гараа арчингаа Челси асуулаа.

Чанаж гэсэн хариу сонсогдов. Челси улайж байгаагаа мэдэрлээ. Тэгээд гэнэт мэгдлээ. “Би энэ мангар хормогчтой, ардаа татаад уячихсан үстэй аягүй бол би маш мангар харагдаж байгаа байхаа. Ялангуяа энд ингэж зогсоод гамбургер яаж өгөх вэ гэж асууж байхдаа.” Тоглосон юм гэж түүнийг чанга залуу хөшсөн царай гарган тайвшрууллаа.

Челси арайхийн инээхчээн болон:



Ойлгож байна гэж хариуллаа. Тэгээд цонх руу эргэн хараад аавдаа захиалгыг нь хашгирч хэлэв. Тэрбээр толгой дохисон бөгөөд Челси халуун тогоо дээр гамбургер шал хийтэл унаад шаржигнаж эхлэхийг сонслоо. Тэгээд чи амьдрах мөнгөө яаж олдог юм бэ? гэж чанга залуу асуухад нүд нь гялалзаж байв. Челси юу хэлэхээ мэдэхгүй түүн лүү ширтэж зогсоно.

Дахиад хошигносон юм гэж тэрбээр тайлбарлалаа.

Чи ч өнөөдөр жаахан ааш муутай байх шив дээ, аа? Энд хүмүүс нэг их хошигнож тоглоод байдаггүй юм гэж Челси хэлээд алчуур авч “Формика” компанийн тэмдэгтэй лангууг арчив. Чиний нэрийг хэн гэдэг юм? Тэр яриа өдсөн янзтай нүд рүү нь эгцлэн харж байлаа. Челси. Челси Ричардс. Охин энэ бол түүний нэрийг асуусан анхны үйлчлүүлэгч гэдгийг саналаа.

Харин би бол Тим Спаркс, гэж нөгөө чанга залуу өөрийгөө танилцууллаа.

Гэхдээ бүгдээрээ л Спаркс гэж дууддаг юм. Гэнэт тэр охины гарыг атгалаа. Тэр том алгатай, гар чанга атгадаг юм байна. Тэр өөрийгөө ямар их чадалтай вэ гэдгээ аягүй бол төсөөлдөг ч үгүй бололтой.

Сайн уу, Спаркс аа гэж Челси арайхийн инээмсэглэх аядав. Тэрбээр дахиад л лангууны буланд байгаа гурван үйлчлүүлэгчдэд кофе хийж өгөв. Дараа нь Спарксын захиалгыг шалгалаа. Хараахан бэлэн болоогүй байв. Автоматаас кокакола хийгээд түүний өмнө тавилаа.

Би саяхан энд нүүж ирсэн хэмээн тэрбээр шилэн аягаа гартаа эргэлдүүлэн дахиад л түүнийг ширтэн байж хэллээ.

– Олд Виллиж руу.

Харин би Шейдисайдад сарын өмнө нүүж ирсэн, гэж Челси хариу өгүүлэв.

Тусгай өрөөнд байсан хоёр хүүхэд тооцоо хийе гэж дохио өглөө.

Энэ хот харагдаж байгаа шигээ тийм л онцгүй юм байх даа, хэмээн тэр жигшсэн байдалтай уруулаа мушилзуулан асуулаа.

Тиймээ. Тийм бололтой, гэж Челси хариуллаа. Түүнтэй ярьж байхдаа охинд нэг л тавгүй санагдана.

Спаркс алиа хошин үг хэлж байсан ч тэр нэг л тийм ширүүн, хүйтэн... бас аюултай санагдаж байлаа.

Хөөе, хоёулаа кинонд явбал яасан юм? гэж гэнэт тэр хэллээ.

## 4-р бүлэг

Юу?

Хоёулаа нэг юм хийе л дээ, гэж зүтгэсээр байлаа. Челси Спаркс руу амаа ангайн харж байлаа. Тэр энэ саналаа гэв гэнэтхэн хэлсэн болохоор бүр хэлэх үг ч олдохгүй байв. Харин тэр лангууны нөгөө талаас хариу хүлээгээд зогсож байлаа. Энэ мөчид Челсигийн мөрөн дээр хэн нэг нь гараа тавилаа. Эргээд харвал духан дээр нь хөлс бурзайсан эцгийнх нь ууртай царай харагдлаа. Тасалгаанд байгаа хүүхдүүд тооцоо хийх гээд хүлээгээд байна гэж түүний аяархан хэлэх сонсогдов. Эцэг нь биеэ барих гэхдээ дандаа ингэж ярьдаг билээ. Уучлаарай, Челси хормогчныхоо халааснаас тэмдэглэлийн дэвтэр гаргаж ирлээ. Дараа нь Спаркс руу харахад түүний нүүр нь час улайгаад хар нүд нь ууртайгаар гялалзаж байхыг харав.

Тэр ноён Ричардс руу хорсон харснаа суудлаасаа огцом босоод үүд рүү алхлаа.

Хүүе... таны гамбургер! гэж хойноос нь Челси хашгирна. Гэвч Спаркс яваад өглөө. Хаалга чанга хаагдав. “Ямар хачин юм бэ? Тэр үнэхээр намайг урьсан юм байхдаа? гэж Челси гайхна. Яагаад яваад өгөв өө? Аавын ярианы дундуур орсон нь тэгтлээ таалагдаагүй юм байх даа? Хачин л юм даа. Охин Спарксын тухай бодсон хэвээр төлбөрийн хуудас бичээд ширэн дээр хаялаа. – Тэгээд энэ нь миний анхны болзоо юм байх даа! Челси дахиад л өөрийгөө өрөвдөж эхэлснээ болиод энэ явдлын гэрэлтэй талыг бодож эхэллээ. “Үгүй, гэхдээ тэр намайг хамт явья гэж урьсан шүү. Энэ залуу үнэхээр намайг болзоонд урилаа.” Гэхдээ би түүнтэй хамт явахыг зөвшөөрөх байсан уу? Түүнтэй явах байсан уу? Тэр ч нилээн чанга харагдаж байсан шүү. Түүнээс нэг л балар эртний, харгис уур амьсгал мэдрэгдэж байсан шүү”.

Челси аавыгаа яриаг нь таслахад хэрхэн уурласан, нүдэнд нь хорсол тодорсон тухай дахин төсөөлөн саналаа.

Үгүй. Би түүнтэй явахгүй байсан. Яалаа ч гэсэн. Би түүнд “үгүй” гэж хэлэх байсан. Хэрэв чадсан бол.

Охин цонхоор гал тогооны өрөө рүү харлаа. Эцэг нь түлэгдчихсэн гамбургераа хогийн сав руу хаяж байна. Царай нь дүнсгэр байлаа.

Дахиад ахимаг насны хоёр байнгын үйлчлүүлэгчид орж ирлээ. Тэгээд сурснаараа цонхон талын тасалгааг эзлэв.

Челси тэдэнд хоолны цэс аваачиж өгөөд юу захиалахыг нь хүлээн хажууд нь гараа хормогчныхоо халаасанд хийгээд зогсоно. Тэрбээр өөрийгөө Уилли Блейкийн тухай бодсоор байгаагаа мэдлээ.

Цээжээр санаж байгаа хэдий ч тэр цонх руу харангаа дахиад л санаандаа түүнтэй ярих бэлтгэлээ хийж байлаа. Гэхдээ Уилл өөрийнх нь түүний өмнөөс бодож зохиосон тэр үгнүүдийг хэлэх үү гэдгийг мэдэхгүй байлаа. Тэгээд түүнийг кинонд урьдаг болов уу?

Уилл чи миний анхны болзоо хийх хүн болох уу? Эсвэл яг энэ Спаркс шиг яваад өгөх үү?

– Тэр ичимхий, шийдмэг бус санагдсанд

– Үгүй би ер нь түүнийг хаа нэг тийшээгээ болзоонд уривал яасан юм бэ? гэж гэнэт түүний толгойд орж ирлээ.

Энэ санаа гэнэт түүний сэтгэлийг хөдөлгөлөө. Түүний өмнө шинэ боломжийн бүхэл бүтэн ертөнц нээгдэх гэж байлаа. Тэрбээр өмнө нь бэлтгэж байсан яриагаа мартаж, түүний оронд бямба гарагт түүнийг хаа нэгтээ урихаар шийдлээ.

“Үгүй. Яасан ч үгүй. Би үүнийг хэзээ ч хийж чадахгүй. Хэзээ ч. Би үхнэ. Эхлээд үхнэ. Хэрэв тэр таггалзвал яах вэ? Тэгвэл насан туршийн гутамшиг болно”. Тэгээд ажлаа дуустал түүнийг хэрхэн урих бэлтгэлээ хийж өнгөрөөлөө.

Зоогийн газар хаагддаг долоон цаг нэг л мэдэхэд болчихсон байв.

Аав нь хөгжилтэйгөөр

– Гэртээ харья гэж кассныхаа хамаг мөнгийг хамж аваад арын өрөөний ширээний цоожтой шургуулганд хадгалдаг, маргааш өглөө нь банкинд аваачиж тушаадаг бор цаасан уутанд хийнгээ хэллээ.

Ээж гэртээ байхгүй, хэмээн Челси аавдаа сануулан хэлэхэд тэрбээр

Мэднэ, өнөөдөр тэр ээлжтэй гэж арчаагүйгээр мөрөө хавчин хэллээ. Тэгээд орох хаалгаа цоожлохоор явав.

Челси дургүй хүргэсэн хормойвчоо тэсвэр алдан угз татан тайлаад угаах зүйл хийдэг хүүдий рүү шургуулчихав. Аав нь орох хаалгаа цоожлохоор явлаа. Гэнэт үүдэнд шуугиан, хашгиралдаан, хөлийн дуу чимээ гарлаа.

Гайхан үүдрүү харвал жинсэн өмд, даавуун хүрэм өмссөн гурван чанга байрын залууг харав. Тэд эцгийг хойш нь түлхэн зоогийн газарлуу шахалдан орж ирлээ.

Челси хашгирах гэсэн боловч огт дуу гарч өгсөнгүй.

Зоогийн газар хаагдсан! хэмээн ноён Ричардс чангаар зарлан хэлээд, Та нар орж ирэх эрх байхгүй. Бид хаачихсан! гэв.

Булчинлаг өндөр, олс шиг урт үстэй залуу аавыг лангуу луу түлхлээ.

Наад кассынхаа машиныг шавхаад өгчих, тэгвэл бид нар явлаа хэмээн тэр архирав.

Тэнд юу ч байхгүй, хэмээн ноён Ричардс айснаасаа болж нүдээ бүлтийлгэн хэллээ. Юу ч байхгүй!

Нээрээ шүү! гэж Челси амжиж хашгираад гал тогооны хаалга руу шигдэн ухарлаа.

Алив хараадахья, гэж нэг залуу нь хэлээд касс руу алхлаа.

Үгүй! хэмээн Челсигийн аав хашгирлаа. Зайлцгаа! Эндээс гарцгаа! тэрбээр өнөөх залуугийн араас ухасхийн мөрнөөс нь зуураад авлаа.

Үгүй... ааваа! Хэрэггүй! гэж Челси хашгирав.

– Ааваа... болгоомжлоорой!

## 5-р бүлэг

Зэвхий царайтай, туранхай, зэрлэг саарал нүдтэй нэг залуу араас нь гүйж очоод толгой руу нь хүнд төмөр хоолойны тайрдсаар буулгаад авахад ноён Ричардсын нүд нь томоо гэгч нь нээгдэж үруулаас нь ёолох дуу гарлаа.

Челси орилоод л байлаа, орилоод л байлаа.

Аавынх нь нүд цагаанаар эргэлдэж толгой нь унжсанаа дараа нь удаашруулсан кино зураг адил аажуухан доошлон өвдөглөснөө хулдаасан дээр унаад өглөө.

Челси гараараа нүүрээ дарсанаа дараа нь үснээсээ зууран зулгаалж эхлэв. Тэрбээр дахин хашгирах гэсэн боловч ганц ч авиа гаргаж чадсангүй.

Аав аа... гэж арайхийн дуугарлаа.

– Аав аа. Цайвар үстэй өндөр залуу хамаг чадлаараа кассын машин луу цохьсоноо хоосон байхыг нь харав. Алив, эндээс явцгаая! гэж тэр залуу найз нартаа хашгиран хэллээ.

Челси гараа биен доороо хумин хэвтээд огт хөдлөхгүй байгаа аавыгаа ширтээд

Аав аа... хэмээн уйлан үглэнэ. Тэр үхчихсэн үү? гэж аавыг нь цохьсон залуу асуугаад төмөр хоолойгоо газар хаяв. Чи тэгээд үүнийг мэдэх гэж эндээ хоцрох гээ юу? гэж хар үст хэллээ. Гурвуулаа инээлдсээр гадаа гүйж гарав. Челси тэднийг булан тойроод явахыг харлаа. Тэр үснээсээ зулгаасан хэвээрээ байгаагаа мэдлээ. Тэгээд аавынхаа хажууд сөгдөж суув.

Аав аа?.. Аав аа... Тэр хариулахгүй байна. Челси түүний толгой дахь гүнзгий шархнаас тод улаан өнгийн цус урсаж гараад шингэрч байгаа үсээр нь урсахдаа бараантаж ирж байгааг хараад дуу алдлаа. Аав аа?..Охин аавыгаа дээш нь харуулж эргүүлэв.

– Битгий үхээрэй. Битгий үхээрэй. Битгий үхээрэй. Эцэг нь нүдээ нээхгүй байлаа. Тэр амаараа аажуухан, чангаар амьсгалж байлаа. Амьсгалах бүр нь ёолохтой адилхан байна. Амьд байгаад нь баярлан, гэхдээ толгой доор нь урсаж гарсан бараан цуснаас айгаад Челси год үсрэн босоод бүдрэн байж гал тогооны өрөөн дөх утас руу гүйв. “Аврах албаны” утас – 911 – ийг тэр цээжээр мэднэ. Хоёр цагийн дараа Челси гэртээ эргэж ирээд одоо пүүзээрээ халцарсан хивсээ зуран байж өрөөн дотуураа алхална. Биеэ хамгаалах гэсэн мэт тэрбээр гараа элгэндээ эвхсэн байлаа. Хөл доор нь шалны банзнууд шархирч дуугарна. Задгай зуухан дээр байсан паалантай цагны цохилох нь улам бүр чанга болоод байгаа юм шиг санагдана. “Тайвширч үз, хэмээн тэр өөрийгөө ятгаж байлаа.

– Тайвширч үз. Тайвшир. гэж утга учиргүй мэт санагдтал нь давтсаар байлаа. Тэгээд, “Хамаг юм сайн болно” гэж шийдэв. Аавыг нь Шейдисайдын эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт хэвтүүлсэн. Эмч түүний байдлыг “аюултай боловч тогтвортой” гэж хэлсэн. Челси хэтэрхий их айж, хэтэрхий их баярласан болохоороо энэ нь юу гэсэн утгатай болохыг асуусангүй. “Аюултай боловч тогтвортой”. Ямар ч байсан “тэр нас барчихсан” гэснээс гайгүй сонсогдож

байлаа. Дотор цус алдалт байхгүй байна гэж шар үстэй, сэвхтэй нүүртэй эмч хэлсэн. Гаднаас нь харахад тэрбээр Челситэй чацуу мэт харагдаж байсан. Аав чинь их азтай байна.

Азтай гэнэ үү? Яагаад азтай гэж? хэмээн Челси асуух гэж байлаа. Гэхдээ гаслангаа ил гаргахгүй байхаар шийдэж больсон.

Албаар инээмсэглээд зөвхөн талархсанаа гүвтнэн хэлсэн билээ.

Төдөлгүй эмнэлэгт ээж нь цардсан цагаан дүрэмт хувцастайгаа ирсэн. Түүний царай зэвхийчихсэн, маш айсан байдалтай байсан. Шар үстэй эмч түүний мөрнөөс нь тэврээд эелдэгээр ярин ногоон өнгөөр будсан урт хонгилоор дагуулаад явсан.

Одоо бараг арван цаг болж байна, гэтэл хатагтай Ричардс өдий хүртэл эмнэлэгт байсаар л байна. Тэндээсээ лав ажил руугаа буцах байх.

Челси ганцаархнаа байсан бөгөөд зочдынхоо өрөөгөөр л холхисоор байлаа. Шалны банзнууд түүний алхам бүхний дараа гашуудан уйлж байгаа юм шиг учиргүй чийхран дуугарч байлаа.

“Энэ муу хуучин байшин яасан дургүй хүргэж байна гэж тэрбээр буланд байсан хилэнгээр бүрсэн хуучин зөөлөн сандал дээр унахдаа бодлоо.

– Энэ байшинг үзэн ядаж байна. Энэ хотыг үзэн ядаж байна. Бүхнийг... үзэн ядаж байна”. Гэхдээ уур хорсол айдсыг нь даван гарч чадахгүй байлаа. Гэнэтхэн Челси учир зүггүй мэгдэн сандарлаа. Түүнийг хөнжлөөр бүтээчихээд боож алах гээд дараад байгаа мэт санагдлаа. “Аав үхчихвэл яана аа? Тэгвэл бид нар яах бол?” гэснээ тэр даруй өөрийгөө:

Болиоч, Челси. Одоохон... боль” гэж загнав. Охин доошоогоо харсан чинь гартаа утасны харилцуур барьчихсан байлаа. Бодол болохгүй шууд л Нинагийн дугаар луу залгав. Утас гурван удаа дуугарлаа. Нинагийн дуу:

Байна уу, гэх нь сонсогдоно.

Нина, би байна, Челси... Аа, сайн уу! Ажил ямар байна даа? Дуг бид хоёр саяхан л ... Нина, аймшигтай юм боллоо гэж Нина хүйт дааж, зүрх цохилж байгаагаа мэдэрч яаран түүний үгийг нь тасаллаа.

– Манай зоогийн газрыг дээрэмдсэн. Аавыг маань толгой руу нь цохьчихсон.

О, Ямар аймшигтай юм бэ! Бие нь зүгээр үү? Хажууд нь байсан Дуг, Юу болсон бэ? хэмээн асууж байгаа нь Челсид сонсогдож байлаа. Мэдэхгүй юм аа. Аав эрчимт эмчилгээний тасагт байгаа. Биеийнх нь байдал тогтвортой байна гэсэн. Ээж эмнэлэг дээр

байгаа. Би гэртээ гав ганцаархнаа байна гээд Челси ханан зуухан дээр байгаа цагийг бүдэг толбо болон харагдтал ширтлээ.

– Нина, надад тус болооч. Чи ирээд надтай хамт хонооч? Тэгэлгүй яахав. Ямар ч асуудал алга. Ээжээс л асуугаадахья хэмээн тэр дор нь хариуллаа. Челси түүнийг харилцуураа тавиад

хүмүүсийн ярилцахыг сонссон боловч юу хэлж байгааг нь ойлгохын аргагүй байлаа.

Цагнаас хараагаа салгаагүй хэвээрээ том хуучин зөөлөн сандлын тохойлуурыг хуруугаараа тогшилж байлаа.

Одоо очлоо гэсэн Нинагийн дуу харилцуураас сонсогдов.

Баярлалаа хэмээн Челси талархлаа. Хэдэн минутын дараа замаар ирж байгаа машины гэрэл хараад үүд рүү яаран довжооны гэрэл асааж өгөв. Нина их ялдам зантай юм. Ёстой жинхэнэ найз шүү хэмээн

давхар хаалганы цаанаас зам руу шагайж харан бодлоо. Дараа нь Челси түүнтэй хамт Дуг ирсэн болохыг харав. Хүүхдүүд үүдний өрөө рүү ороход тэдний хамт хүйтэн агаар сэнгэнэн орж ирэв. Нина Челсиг айлган тэвэрч авлаа.

Чи зүгээр үү? Их айсан байх даа!

Тийм ээ, би.. гээд юу хэлэхээ мэдэхгүй байв. Дуг гараа хооронд нь үрэн байж хажуугаар нь чихэлдэнэ. Аймаар хүйтэн байна хэмээн тэр зочдын өрөө рүү сониучланшагайж хэлэв. Би халуун шоколад бэлдээдэхье гэж Челси санал болгоход, Кофе нь дээрээ гэж Дуг хүрмээ буйдангийн хажууд газар чулуудан хэллээ.

За, тэгье. Кофе хэмээн Челси зөвшөөрөв. Дуг, Нина хоёр хойноос нь гал зуухны өрөө рүү зүглэв.

Би уусдагийг бэлдээдэхье, тэгэх үү? Би хийгээдэхье, хэмээн Нина шаардлаа. Хөөрхий минь! Хар даа... Гар чинь чичирч байна шүү дээ. Ёстой аймаар байсан гэж Нинаг данханд ус хийхэд нь зай тавьж өгөөд хэлэв.

– Би аавыг... тэнд аймаар их цус байсан! Тэр юун залуус байсан бэ? – хэмээн Дуг лагс том биеэрээ өндөр модон сандал дээр сууж ширээн дээр тохойлдон асуув. Мэдэхгүй. Урьд нь би тэднийг хараагүй. Бүгдээрээ даавуун хүрэмтэй байсан. Чанга байрын. Ямар нэг бүлгийнхэн л бололтой.

Аав маань ОлдВиллижид аймаар их гэмт хэрэг болдог гэж хэлж байсан хэмээн Нина бодлогошрон хэллээ.

Аав чинь эдгэх үү? гэж Дуг сонирхож асуув. Тэгэх байх аа гэж Челси хариулснаа дахин нэг ч үг хэлж чадахгүй болтлоо айчихав. Хэдэн минутын дараа тэд нар зочдын өрөө рүү эргэж ирээд зурагт асаалаа. Хамаг өрөөг өнгө өнгөөр дүүргэн киноны кадрууд жирэлзэж байлаа. Челси булан дахь хилэн зөөлөн сандал дээр кофетой сэнжтэй аягаа хоёр гараараа бариад хөлөө нугалж суулаа. Нина Дуг хоёр буйдан дээр байр эзлэв. Дэлгэцнээс хараагаа салгаад харсан чинь Дуг Нинаг өөр лүүгээ татаад тэвэрч байна. Тэр хоёр нүүрээ наалдуулаад үнсэлцэж эхэллээ.

“Ингэх гээд л Нина уриалагхан гэгч гэрээсээ явж манайд ирэхийг зөвшөөрсөн юм байна

хэмээн Челси гуниглан бодлоо.

– Дуг тэр хоёр нялуурах газраа олох нь энэ шив.” Тэр хоёр бүхэл хорвоо дээр хоёулахнаа байгаа юм шиг үнсэлцэж байлаа. Челси анхаарлаа жирэлзэн өнгөрөх зурагтны дүрснүүд дээр төвлөрүүлэх гэсэн боловч нүд нь өөрийн эрхгүй

Нина Дуг хоёр луу эргэн харсаар байв. Тэр хоёрыг ажигласаар урьдынхаас илүү ихээр ганцаардаж байлаа.

Яахаараа би энэ буйдан дээр залуутай хамт суугаагүй юм бэ? гэж өөрөөсөө асууж байлаа. Яахаараа энэ буланд ганцаархнаа цаг нөгцөөж байх ёстой юм бэ? Бурхан минь, би ганцаараа байхаас бүр залхаж гүйцлээ! Би хаашаа ч явдаггүй, хэнтэй ч уулздаггүй, хэн ч надад ая тал засдаггүй. Тийм болохоор л надад ийм хэцүү байна. Гэтэл түүний толгойд: Хэрэв өнөөх зоогийн газар орж ирсэн чанга байрын залуу... Тим Спаркс... тийм ээ, дахиж ирээд хамт явъя гэж урих юм бол би “тэгье” гэж хариулна. Ганц секунд ч бодохгүй” гэсэн бодол орж ирэв.

Охин нүдээ аниад аавынхаа толгой руу цохихыг дахин харлаа. Түүний нүдэнд тодрох гайхашрал, нүд нь цагаанаар эргэлдээд сөхөрч, унахыг нь харлаа. Толгойноос нь цус урсан гарч байхыг харснаа яг энэ агшинд нэг аймшигт бодол санаанд орж ирэв. “Спаркс гэв гэнэт гамбургераа ч идэлгүй яваад өгчихсөн. Аавыг хүрээд ирэхээр л. Аав бид хоёроос өөр хүн зоогийн газарт ажилладаггүй юм байна гэдгийг мэдчихэнгүүтээ л. Хэрэв тэр гурван дээрэмчин түүнийг тагнахаар явуулсан бол яана аа? Байдлыг шалгуулах гэж. Тэгвэл түүний яаран гараад явчихсаныг тайлбарлахад амархан болно. Тэгээд тэд нар дараахан нь хүрээд ирсэнийг.. Гэвч энэ худлаа байлгүй дээ! хэмээн Челси өөрийгөө ятгаж байлаа. Гэхдээ хэрэв Спаркс тэд нарын нэг нь бол дахиад хүрээд ирэхгүй. Тийм юм бол баригдана гэдгээ мэдэж байгаа шүү дээ.

– Челсигийн толгойд бодол зурагтын дэлгэц дээрхи дүрснүүдээс ч хурдан хурдан ээлжилнэ. Гэнэт түүнд тархи нь хагарах гэж байгаа юм шиг санагдлаа. Охин нүдээ чанга гэгч нь анилаа, дүрс бичлэгийн дуу чимээ чихэнд нь лугшина.

– Хэрвээ тэр дахиад хүрээд ирвэл яана аа? Тэгвэл би юу хийх вэ?”



## 6-р бүлэг

Голын дэргэд хүйтэн боловч сайхан байлаа.

Тэрбээр агаар хүйтэн байхад дуртай. Нэвт үлээх хүйтэн салхинд дуртай билээ. Салхи хамар луу орж, дух руу шахаж дарах түүнд таалагддаг.

Өглөөний нар моднуудын оройгоос нэг их дээшлээгүй байлаа. Цанын ноосон малгай доороос цухуйх өтгөн хар үсэн дээр хүйтэн усны дуслууд бөнжигнөж байв. Салхи аажмаар намдан чихэнд шуугиж байна.

Гол түүний бодож байснаас өргөн байлаа. Түүний хоржигнох урсгалаас сэрүү татах нь үнэхээр тааламжтай байв. Залуу жинсэн өмднийхөө халаасанд гараа шургуулаад өндөр өвсөн дунд хөдөлгөөнгүй удаан зогсож хөөсрөн хүрэнтэх ус руу харж байлаа.

Салхи дахин хөдөлж хөл доорхи өвсийг газар луу налуулна. Түүний биенд хүрэх нь яасан таатай вэ! Аймшигтайгаар гал шатах нүүрэнд хүрэх нь. Салхигүйгээр түүнийг хөргөхийн аргагүй.

Голын нэрийг Кононка гэнэ. Нэр заасан самбар дээр тэгж бичсэн байна. Индиан нэр бололтой. Юу гэсэн утгатай нэр юм бол? Жижигхэн булингартай гол юм болов уу?

Тэрбээр аяархан инээлээ.

Голын цаад талд ой модтой хаднууд сүндэрлэнэ. Тэдний хоорондуур РиверРоуд зам могой адил тахиралдан өгсөж байна. Үүнийг залуу өмнө нь орон нутгийн газрын зургаар анхааралтай судалж мэдсэн билээ.

Тэр цанын ноосон малгайгаа угз татан тайлаад хүрэмнийхээ халаас руу шургуулчихав. Тэр нь дулаацуулж байсан. Гэтэл хүйтэнг мэдэрмээр байлаа. Ялангуяа халуун нар шатааж байгаа мэт цаг ямагт санагддаг нүүрээрээ. Харин агаар тийм хүйтэн, сэнгэнэсэн мэт байдаг! Гэвч нүүр шатсан хэвээрээ л байлаа. Тэгэхээр нь тэр дахиад л өндөр өвсөн дундуур алхалав. Ботинкнууд зөөлөн шороон дээр шал шал хийж, өмдний түрүү шүүдэрт норсон байлаа.

“Шейдисайд ч нэг их муухай хот биш бололтой” хэмээн залуу шийдэв.

Тиймээ, зөв сонгосон байна. Хот нүд баясгаж байна. Гол ч гэсэн.

Тэрбээр НортХиллын уужим, цэвэрхэн үүдний цэцэрлэгүүдтэй өндөр өндөр хашаануудтай, маш нямбай зассан мөнх ногоон ургамлуудтай том том байшингуудыг харж байх дуртай байсан. Түүнийг тэнд хэн ч хүлээгээгүй нь мэдээж л дээ. Тэр өөрийгөө тэндхийн хүн биш гэдгийг ойлгож байсан.

Шейдисайдын арай тохилог, аятайхан хэсэг болох ОлдВиллиж бас түүнд таалагдсан.

“Муугуй л хот байна” гэж дахин нэг бодчихоод том хавтгай чулуу аваад түргэн урсгалтай үс

дээгүүр түүнийг олон дахин ойлгуулж чулуудах гэж оролдлоо. Гэвч чулуу шууд ёроол руу орчихлоо.

“Энэ хотод үхэх үйлтэй охидууд байгаа нь мэдээжийн хэрэг. Яг тан шиг охидууд шүү, ээж ээ”, хэмээн гараа өмднийхөө халаасанд шургуулан өөрөө өөртөө хэлэв. Тэгээд түүнийг дахин уур хилэн эзэмдэн авахыг мэдэрлээ.

Энэ бүхэн дандаа түүний ходоодонд эхэлдэг билээ, дараа нь аажмаар дээшлэн хүзүүний булчин татдаг. Тэгэхээр нь толгой өвдөж, уур хилэндээ таталдаж эхэлдэг бөгөөд нүүр улам бүр тэсэхийн аргагүй халуунд шатдаг билээ.

Шоржигнох хүйтэн ус, сэрчигнэх салхи, хөл доор найгах чийгтэй өвс, аль нь ч тайвшрал авч ирч чадахгүй байлаа. Эхэлсэн л бол түүний уур хилэнг юу ч зогсоож үл чадна. Эхийнхээ тухай бодож эхлэнгүүт л тэр уур хилэндээ шатаж эхэлдэг.

“Ээж ээ, үхэх хувь тавилантай охидууд байдаг юм шүү. Яг тантай адил.”

Энэ уур хилэн түүнийг олон жилийн турш эзэмдээд тавихгүй байгаа билээ. Түүнийг дөрвөн настай байх үеэс хойш. Эцэг эх нь салсан тэр үеэс хойш. Эх нь насанд хүрсэн охиноо аваад явчихсанаас хойш. Түүнийг эцэгтэй нь ганцааранг нь үлдээснээс хойш.

“Ээж ээ, та юу хийж байгаагаа ойлгож байсан шүү дээ хэмээн чулуу шидэн, энэ шидэлтэндээ хамаг хүч чадал уур хилэнгээ гарган санаандаа эхтэйгээ ярьсаар байв. Энэ удаадаа тэр чулуугаа ойлгохыг хүсээгүй, түүнийг булингартай хүрэн усны хамгийн гүнд оршуулахыг л хүссэн билээ.

– Чи юу хийж байгаагаа мэдэж байсан. Аав орой болгон архи уугаад согтуугаараа намайг зоддог гэдгийг мэдэж байсан. Тэглээ ч гэсэн эгчийг аваад алга болсон. Намайг хаячихсан. Намайг түүнтэй үлдээгээд... Ээж ээ, би таны тухай шөнө болгон боддог байсан. Намайг зодох болгонд л би таны тухай боддог байсан. Зөвхөн таны л тухай. Бас өшөөгөө авах тухай. Би танаас өшөөгөө авна, ээж ээ. Өшөөгөө аваад эхэлчихсэн. Очсон хот болгондоо. Би таныг л олмоор байна. Таны хаана амьдарч байгааг л мэдмээр байна.”

Гэнэт моддын дунд муурны цагаан зулзага гараад ирлээ. Тэрбээр түүн лүү аймшиггүй хар нүдээрээ өвсний дээгүүр харж байлаа.

Алив нааш ир, муужгай гэж тонгойгоод гараараа даллан тэр дуудав.

– Кскс, нааш ир!

Муурны зулзага толгойгоо бөхийлгөсөн боловч байрнаасаа хөдөлсөнгүй.

Ээж ээ, заримдаа би өшөөгөө авдаг хэмээн өөрөө өөртэйгөө ярьсаар явган суугаад цагаан арьстай жаахан амьтанг дуудсаар байв. – Тэгэхээр бие жаахан хөнгөрөөд явчихдаг юм. Хүн алахаар хөнгөрөөд явчихдаг... Гэвч уддаггүй”.

Муужгай, нааш ир. Нааш ир гэж тагнай, шүдээ ташиж дуудлаа.

“ Ээж ээ, гол нь хэрэгтэй охиноо л сонгож авах хэрэгтэй байдаг юм. Тэгээд би түүнийг энд Шейдисайдад оллоо. Тэр тантай адилхан бор царайтай. Ядахнаан л би таныг тийм байсныг санадаг юм. Надад таны гэрэл зураг байхгүй л дээ. Та надад ганц ч зургаа явуулаагүй. Захиа ч бичээгүй. Зүгээр л намайг хаячихсан. Харин намайг орой болгон зоддог байсан... Тэр охин тантай адилхан юм шиг ээ. Тан шиг бор царайтай, булцгар... Хөөрхөн биш боловч аятайхан. Тэгээд зориг муутай юм шиг байна лээ. Аймаар зориггүй. Тэр охин яг тохирно, ээж ээ. Дараа дахиад уур хилэн хөдлөх юм бол тэр охин яг тохирно гэж бодож байна”.

Кс кс, наашаагаа хүрээд ирээч! Муурын зулзага болгоомжтойхон өөдөөс нь нэг алхаснаа аяархан дуугарлаа. Дараа нь дахиад нэг алхлаа. Сонжсон байдалтай харснаа, бас дахиад алхлаа. Кскс, нааш ир, хэмээн тэр зөөлөн, нарийхан дуугаар дуудлаа.

– Чи удаан зовохгүй гэснээ муужгайг авангуугаа боогоод алчихав.

## 7-р бүлэг

Челси өөрөө ч мэдэлгүйгээр лангуугаа чийгтэй алчуураар арчаад, дараа нь онгорхой цонхоор гал зуухны өрөө рүү шагайлаа. Хэн ч алга. Эрни хэмээх шивээстэй, булчинлаг тогооч тамхи татахаар гарсан бололтой.

“Аавыг байхгүйд энд ажиллах онцгүй юм аа! гэж тэрбээр бодно. Гэхдээ үнэнийг хэлбэл түүнийг хажууд байхад ч энд ажиллах нь таалагддаггүй байсан”. Охин санаа алдлаа. Үгүй юмаа гэхэд энэ ажлыг хийснээрээ шинэ хувцастай болж, хааяа нэг хуурцаг худалдаж авах боломжтой байдаг байлаа.

Дөрвөн өдөр өнгөрсөн боловч ноён Ричардс Шейдисайдын эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт хэвтсээр байгаа билээ. Гэхдээ эмч нар түүний эдгэрч байгаад сэтгэл ханамжтай байгаа билээ.

Челси хөх ягаанаар гэрэлтэх неон цаг руу нүдээ өргөн харав. Долоод хорь дутуу, мөдхөн хаах цаг болж байна. Хэрэв яаравчлах юм бол аавыгаа эмнэлэгт эргэж амжина. Долоо хагасаас эргэлтийн цаг дуусна.

Челси хоосон зоогийноо газрыг тойруулан харлаа. Өнөөх гурван чанга этгээд эргээд ирвэл яана аа?

Хүүш, Эрни! хэмээн тэрбээр гэнэт айн хашгирав. Эрни чанга байрын том биетэй залуу байлаа. Ямар нэг юм болох юм бол тэр охиныг хамгаалж чадна. Гэхдээ Эрни хаана байна? Хэн ч хариулахгүй байна. “Зоогийн газрын арын гудманд байгаа юм байна” гэж Челси

бодсоноо зэвэрдэггүй төмрөөр хийсэн том хөргөгчийг чат хийн гэнэт дуугарахад цочин бөндөсхийлээ.

Яаж ийн цаг өнгөрөөхийн тулд ангийнхаа шинэ сурагч Уилын тухай бодохоор шийдлээ.

Одоохондоо хэн хэн нь жинхэнээсээ ярилцаж чадаагүй л байгаа. Челси хэлэх гэж бэлдсэн үгнүүдээ хэд хэдэн удаа давтсан. Тэрбээр хичнээн олон янзын харилцан яриануудыг бодон боловсруулж, санан дотроо хоёр биенийхээ хэлэх үгнүүдийг сургуулилан тоглосон. Түүний зохиосон ярианууд хялбархан, хөгжилтэйгөөр өрнөж байлаа. Уилл тэр хоёр нэг нэгнийгээ тохуурхан наадаж хошин шог яриандаа инээлдэж байсан.

Гэвч өглөө ангидаа түүний хажууд сууж байхдаа Челси зөвхөн догдолж байлаа. Хажуудах хүүхэдтэйгээ ярилцах боломж ер гарахгүй байв. Эсвэл Ноён Картер баахан зарлал уншаад эхлэнэ, эсвэл Уилл дэвтэр дээрээ ямар нэг юм хичээнгүйлэн бичиж байна, эсвэл яриа эхлэх эгзэг нь таарч өгөхгүй байна.

Залуу түүнд хэд хэдэн удаа инээмсэглэсэн, бүр хоёр удаа мэндэлж ажил ямар байгааг асуусан. Тэгэнгүүтээ дахиад л бичээд юмуу уншаад эхэлдэг байлаа.

“Ер нь намайг урихгүй юм шиг байна” гээд Челси бүр сэтгэл санаагаар унан бодож байлаа.

Тэр хоёрын харилцаа тэгж удаанаар өрнөж байгаа хэдий ч Челси Уиллын тухай маш их бодож байгаага мэдэж байлаа. Саксофон дээрээ тоглож байхдаа ч хүртэл заримдаа түүний зориг муутай инээмсэглэл, яруухан хар нүдийг нь дурсан санадаг.

Охиныг дотроо түүнтэй яг ээлжит удаагаа ярилцаж байтал хаалга нээгдэж чанга байрын хоёр банди ороод ирэв. Тэр хоёрын нүд хоосон танхимаар гөлөлзөн гүйлгэнэ. Тэдний нэг нь өндөр, өргөн цээжтэй, тоор жимсний үслэг хальстай адилхан богинохон зассан шар үстэй. Нөгөөх нь нарийхан, өндөр, цэцэг өвчнөөр өвдөөд тогтсон толбот царайтай байв. Тэр нь зэвүүнээр мушилзана. Хоёулаа өнгө нь гандсан жинсэн өмд, намар хүйтэн байгаа хэдий ч “хеви металл” гэсэн бичигтэй ханцуйгүй цамцтай байна.

Челси айсандаа арагш ухарч аажмаар гал тогоо руу зүглэнэ. Айснаа мэдэгдэн – Эрни! хэмээн аяархан дуудав.

Хариу байдаггүй.

“Биднийг дахиад дээрэмдэнэ гэж үү?” Челси хана налаад тэр хоёр тонуулчнаас хараа үл салган биендээ зэвсэгтэй байна уу гэдгийг мэдэх гэж оролдоно. Кассанд тавь хүрэхгүй доллар байгаа билээ. – Тиймхэн мөнгөний төлөө тэд нар намайг гомдоохгүй байлгүй дээ”.

Тэрбээр үг дуугүй мөнгөө өгөхөөр шийдэв. Хэдхэн өдрийн өмнө аав нь гурван дээрэмчидтэй муудалцаж, тэднийг хөөж, касс руу очуулахгүй гэж оролдож байсныг хэзээ ч мартажгүй.

“Хэрэв тэдэнтэй сөргөлдөж, тэмцэлдэж, касс руу очиход нь саад болох гэж оролдоогүй бол аягүй бол түүнийг цохихгүй л байсан болов уу гэж Челси өөрийгөө ятгаж байлаа.

– Баатарлаг царай гаргаж тэд нартай зөрөлдөхөө больё.”

Зоогийн газарт өөр хэн ч байхгүй байгааг хараад өнөөх хоёр чинь касс руу дөхөөд ирлээ.

Чи энд ганцаархнаа байгаа юм уу? гэж туранхай нь мушилзсан хэвээрээ асуув. Гэхдээ нүд нь түгшсэн харагдана.

Үгүй, хэмээн Челси түвшин дуугаар догдолсноо мэдэгдэхгүйг хичээн хариулав. – Ганцаараа биш.

Янзгүй залуус бие бие рүүгээ харснаа инээлдлээ.

Бид нар яг хаах гэж байсан юм гэж Челси нэмж хэлэв. Айснаа мэдэгдэхгүй гэж шийдсэн боловч хоолой нь чичирч байлаа. Цаг руугаа харвал долоод арван минут дутуу байна.

Яг уу? гэж туранхай нь лавлан асуулаа. Хоёулаа дахиад инээлдэв. Та нарт би юу авч ирэх вэ? хэмээн Челси арайхийн хэллээ. Чи тийм ч тэнэгхэн амьтан биш бололтой гэж нөгөөх өндөр нь богинохон шар үсээ маажлан хэлэв.

Нээрээ шүү, манайх хаагдах гэж байна гэж хэлэхдээ Челси амьсгаа бөглөрч байгаага мэдлээ. Ам бүр хатаж орхижээ.

Алив хөө, чи ч энд хамгийн авхаалжтай нь юм гээч, хэмээн өндөр нь махлаг гараа кассны хажууд лангуун дээр тавилаа.

Та нар юу хүсээ вэ? гэж Челси асуув. Түүний асуусан нь гуйж байгаа мэт сонсогдоно.

За даа... хэмээн өндөр залуу эхэлснээ хамтрагч руугаа харан хоёулаа дахиад л инээлдэцгээв.

Челсигийн зүрх нь хүчтэй цохилно. “Хэрэв тэд нар намайг дээрэмдэх гээд байгаа юм бол яагаад явахгүй удаад байгаа юм бол?” гэж Челси уцаарлан өөрөөсөө асуулаа.

Бид нар юу хүсэв гэж үү? хэмээн өндөр нь маасагнахад,

Сайхан асуулт байна гэж нөгөөх нь нэмж хэллээ. Тэгээд хэдэн цагт чи тарна гэнээ? гэж өндөр залуу лангуун дээгүүр тонгойгоод лавлан асуув. Түүний нүүр нь Челсид бүр тулаад ирлээ. Айснаасаа болоод түүний амьсгал боогдох шахав. “Тэгээд эд нар чинь яах гээд байгаа юм бэ? Зоогийн газар дээрэмдээд алга болох гээгүй юм уу? Энэ тэнэг асуултуудыг яах гэж тавиад

байгаа юм? Яагаад юм л бол маасалзаад байгаа юм?”

Тэгээд чи хэзээ ажлаасаа буух юм бэ? гэж өндөр дахин асуув.

Челси цаг руугаа харснаа тэднийг хүн айлгахаа болиод яваад өгөөч гэж гуйх гэсэн боловч хаалга дэлгэгдэж тод гэрэлтэй зоогийн газар бас нэг банди ороод ирлээ.

Хоёр гараа доош нь буулгаад тэр хүү лангууны хоорондох нарийхан зайгаар түргэн алхлав. Челси түүнийг нэг л удаа харсан боловч дор нь танилаа.

Спаркс! – гэж хашгирснаа тэр даруйхан эргэлзэн “Тэд нартай хамт яваа бол яанаа? Үгүй! Тийм байх ёсгүй” гэж бодлоо. Өнөөх зэвүүн царайт банди нар хоёулаа Спаркс руу мэгдэн харав. Тэрбээр лангууны буланд зогссоноо тэдэн лүү бас харлаа.

Түүний доош нь унжуулсан хоёр хүчирхэг гар зангирч, хар нүд нь тэр хоёрыг ээлжлэн ширтэнэ.

Зоогийн газар хаагдаагүй байна уу? гэж Спаркс Челсигээс асуув.

Яг хаагдаж байна гэж тэр аяархан хариулсан боловч байрнаасаа хөдөлсөнгүй.

Аяга кофе авч болох уу? Спаркс дахин тэр хоёр луу харав.

Тэгэлгүй яахав, Челси автомат руу очлоо. Дараа л болохоос доо гэж өндөр банди хэлээд нөгөөхтэйгөө бие биеэ харлаа. Туранхай нь мушилзахаа больсон байхыг Челси ажиглав. Тийм ээ, дараа, гэж нөгөөх нь занасан байртай зөвшөөрч хэлснээ хоёулаа эргэж хараад Спарксын хажуугаар хөнгөхөн алхлан зоогийн газраас гараад явлаа. Тэдний араас хаалга хаагдтал Челси хадаастай юм шиг зогсов. Дараа нь санаа нь амарч чангаар санаа алдсанаа хамаг бие нь сульдаж, унахгүйн тулд лангуун дээр наллаа. Спаркс лангууны цаад булангийн сандал дээр суунгаа

Тэд нар чамайг дээрэмдэх гэсэн үү? гэж асуув. Тийм ээ. Үгүй, сайн мэдэхгүй юм аа. Итгэлгүй байна.

– Челси мэгдэж орхив. Кофе гоожиж байх хооронд тэрбээр цагаан шаазан аягаа автомат доор тэгшхэн тосох гэж хичээж байлаа. Аягаа Спарксын өмнө тавихдаа түүний хар нүд анхааралтай ширтэн харж байгааг ажлаа. Спарксын царай төлөв, бодлогошронгуй байлаа. Челси түүнд зэвэрдэггүй төмрөөр хийсэн сүүний жижиг гүц дөхүүлэн өглөө.

Ямар ч байсан чанга гарууд шиг аяглаж байсан шүү. Яах гэж байсныг бүү мэд. Дэрэмдэх гэж байсан ч байж магадгүй.

– Охин хормогчоо тайлаад эвхлээ.

Спаркс сүү хийлгүйгээр кофеноос балгав.

Челси эвхээстэй хормогчоо булан руу чулуудлаа.

Чамаас айсан байхаа, гэж зориггүйхэн инээмсэглэн нэмж хэлэв.

Зөв юм хийж хэмээн Спаркс хариу хэлээд хараагаа буулган аяга руу ширтлээ.

Челси гайхцран “Үүгээрээ юу гэх гэсэн юм бол? Дахиад хошигнож байгаа юм болов уу?” Царайг нь хараад тааварлах аргагүй байв.

Спаркс дахиад нэг балгалаа. Түүний хар үсэн дээгүүр халуун уур суунаглан тод гэрэлд замхран алга болж байна.

Энд аюултай юм аа хэмээн тэр хараа буруулан хэлэв. “Юу бодож тэгж хэлсэн юм бол оо? Зүгээр л бодсоноо хэлж байгаа юм болов уу? Аль эсвэл надад анхааруулан мэдэгдэх гэсэн юм болов уу?” Челси гал зуухны өрөөнд юм маажих мэт чимээ гарахыг сонсов. Эргээд харсан чинь Эрни байлаа. Тогооч амандаа янжуур зуучихаад халуун тогоогоо угааж байна.

Ажлаа дуусгах уу? гэж тэр чанга, огцом дуугаар асуув. Тийм ээ. Би зоогийнхоо газрыг хааж байна гэж Челси хариуллаа. Спаркс кофеноосоо дахин уулаа. Челси түүнийг дахиад юу ярихыг нь хүлээсэн боловч залуу гүн бодолд автсан бололтой байна. Челси түүнд талархаж, тэр зэвүүн, мушилзсан амьтдаас аварсанд баярласнаа хэлж яриа дэмжье гэж бодно. Гэвч дахиад л зориг хүрсэнгүй. Толгойд нь юу ч орж ирдэггүй. “Намайг хаа нэгэнтээ урих болов уу? хэмээн тэр бодлогоширно. Хэрвээ урих юм бол би яах вэ? Зөвшөөрөх үү?”

– Охин түүнд татагдаж байсан боловч айж байгаагаа мэдэрч байлаа.

– Үгүй энэ чинь би яахаараа юу ч бодож олж чадахгүй байна? Яагаад зүгээр л түүнтэй чалчиж болдоггүй билээ? Яагаад Нина шиг зарим охид үүнийг хялбархан хийчихдэг, харин надад тийм хэцүү байдаг юм бол оо?

– Энэ асуултууд Спарксыг лангууны цаад талаас харж, түүний төлөв бор царайг судалж байх хооронд толгойд нь эргэлдэж байлаа. Эцэст нь хоолойгоо зассанаа

Дахиад кофе хийгээд өгөх үү? гэж асуув.

Үгүй, баярлалаа. Банди толгойгоо сэгсрэв. Гал зуухны өрөөнөөс Эрни хүрмээ булчирхаг гар дээгүүрээ тохоод барьчихсан гарч ирлээ.

Маргааш болтол баяртай! гэж Челсид толгой дохин хэлснээ Спаркс өөд харлаа.

За. Баяртай, хэмээн тэрбээр нүдээрээ үүд хүртэл түүнийг үдэн хариулав. Тэгснээ гэнэт “Би Спаркстай хоёулахнаа үлдлээ” хэмээн санав. Ингэж бодохоос нуруугаар зарс гээд явчихлаа.

Спаркс ууж дуусаад аягаа тавьснаа лангуун дээр доллар чулуудчихав.

“Ярихгүй юм болов уу? Хүлээснээсээ болоод Челси хөшчихөв.

– Намайг болзоонд урихгүй юм байх даа? Уриач, Спаркс аа! Би “тэгье” гэж хариулна. Түүнд бодлоо зайнаас дамжуулахгэж хичээлээ. Би заавал “Тэгье!” гэж хэлнэ. Спаркс огцом босов. Түүний гарных нь булчин гүрэлзэнэ. Зогссон хэвээрээ тэр зориггүйхэн түүнд инээмсэглэв.

Баярлалаа.

Зүгээр гээд Челси гараа аяга руу сарвайлаа. Баяртай, Түүний пүүзнүүд хулдаас дэвссэн шалан дээгүүр чимээгүйхэн сүрчигнэнэ. Эргэж харсан ч үгүй яваад өглөө. Зоогийн газраас хэдэн хорооллын алсад Спаркс цахилгаан шатгүй байшингийн гуравдугаар давхарт байдаг өрөөнийхөө хаалгыг угз татан онгойлгоод гэрлээ ч асаалгүй давчуухан зочдынхоо өрөөнд оров. Хаалгаа хаахад бараг огт харанхуй болж зөвхөн гадаа гудамжны ёлтойсон шар гэрэл цонхоор тусна.

Жижигхэн, бүгчимхэн өрөөндөө холхиж байхдаа Спаркс хэд хэдэн удаа тэнийлгэсэн алга руугаа зангидсан гараараа цохиж, тав тухыг нь алдуулсан амьтны хүрээлэнгийн араатан адил алхалсаар байхдаа бүр уурлан хашгирна. “Яагаад би түүнийг хааш нь ч урьсангүй вэ? – гэж өөрөөсөө асууж байлаа. Яагаад үүнийг хийсэнгүй вэ? Урихыг хүсч байсан шүү дээ. Аль эртнээс хүсч байсан... Яахаараа тэр гашуун кофе шимээд л яг хөшөө шиг суудаг байна? Бид хоёулахнаа байсан шүү дээ. Бүр хоёулахнаа. Тийм сайхан боломжийг алдах ч гэж дээ! Би чинь юу болоод байна?”

Өөртөө дургүйлэхсэндээ тэр ширээн дээр байсан харилцуурын аппаратыг барьж аван угз татан залгуураас утсыг нь салгаад хамаг хүчээрээ цонхоор гаргаад чулуудчихав.

Шил тачигнан хэсэг хэсэг болон бяц үсэрлээ. Гэвч тэрбээр үүнийг сонссонгүй. Түүний тархийг нэвг сүлбэх уур хилэнтэй хашгираан чимээ шуугианыг даржээ.



## 8-р бүлэг

Маргааш өдөр нь хичээлийн дараа Челси шүүгээгээ түгжчихээд нүдээрээ Нинаг хайснаа пиг дүүрэн хүнтэй шуугиан ихтэй хонгил руу шагайв. Найзыгаа олно гэдэг амаргүй хэрэг байлаа. Сургууль дотор немец овчарк ороод ирчихсэн түүнийг тойроод хөвгүүд охидууд шавааралдан хонгилыг дүүргэжээ. Нохой байдгаараа сүүлээ шарван сургууль дүүрэн хуцаж байв.

“Нохой л байна. Юун сүртэй юм, нэг их чухал үйл явдал болж байгаа юм шиг аашлах юм! гэж Челси гайхлаа.

Хоёр эрэгтэй хүүхэд овчаркийг захирлын өрөө рүү аваад явсан боловч нохой хүзүүвчгүй байсан болохоор амаргүй байлаа. Араас нь бөөн хүүхдүүд дагалдана.

Челси арайхийж Нинаг олж харав. Охин шүүгээнийхээ хажууд гартаа цэнхэр ноосон пальто барьчихсан Челсиг хараад зогсож байна.

Хөөе, Нина!

– Челси бөөн хүүхдүүдийн дундуур арай гэж чихэлдэн шургана. Тэрбээр найзтайгаа Спаркс Уилл хоёрын тухай зөвлөлдөх гэж шийджээ. Тэр хоёрын нэг нь түүнийг болзоонд урихын тулд юу хийх хэрэгтэй вэ? гэдгийг хэлээд өгч магадгүй.

Нинагийн нүүр царай нь урвайчихаад уйлсан юм шиг нүд нь улайчихсан байхыг хараад тэр гайхлаа.

Юу болов? хэмээн Челси үүргэвчээ нөгөө мөр лүүгээ шилжүүлэн асуув.

Хамаг юм тэр муу тэнэг Дугаас л болж байгаа юм, хэмээн Нина уцаартай хэлээд шүүгээнийхээ хаалгыг ойгоод эргэж нээгдтэл нь чанга хаалаа.

Дуг яасан юм?

Өдрийн цайны үеэр би түүнийг харсан гэж Нина дургүйлхан тайлбарлав, Тэр Суки Томастай ярилцаж байна лээ.

Би түүнийг танихгүй юм байна хэмээн толгойгоо нохойд хөөгдөөд гүйлдэж байгаа хэсэг хүүхдүүдийн зүгт эргүүлэн хэлэв.

– Хэн нэгэнтэй ярилцах юу нь муу байгаа юм? Хамаг зүйл хэрхэн ярилцаж байгаад байгаа юм гэж Нина тодотгоод дахин хаалгаа хаалаа. Энэ удаад тэр түгжигдэв. Яг энэ үед олон хүүхдэд хөөгдөн айсан нохой хажуугаар нь сарвуугаараа шал маажин давхиж өнгөрсөн болохоор яриа тасалдлаа. Наадхыгаа тавиач ээ! Хаалгаа онгойлгоод гаргачих! гэж хэн нэг нь хашгирлаа. Хонгилын үзүүрт давхар хаалга нээгдэхэд нохой баярлан год үсрэн гадаа гараад агшин зуур алга болов. Баярлан хашгиралдах дуу гарлаа. Сургууль дотор дахиад хэдэн минут инээлдэх баярлан хашгирах дуу сонсогдож байснаа дараа нь хүүхдүүд пальтогоо өмсч үүргэвчээ бариад тарцгаалаа. Чамд зоогийн газар хоёр удаа орж ирсэн тэр залуугийн тухай

чамд ярих гэсэн юм хэмээн Челси ярьж эхлээд хоккейн хувцах өмсч гартаа махир цохиур барьсан хоёр хөвгүүнд хана руу шахагдав. Тэд нар хажуугаар нь арайхийж багтаж гарлаа. Нина цоожныхоо тоотой цоожийг эргүүлэн цоожлогдсон эсэхийг шалгачихаад дотор нь номоо мартчихсанаа саналаа. Тэгээд цөхрөнгүй санаа алдсанаа нууц дугаартай цоожныхоо тоог эргүүлж гарав. Тэр залуу нилээн чанга байрын харагддаг хэмээн Челси үргэлжлүүлэв.

– Түүний нэрийг Тим Спаркс гэдэг, гэхдээ тэр өөрийгөө хүмүүс зөвхөн овгоор нь дууддаг гэж ярьж байна лээ. Ямар дүнсгэр гээч! Би бага зэрэг ууртай гэж хэлэх гэсэн юм. Гэхдээ зүгээр л ичдэг байж болох юм. Анхныхаа удаа намайг кинонд урьсан. Гэвч би юу ч гэж хариулаагүй. Үнэндээ бол бидний яриаг тэгэхэд тасалдуулчихсан юм. Дараа нь...

Би зүгээр л Дугт итгэхгүй байна хэмээн Нина түүний яриаг таслав. Түүний нүүрийг шүүгээний хаалга халхалжээ. Тэрбээр шалан дээр өвдөглөж суугаад доод тавиур дээрээс номоо хайж байлаа.

– Үгүй, би тэр Суки Томасыг жинхэнэ янхан гэж хэлэх гэсэн юм.

Тэглээ ч гэсэн би түүнийг сонирхолтой залуу гэж бодож байна хэмээн ярьж дуусгачихсанаа хий дэмий ярьж байгаагаа ойлгоод, Чи намайг ерөөсөө сонсохгүй юм аа гэж найз охиноо зэмлэлээ.

Нина босоод шүүгээнийхээ хаалгыг хааж түгжив.

Юу? гэж тэр духаа айсан байдалтай үрчийлгэлээ.

– Уучлаарай, Челси би өөрийнхөө юмыг бодоод. Гэнэт түүний нүд бүлтийгээд ирлээ.

Хүүшээ, тэр тэнд явж байна. Хөөе, Дуг ээ! гэж Нина дуудлаа.

– Дуг ээ, хүлээгээч!

– номоо арайхийн үүргэвчиндээ чихчихээд хонгилоор найзыгаа гүйцэхээр гүйгээд явчихав.

Унтууцаж урам нь хугарсан Челси нэг хэсэг түүнийг араас нь харж зогслоо. Дараа нь Нинагийн шүүгээг цоожлогдсон эсэхийг нь шалгачихаад сургуулийн хаалга руу ядарсан байдалтай алхаллаа.

“Нина сайн найз л даа... гэхдээ хэрэв хажууд нь Дуг байхгүй л бол гэж тэрбээр халаглан бодлоо.

– “Хэрвээ тэр хажууд нь байх юм бол намайг анзаарахгүй юм”.

Хаалганаас хэдхэн алхамын наана түүний мөрөнд хэн нэг нь гараа хүргэв. Челси чочоод огцом зогсож эргэн харлаа.

Өмнө нь Уилл Блейкли зогсож байв. Түүний хацар нь ягаанаар гэрэлтэж, уруул нь ичингүйрэн инээмсэглэнэ. Хар үс нь “Дожер” пүүсийн саравчтай малгай дороос цухуйна.

Тэр хар хүрэн өнгөтэй ноосон хүрэм өмсчээ. Нэг гартаа тасалдаг хуудастай том тэмдэглэлийн дэвтэр барьж, ном сугавчилжээ.

Сайн уу! гэж Уилл хэлээд инээмсэглэв.

А, сайн уу! хэмээн Челси хариуллаа. – Ажил төрөл чинь ямар байна даа?

Сайн байна, хэмээн тэр мөрөө хавчлаа. Энэ хүрэм Шейдисайдых биш байна гэж Челси хэлчихээд тэр даруй – Ямар мангар юм бэ! Шейдисайдынх биш гэдэг нь тэртэй тэргүй харагдаж байна шүү дээ. Харсан болгоноо л хэлэх юм” гэж бодлоо. Би тэр... нөгөө... өөр сургуульд байхдаа өмсдөг байсан юм аа. Хуучин сургууль чинь хаана байсан юм бэ? хэмээн Челси үүргэвчээ нэг мөрнөөсөө нөгөөх рүүгээ шилжүүлэн асуулаа. Өмнө зүгт гэж Уилл түүний хажуугаар харан хариуллаа, Чи завтай юу? – Хөвгүүн түүнээс хараа буруулсаар л байв. Би яг гэр лүүгээ явж байлаа гэж Челси хариулав. Тэдний ангийн хоёр хүүхэд хажуугаар нь өнгөрөөд сургуулиас гарахдаа тэдэн лүү гараараа даллалаа. Хоёр цагийн дараа би ажилдаа явна. А! – Урам нь хугарсандаа түүний нүүр нь урвайгаад явчихлаа. – Тэгвэл чи зугаалах завгүй байгаа юм шив дээ? О! Байгаа. Байлгүй яахав, Челси сэтгэл хөдөлснөө нууж чадахгүй байлаа. – Зугаалах сайхан шүү. Ямар сайхан өдөр вэ! гэж охин хаалга онгойхоор шагайгаад хэллээ. Хөнгөн үүл нарыг халхалсан байлаа. Тэнгэрийг үүл бүрхэн сааралтана. – Ягтаа бол сайхан өдөр байжээ хэмээн Челси хөхрөн байж хэллээ.

О, тэгвэл чи зугаалмааргүй байгаа юм уу? “Миний бодож байснаас тааруухан банди байна шүү” гэж охин бодсоноо хөгжөөнтэй болоод ирлээ. Явья, цэцэрлэгт хүрээлэн яг сургуулийн ард байдаг юм. Чи тэнд очиж үзсэн үү? гэж Челси асуулаа. Залуу толгой сэгсрээд түүний араас сургуулийн өөр нэг хаалга руу явлаа. Урт хонгилоор явж байх туршдаа тэр хоёр нэг нэгэндээ ганц ч үг хэлсэнгүй.

Гадаа Челсигийн бодож байснаас хүйтэн байв. Салхи үлээж өвөл болчихсон юм шиг хүйтэн байлаа. Тэр хүрэмнийхээ цахилгаан товчийг хаах гэж зогслоо. Дараа нь хоёулаа зэрэгцэн алхаад багш нарын машины зогсоол, бейсболын болон хөл бөмбөгийн талбайг өнгөрч эцэст нь уужим цэцэрлэгт хүрээлэнд оров.

Челси уртаар амьсгаа авлаа.

Ямар сайхан агаартай юм бэ! Ялангуяа бидний сургууль дотор амьсгалдаг агаарын дараа юу хэмээн Уилл зөвшөөрөв. – Түүнийг лав 1920 оноос юм уу эсвэл тэр хавиас л нэрж байгаа байх шүү. Челси инээгээд түүний хошигнож хэлснийг: “Ёстой догь! Бас алиа хошин зантай байх нь” хэмээн ихэд тоож бодлоо. Уилл бас чимээгүй бараг сонсогдохгүй, хоолойных нь хаа нэгтээ гүнээс гарах мэт дуугаар инээлээ. “Нээрээн үнэхээр дажгүй залуу байна шүү” хэмээн түүнд санагдана. Челси модод өөд харлаа. Тэд нар бараг хамаг навчаа гөвөөд, мөчрүүд нь нүцгэрэх шахан өвлийнхөө төрх байдалд оржээ. Цэцэрлэгт хүрээлэнгийн арын ой гол хүртэл үргэлжилдэг хэмээн Челси тайлбарлалаа. Би голруу очиж үзмээр байна гэж цаадах нь хариулав. Ой дундуур зөрөг байдаг болов уу? Тийм ээ. Байдаг гэж бодож байна. – Челси толгой дохилоо. Би эндхийг бүгдийг нь сайн мэдэхгүй л дээ. Бид нар Шейдисайдад дөнгөж есдүгээр сарын сүүлээр нүүж ирсэн юм. Танайх олон нүүдэг юм уу? хэмээн хүү төлөв царай гарган асуув. Үгүй, олон биш ээ. Охин түүнийг санамсаргүй гараараа шүргэчихэв. Тэд нар

өвсөн дундуур явж байлаа, хөл доор нь

хүрэн навчис шаржигнана. – Аав маань энд зоогийн газар худалдаж аваад бид нар нүүж ирсэн юм.

Чи баян уу? – гэж асуучихаад улайлаа. – Үгүй, би юу... гэж хэлэх гэсэн юм.

Охин түүний хэлснээс биш ичсэнээс нь илүү хөгжин инээв.

Энэ бол ОлдВиллижийн нэг жижиг зоогийн газар байгаа юм. Аав маань түүнийг худалдаж авах гэж их зээл авсан. Гэхдээ тийм зоогийн газартай болох юмсан гэж үргэлж их хүсдэг байсан л даа.

Нэг хэсэг тэр хоёр дуугуй явлаа.

Харин чи олон нүүдэг үү? – хэмээн Челси яриа дэмжих гэж хамаг байдгаараа хичээж асуув.

Тийм ээ гэхэд түүний дуунд харамсал сонсогдлоо. Охин түүнийг өөр юу гэж хэлэх бол гэж хүлээсэн боловч цаадах нь бодол болон урагшаагаа хараад түүний асуусныг сонсохгүй байгаа бололтой. Тэд нар моднуудын хооронд тахиралдах навчис хөглөрсөн зөрөгөөр алхаж байлаа. Тэнгэр бүрхэж, доошоогоо буух мэт болоод ойг харанхуйлна. Яасан хүйтэн байх юм бэ, удахгүй цас орох байх аа хэмээн Челси яриа өдлөө. Тэгснээ өөрийгөө: “Бурхан минь! Болиоч! Цаг агаарын тухай ярьж болсон юм биш үү” гэж загнав. Надад харин цас таалагддаг шүү, Уилл түүн лүү эргэж хараад инээмсэглэлээ. – Цас маш цэвэрхэн шүү. – Тэр том цагаан хусны дэргэд зогсоод түүний толигор их биений хажууд тэмдэглэлийн дэвтэр номоо чулуудчихаад, – Хоёулаа юмнуудаа энд үлдээчихье гэснээ түүний үүргэвч рүү хуруугаараа заан: Наадах чинь лав их хүнд байх аа, гэв. Сайхан санаа байна хэмээн охин хүнд үүргэвчээ тайлаад түүний юмны хажууд хаячихав. – Мөрөн дээрээсээ уул аваад хаячихсан юм шиг л боллоо.

Энэ замаараа буцна хэмээн залуу хэдэн алхамаар хоцрон хэлэв.

Зөрөг зам моддын цаана хоцорч алга боллоо. Челси гараа урагш нь сунгаад: Хүүш, Би гол харах шиг боллоо! Тэр хараач! гэснээ түүнийг

хүрч ирэхийг хүлээгээд, – Энэ голыг Конононка гэдэг гэв.

Хүү инээмсэглэсээр түүн лүү бүр ойртоод ирлээ. Инээмсэглэх болгонд нь гялалзах түүний нүд таалагдаж байна шүү хэмээн Челси шийдлээ.

“Хараач хөө, би эрэгтэй хүүхэдтэй хамт ойгоор зугаалж байна хэмээн тэр хөөрнө. – Бодвол олон охидын хувьд энэ бол тийм ч их том үйл явдал биш байх л даа. Харин би өмнө нь хэзээ ч эрэгтэй хүүхэдтэй хамт ойгоор зугаалж байгаагүй.”

Челси зүгэр л ямар ч шалтгаангүйгээр Уилл өөд инээмсэглэхчээд дараа нь эргээд зөрөг зам руу харна.

Тэр хоёр цааш нь алхлаа. Гол руу ойртох тусам агаар улам бүр хүйтэрсээр байв. Гэхдээ

салхины сэрчигнээн завсраар түргэн гол шаагих нь сонсогдож байв.

Чи намайг энэ зугаалгад урьсан нь сайн болж хэмээн Челси хөгжилтэйгөөр хэллээ. – Хөөе!.. Уилл дахиад л хоцорсныг сая л анзаарлаа. Эргээд харсан чинь тэр гартаа ямар нэг юм барьсан харагдана.

Энэ нь саарал олсны өөдөс байлаа. Уилл явж байх зуураа түүнийг голоор нь хоёр нугалаад урдаа барин өргөсөн боловч Челси түүнийг харж байгааг мэдээд буулгачихав.

Оллоо хэмээн намхан бут руу заан тайлбарлалаа, Газраас, тэнд. – Дараа нь мөрөө хавчиснаа олсоо хүрэмнийхээ халаас руу шургуулчихав.

Гэнэтхэн цас орлоо, эртэч цас, анхны цас, том том ширхэгтэй цагаан цас. Челси амаа ангайн хэлээ тосоод ганц ч гэсэн цас барьж авах гэж оролдоно. Гэвч Уилл түүнийг анхааралтай харж байхыг хараад больчихов.

Ийм эрт, арван сард цас ордог гэж үү?

Мэдэхгүй юм аа хэмээн охин хариуллаа. Магадгүй.

– Дараа нь цагаа харснаа – Хүүш, миний явах цаг болчихож. Ажилдаа хожигдож болохгүй. Уучлаарай хэмээн түүний нүүр улайн хэллээ. – Би чамд гай болох гээгүй юм шүү.

Ямар гай? гэж гайхан асууснаа гараас нь барьж газар унасан модон дээгүүр арайхийж алхан гарав. Ёстой сайхан зугаалга боллоо. Надад маш их таалагдсан шүү. – Челси түүнд инээмсэглэлээ.

Уилл хариу инээмсэглэсэнгүй. Нүд нь түгшүүртэйгээр эргэлдэнэ. Том том алхлан урд ороод явлаа.

Цас орж эхэлсэнтэйгээ адилхан гэнэт орохоо больчихов. Тэнгэр ч бага зэрэг цэлмэлээ.

Хоёулаа хамт юм хумаа орхисон хусны дэргэд очиход Уилл гэв гэнэт зогсоод түүн лүү эргэн харав. Түүний хар нүд гялалзана. Нүд рүү цоргиж байгаа мэт санагдана. Хэсэг бодсоноо тэр:

Бямбад хамт кинонд юм уу, өөр хаа нэг тийшээ явах уу? Тэгье. Ёстой догь! – хэмээн Челси дуу алдлаа. Тэгээд – Анхны болзоо! гэж сэтгэл догдлон хэллээ. Тэгснээ ичсэндээ болоод нүдээ анин үүргэвчээ авах гэж тонгойхдоо гайхамшиг болж Уилл сүүлчийх нь үгийг сонсоогүй байгаасай хэмээн найдаж байлаа. Үгүй яах гэж ингээд хэлчих вээ? Яахаараа тийм тэвчээргүй байдаг байна? “Ёстой үхмээр юм аа гэж Челси бодлоо. – Намайг дахиж хэн ч харахгүй болтол газрын гаваар уначих юмсан”. Арай гэж хүчлэн байж Уилл өөд харав. Гэтэл Уилл дотноор инээмсэглэж байсныг яана.

Тэр ойртож ирээд:

Чи нууц хадгалж чадах уу, Челси? гэж асуулаа. – Энэ бол

бас миний анхны болзоо байгаа юм. Би их баярлаж байна гэж Челси зориггүйхэн хэлэв. Тэгээд арай илүү сайхан, ухаалаг үг хэлж чадаагүйдээ харамслаа. Ямар ч байсан Уиллын үнэнээ хэлсний дараа сэтгэл нь хөнгөрөөд явчихлаа.

Хоёулаа нууцаар болзох уу? гэж тэрбээр бүр ойртож ирээд, нүд рүү нь харан байж аяархан санал болгов. –Хэнд ч битгий хэл. Бидний хооронд л үлдэг. Чи бид хоёрын хооронд л.“Ямар романтик юм бэ! хэмээн охин бодлоо. Баярласандаа болоод өндөр үсэрч хашгирмаар санагдаж байлаа. Маш аятайхан залуу түүнтэй анхны болзоо тогтоолоо. Тэр их ялдамхан. Тэгээд тийм... шударга. Тэгээд яг над шиг зориг муутай. Тэгээд би бас түүнд таалагддаг.

За, тэгье гэж Челси бараг шивнэх шахан хэллээ. – Энэ бидний нууц болог. Бидний анхны болзоо.

## 9-р бүлэг

Маргааш нь Челсиг саксофон дээр тоглох дасгалуудаа хийж байтал хаалга дэлгэгдээд хатагтай Ричардс нисэх мэт орж ирлээ. Цув, үс нь норжээ.

Челси цонх руу харвал гадаа усан бороо цутгаж, шөнө болсон юм шиг харанхуй байлаа. Хэдхэн минут орсон өчигдрийн цас газар бүрхэж чадаагүй, харин өнөөдөр Челси хөгжмөө тоглосоор байгаад бүр аадартай шуурга болж байгааг ч анзаарсангүй.

Ээж ээ таны бүх зүйл чинь сайн биз дээ? гэж нойтон цувыг нь тайлахад туслах гэж ээж рүүгээ гүйж очив. – Яагаад та ийм эрт хүрээд ирэв? – Челси задгай зуухан дээрхи цаг руу харвал дөрвөн цаг гучин минут болж байна.

Асуугаад ч юу гэхэв хэмээн ээж нь ядрангуй хариуллаа. Тэрбээр чичирч байсан бөгөөд охин луугаа харан – Ясаа хүртэл даарлаа гэж гомдолно.

Ээжийнхээ цагаан дүрэмт хувцсыг нил цус болчихсон байхыг хараад дуу алдав.

Ээж... юу болоо вэ? Эмнэлэг дээр багахан осол болоод. Нэг эмчлүүлэгч угаалгын өрөөнд хальтраад хөлөө зүсчихлээ. Гэхдээ гайгүй. Даанч миний нөгөө ээлжийн хувцас гэрт байдаг. Энэ хар борооноор түүнийгээ авах гэж ирлээ хэмээн хатагтай Ричардс тайлбарлав. Тэгвэл та дахиад л ажилдаа явах нь ээ? – хэмээн Челси гартаа цув барьсан чигээрээ асуулаа. Тийм ээ. Тэгээд би Алиса Броудигийн өмнөөс ээлжинд гарах нь. Тэр ханиад хүрчихсэн юм. Ээж нь хувцсаа солих гэж дээшээ өрөө рүүгээ явлаа. – О, Миний гутлыг хараач. Бүр норчихож. Гэтэл надад өөр байдаггүй.

Челси араас нь дагаад явлаа.

Ээж ээ, та дандаа л эмнэлэг дээр байж байх юм. Би таныг ерөөсөө харах ч үгүй юм.

За, битгий дахиад л гомдоллоод уна хэмээн хатагтай Ричардс эрсхэн сануулав. Тэгэх тэнхээ алга. Итгэж үз. Өрөөнийхөө үүдэнд тэрбээр зогслоо. – Би бямбад оройн хоолныхоо үеэр ирнэ. Ажилдаа бүр орой гарна. Хоёулаа сайхан хооллоод ханатлаа ярилцаж болно.

Үгүй, болохгүй гэж Челси татгалзлаа. Ээж нь гайхан харвал, Би болзоотой хэмээн Челси мэдээлэв. Хатагтай Ричардсын нүд томоо гэгч нь боллоо.

Ямар сайн хэрэг вэ! Та тоглоогүй биз? – хэмэн Челси ээжийгээ дахиад л энгүүхэн даажигнаагүйд нь сэтгэл гонсойн сонирхов. Би даажин хийж байх чадалгүй болтлоо норчихсон байна. Тэгээд ч чиний төлөө би баярлаж байна. Чамайг дандаа л ганцаархнаа байдаг гэдгийг би мэднэ шүү дээ гэж хариуллаа. Ээжийгээ цэвэр хувцас өмсөж байх хооронд Челси ангийнхаа шинэ сурагч Уиллын тухай, Шейдисайдын цэцэрлэгт хүрээлэнгээр хамтдаа зугаалсан тухай, түүнийг ямар зориг муутайхан боловч аятайхан болох тухай ярилаа. Түүнтэй танилцах юмсан гэхээс тэсч ядаж байна гэж ээж нь инээмсэглээд цардсан хормойгоо тэнийлгэн байж хэлэв.

Ө, Би чамд аавын чинь тухай хэлэхээ мартчихаж. Би түүнтэй ярьсан.

Тэгээд? Түүнийг эрчимт эмчилгээний тасгаас шилжүүлсэн. Эмч нар түүнийг нэг юм уу хоёр долоо хоногийн дараа эмнэлгээс гарч болно гэж бодож байгаа гэсэн. – Эх нь Челси өөд гүйж ирээд сэтгэл догдлон түргэн тэврэв. Сайхан байгаа биз дээ?

Сайхан! хэмээн Челси хөөрөн өгүүлээд, Тэгвэл бид нар түүн дээр энгийн эргэлтийн цагаар очиж байж болох нь ээ, Ээж нь орны дэргэдэх ширээн дээр байдаг цагийг харснаа Ө, Бурхан минь, ажилдаа хожигдож байна. Өнөө орой би Кристигаас ээлж хүлээн авна. Хэрвээ би хоёр секундээр ч гэсэн хожигдох юм бол тэр ёстой жинхэнээсээ уурлана даа.

Борооноос болж зоогийн газрын ихэнх байнгын үйлчлүүлэгчид ирсэнгүй. Хэдхэн хүн л цувныхаа усыг сэгсэрч гараа үрэн чичирсээр орж ирсэн. Тэд нар бүгдээрээ л адилхан шөлтэй хоол, чили халуун кофе захиална.

Челси ихэнх цагаа арын кабинд геометрийн хичээл хийж өнгөрөөлөө. Сүүлийнхээ бодлогыг бараг дуусгаж байтал кабинд чимээгүйхэн нэг хар юм сүүтгэнэн ороод ирэв.

Спаркс! –хэмээн Челси цочин дуу алдлаа. Түүний хар үснээс ус дух руу нь урсаж байсан хирнээ нүүр дүүрэн инээмсэглэж байлаа. Спаркс хүрмээ тайлаад хажуу дахь суудал дээрээ тавьж, дан ажлын цэнхэр цамцтайгаа үлдлээ. Ажил чинь ямар байна даа? гэж толгойгоо сэгсэрч, түүнийг усаар шүршин байж асуухад Челси дэвгрээ хаав. Аяархан байгаач гэж тэрбээр арьсаар нь хүйт оргиод явчихыг мэдрэн гуйлаа. Спаркс түүн лүү ширүүн, анхааралтай харсан чинь яагаад ч юм сэтгэл тавгүйрхаж, түгшсэн харцаар гал тогооны өрөө рүү шагайв. Эрни угаалтуурын хажууд мухар сандал дээр суугаад хуйлсан сонин барин үгийн сүлжээ бодож байна.

Челси Спарксын гөлөрсөн харцаас нүд буруулан байж кабинаас мяраан гарлаа.

Чамд юу авч ирэх вэ? Кофе гээд хуруунуудаараа ширээн дээр тогшилж, Бас хэтэрхий хатчихаагүй бол нэг зүсэм бялуу.

Бялуу өглөөнийх л дөө, гэхдээ зүгээр байх гэж бодож байна гэж Челси хариулав.

“Түүний хажууд би яахаараа ингэтлээ тавгүйрхана вэ? гэж тэрбээр тавган дээр нэг зүсэм бялуу чулуудчихаад кофетой автомат руу алхаж байхдаа бодож явлаа. – Надад таалагддаг болоод тэр үү? Эсвэл түүнд ямар нэг ер бишийн, хачин, аюултай зүйл байна уу? Сонин юм шүү, би түүнд таалагддаг болов уу? хэтэрхий бялхам кофе хийчихсэнээ аягаа тонгойлгон дундруулснаа үргэлжлүүлэн бодсоор байлаа: Үгүй. Таалагддаггүй байх. Би ямар хөөрхөн биш. Гэхдээ тэр ганцаарддаг байж болох юм. Эсвэл аягүй бол зүгээр л намайг дамшиглаж, тоглож байгаа байлгүй”.

Ийм дүгнэлтэнд хүрээд Челси түүний тухай илүү ихийг мэдэж авахаар шийдлээ.

Кабин луу эргэж ороод өмнө нь ширээн дээр тавагтай бялуу, кофе тавьчихаад түүний нүүр лүү харав. Гэвч түүгээр нь юу ч хэлэх бололцоогүй байна. Спаркс бялуунаас том хазлаа, элсэн



чихрийн нэвс түүний уруул дээр наалдана.

Нүүрэмгий байх гэж хичээн

Чи хаанаас ирсэн бэ? гэж Челси асуув.

Залуу бялуугаа зажилж байж залгичихаад балга кофегоор даруулж уучихаад дараа нь л:

Эндээс хэмээн нүдээ гялалзуулан хэллээ.

Энэ чинь хаана байдаг юм? Спаркс өргөн мөрөө хавчив. Зүгээр л эндээс. – Тэр бялуунаасаа дахин нэг хазлаа. – Би

ойр ойрхон нүүдэг юм. Чи сургуульд явдаггүй юм уу? – охин түүнээс заавал ямар нэг юм мэдэж авахаар шийдэв.

Явдаг.

Ямар? Яг үнэнийг хэлэх юм бол ямар ч биш гээд нүдээ бурууллаа.

– Хаячихсан. – Дараа нь дахин нэг балгаснаа Челси өөд уур суунаглах аяга дээгүүр хараад тодруулан: Би дунд сургуулиасаа гарчихсан гэв.

Охин эв хавгүйхэн инээлээ.

Сургуульд байх тийм ч муу биш шүү. Жишээ нь би хөгжим тоглодог гэснээ дорхноо тэгж хэлсэндээ харамслаа. “Үгүй, би яах гэж ингэж хэлэв ээ?” гэж нүүр нь улайн гайхаж байлаа. – Яасан мангар юм болов оо!”

Юун дээр чи тоглодог юм? Бүрээ юу? Залуу доог тохуу хийгээгүй мэт байсан боловч тэрбээр гомдчихлоо. “Тэгэлгүй дээ, намайг ийм том, бүдүүн болохоор бүрээ үлээдэг гэж бодоо байлгүй. Яагаад бишгүүр дээр гэж хэлсэнгүй юм?” Чи намайг тохуурхаж байгаа байлгүй хэмээн Челси гал зуухны өрөө рүү харан хэллээ. Үгүй, тохуурхаагүй! Зүгээр л чамайг бүрээн дээр тоглодог байж магадгүй гэж бодсон юм. Үгүй, тоглодоггүй гэж охин огцом хэллээ. Би саксофон дээр тоглодог юм. Тэр, харж байна уу, би бараг таачихсан байна шүү дээ. – Тэр нүдээ аяга руугаа буулгасан боловч уруул дээр нь үл ялих инээмсэглэл тодорно.

Тэгвэл чи ажилладаг юм уу? – Челси ярианыхаа сэдвийг өөрчлөхөөр шийдлээ.

Чи юун их асуулт тавих дуртай юм? гэж хэдэрлэв. Уучлаарай. Челси дахиад л улайснаа мэдэрлээ. Зүгээр л сонирхсон юм. Хэрвээ намайг яваасай гэж бодож байгаа бол би... Үгүй ээ, үлд. – Тэр өөрийгөө ямар хүчтэй гэдгээ мэдэхгүй байгаа бололтой, яагаад гэвэл Челсигийн гарыг өвдтөл нь атгачихав. Охин ийм харьцаанд дасаагүй гэж хэлэх гэсэн боловч гарыг нь тавиад:

Би ажил хайж байгаа. Эцэг эх маань намайг ажилд ор гээд байгаа юм. Ойлгож байна уу, юу хийх вэ гэдгээ шийдсэнийхээ дараа хэмээн мэдээллээ.

Чи хаагуур хайсан бэ? – хэмээн Челси сонирхов. Спаркс хоосон зоогийн газрыг тойруулан харснаа.

За яахав, энэ газар надад таалагдаж байна гээд инээмсэглэхэд түүний нүд нь дахиад л гялалзав. – Энд нэмэлт ажлын хүч шаардагдаж байгаа юм шиг байна. Юу гэж хэлмээр байна?

Инээдтэй биш байна. Тэгээд чи хаагуур ажил хайгаав? Тээрэм дээр ярилцлаганд орсон. Хамаг юм дажгүй болох шиг болсон шүү. Тээрэм ажлаагүй удаж байна гэж Челси хэллээ. – Миний найз охин Нина машинаар намайг тийшээгээ аваачиж үзүүлсэн. Ө, тэгвэл ярилцлага тийм ч амжилттай болсонгүй бололтой гэж хэлээд өөрийнхөө хэлсэн үгэнд инээнэ. Түүнийг худлаа ярьж байгааг нь илрүүллээ. Тэгвэл ярьж байгаа болгон нь худлаа юм болов уу? Юуг нуух гээд байгаа юм бол оо? Спаркс гараа дахиад ширээн дээгүүр сунгаж охины гарт хүргэв.

Хүүш, чи бямбад завтай юу? Хоёулаа ямар нэг юм хийе. “Би түүнтэй явах ёстой, хэмээн Челси зүрх нь цохилон өөртөө хэллээ. – Гэхдээ би түүний тухай юу ч мэдэхгүй. Тэгээд ч итгэхгүй байна” гэснээ гэнэт Уиллын тухай санав.

Бямбад би болзоотой хэмээн тэр хариуллаа Спаркс түүнийг үнэн хэлж байна уу үгүй юу гэдгийг мэдэх гэж байгаа мэт түүн лүү гөлрөн харлаа. Дараа нь хөл дээрээ босоод:

Харамсалтай байна гэв.

Челси түүн лүү харав. Спарксын нүүр нь улайж хорссондоо хүрлийнэ. Нүд нь нарийхан зурвас болж, уруулаа жимийжээ.

Тэрбээр жинсэн өмднийхөө халаас руу гараа хийснээ үрчийсэн хоёр доллар гаргаж ирээд хөндий дуугаар :

Дараа уулзталаа баяртай! гэж салах ёс хийлээ. За. Зүгээр хэмээн Челси өөрийхөө дууг таньж ядан аяархан хариулав. Уурласан хөдөлгөөнөөр Спаркс хүрмээ аваад эргэн үүд рүү алхаллаа. Дараа нь үүдээ дэлгэснээ бороо руу гараад явав. Хачин юм! – хэмээн Челси байрнаасаа хөдлөлгүй чанга хэллээ. Тэгснээ “Яасан аймаар залуу вэ? Яг дэлбэрэх гэж байгаа бөмбөг шиг” гэж бодлоо.

## 10-р бүлэг

Бид нар хаашаагаа явж байгаа юм бэ? гэж Челси асуув. Кинонд хэмээн Уилл толгойгоо эргүүлж харахгүйгээр яаравчлан хариулав. Түүний хоёр гар нь жолоон дээр байна. Гэхдээ худалдааны төв тэр талд байдаг шүү дээ, Челси зүг зааж байлаа. – ДивижиСтритэд. Мэднэ, Уилл хаазан дээр гишгэхэд хуучин “Понтиак” хүрхэрлээ. – Уейнбрижид бас л нөгөөх кино гарч байгаа. Би сонин дээрээс харсан. Челси сэтгэл дундуур байгаагаа нуух гэж цонх руу эргэн харлаа. Энэ чинь түүний анхны болзоо шүү дээ. Тийм болохоор сургуулийнхаа хүүхдүүдийн цуглардаг худалдааны төвийн кино театрт очмоор байлаа. Тэгвэл бүгдээрээ түүнийг Уиллтай хамт явааг харах байсан юм. Яагаад тэр ойролцоох хотын кино театрлуу авч яваа юм бол? Охин харанхуйд жирэлзэх байшингуудыг харж байлаа. Радиог хуучны нийтийн дуунуудыг дамжуулж байгаа станц дээр тохируулжээ. “Бич Бойз” хамтлагийн дуу машин дүүрэн хангинана. Ашгүй бороо дуусаж. Бямба гарагийн цэлмэг сэрүүхэн орой байлаа. Саяхан орсон борооны дараа зүлэг, мод, бүр гудамж хүртэл гялалзаж байна. “Харанхуйд бүх юм хамаагүй цэвэрхэн, илүү их тод харагдах юм аа хэмээн Челси бодно. Энэ борооноос болсон юм бол уу? Аль эсвэл би анхныхаа болзоонд явж байгаа болод тэр үү?” – Гэнэт Уилл яагаад түүнийг Уейнсбриж рүү авч яваагүйг ойлголоо: тэр хоёр анхныхаа болзоог нууцална гэж тохиролцсон шүү дээ. Энэ бол тэр хоёрын хувийн, романтик нууц.

Челси түүн лүү эргэж хараад инээмсэглэв. Түүнийг ямар төлөв байдалтай машинаа жолоодож явааг хараад тайвширлаа. Бүр аз жаргалтай санагдана.

Чи ч догь машинтай юм аа хэмээн нийллэг эдээр бүрсэн хар суудлыг гараараа илэн хэллээ. – Хэдэн жил болж байгаа юм?

Сайн мэдэхгүй юм аа гэж тэр хариулав. – Манайд далаад оны сүүлээс л байгаа юм.

Эцэг эх чинь үүнийг шинэ байхад нь худалдаж авсан уу? хэмээн Челси асууна.

Тийм... Би ганцхан энэ машиныг л жолооддог юм хэмээн нэмж хэлэв.

Чи юу гэж бодож байна, халаагуураа асаах уу? Салхины шил цантаж байна гэж Челси санал болголоо.

Уилл өөр нэг машинд зам тавьж өгөн тоормозлоод, баруун гараараа халаагуураа асаах гэж янз бүрийн оньс дарж ноцолдоно. Түүний оронд сэнс ажиллаж эхлэхээр Челси инээлээ. Тэгснээ гэнэт толгойд нь сэтгэл түгшээсэн бодол орж ирээд дуугүй болчихов. Хэрэв эцэг эх нь энэ машиныг аль эрт авсан юм бол халаагуурыг яаж ажиллуулдгыг яагаад мэдэхгүй байна?

Яагаад чи халаагуур ажиллуулж чаддаггүй юм? хэмээн өөрийн эрхгүй асуучихлаа. – Чи дандаа энэ л машиныг барьдаг гэсэн шүү дээ гээд түүний нүүр улайгаад явчихыг анзаарав.

Залуу машиныхаа хурдыг бага зэрэг хасаад замаас нүдээ салгалгүй тайван, нухацтайгаар

Чи ч миний нууцыг нээчих шив дээ гэлээ.

Чиний нууц уу? хэмээн охин зарсхийв. Тийм ээ хэмээн Уилл түүн лүү харан, намайг болхи амьтан гэдэг. – Тэгээд инээснээ баруун гараараа жолоогоо алгадлаа.

Челси ч гэсэн гол төлөв сэтгэл амраад явчихсанаасаа болж инээчихэв.

Чамайг миний нууцыг мэдчихгүй байх гэж би найдаж байсан юм хэмээн Уилл үргэлжлүүлэн, Ядаж наад зах нь ийм эрт, анхны болзооныхоо үед биш гэж. Гэхдээ энэ бол үнэн шүү. Би аймаар болхи амьтан байгаа юм. Бүр халаагуураа хүртэл асаачихаж чаддаггүй.

Би ч гэсэн эв хавгүй шүү гэж Челси үнэнээ хүлээлээ. Тэгээд хуучин сургуульдаа нэг удаа концертны өмнө гэнэт түүний саксофонтой сав нээгдчихсэн тухай ярив. Тайзан дээрээс амгайвч, бас хөгжимний маань бусад хэсгүүд унаад сургуулийнхныхаа өмнө тэднийгээ бүгдийг нь хамж авч билээ.

Их л таагүй юм болж, гэхдээ чи ядахнаа халаагуурыг асааж чадна.

Кинотеатрт хүрэх үлдсэн замынхаа турш тэр хоёр нэгнийгээ өөр өөрийнхөө амьдралд тохиолдсон бүтэлгүй явдлуудаа ярин зугаацуулна. Чөлөөтэй, хөгжилтэй яриа боллоо.

“Мань хүн ч хошин шогийн овоо мэдрэмжтэй юм аа,” хэмээн Челси бодов. Тэр өөрийгөө түүнд таалагддаг эсэхээ мэдэхгүй л байлаа. Таалагдаж л байгаа юм шиг байна. Түүний дэргэд Уилл урдынхаас илүү чөлөөтэй, тайван байна.

Энд зогсоол байна хэмээн машинаа ухруулаад талбай дээр аятайхан оруулчихлаа. Дараа нь хөдөлгүүр, гэрлээ унтраачихаад халаасандаа түлхүүрээ хийгээд, өөрийнхөө талын хаалгыг онгойлголоо.

Бүхээг дотор дээд талын чийдэн асахад Уилл суудал дээрээ хэтэвчээ орхичихсон байхыг Челси ажиглав.

Хөөе... хэмээн түүнийг авангаа дуудлаа. Уилл хэтэвчээ түүнийг айтал нь яаравчлан маш хүчтэйгээр шүүрэн авлаа. Уучлаарай, би чамайг айлгах гээгүй юм шүү гэж охин луу царайгаа барайлган хэлэв.

“Энэ ямар учиртай юм бол оо? – Челси хаалгаа онгойлгоод машинаас гарах зуураа гайхаж байлаа. Намайг түүний хэтэвчийг авах гэж байна гэж бодмооргүй юм аа! Шал инээдтэй юм.” Гэвч Уилл элэгсэгээр инээмсэглэн түүний мөрөн дээр гараа тавиад кинотеатр луу дагуулан явахад нь тэр явдлын тухай дорхноо мартаж орхив.

Жон Кенди болон ах дүү Куэйд нарын тоглосон овоо хөгжилтэй инээдмийн кино байна. Уг нь Челсид тиймэрхүү кинонууд таалагддаггүй байсан боловч анхныхаа болзооны үеэр Уиллын хажууд суугаад аз жаргалдаа умбаж байхдаа Челси чин сэтгэлээсээ инээн баясч, машинаар хөөцөлддөг сүүлийн кадрууд дуусч гэрэл асахад харамсав.

Тэр хоёрыг кинотеатраас гарч ирэхэд гадаа гайхалтай дулаахан байлаа. Толгой дээр бараан үүлний зурвасаар таллан хуваагдсан сар өлгөөтэй байна.

Нилээн мангар кино байна шүү хэмээн Уилл инээмсэглэн дүгнээд машин луугаа алхихдаа Челсигийн мөрнөөс ялдамхан тэвэрнэ.

Тийм л дээ, гэхдээ хөгжилтэй байсан шүү гэж охин хариуллаа.

Өлсөв үү? гэж түүнээс асуув. Челси мөрөө хавчлаа. Чи намайг юу хүсч байгааг мэдэх үү? – Тэд машин дээрээ

хүрээд ирсэн байлаа. Уилл түүний хажууд зам дээр зогсов, гудамжны гэрэлтүүлгэнд түүний хар нүд гялалзах нь харагдана.

Юу? Давхиж яваад, дараа нь нэг газар зогсож байгаад жаахан чалчъя хэмээн тэр охины нүд рүү ширтэн байж хэллээ. Тэгээд жинсэн өмднийхөө халаасанд гараа хийв.

Ёстой догь гэж Челси зөвшөөрлөө. Чи оччихож болох аятайхан газар мэдэх үү? – хэмээн машинууд кино театраас явах тусам хоосорч байгаа зам өөд харан асуув.

Долоо хоног бүр ямар нэг охин суулгаад явдаггүй гэдгээ үзүүлэх гээ юү? – гэж Челси түүний хорыг малтлаа.

Чи намайг энд ирээд удаагүй байгаа гэдгийг бүү мартаарай хэмээн залуу аяархан инээгээд биеэ хамгаалан, Би дасах хэрэгтэй биз дээ гэв.

Тэгвэл би ч гэсэн энд ирээд удаагүй шүү дээ, гэж охин санууллаа. – РиверРиж өөд явж болно байх гэж бодож байна. Гол дээрхи хаднуудын дунд байдаг юм. Хүүхдүүд тийшээгээ их очдог гэж Нина хэлж байна лээ.

Нина гэж хэн юм бэ? – гэж Уилл сэжиглэн асуулаа. Миний найз охин. Шейдисайдад ирчихээд одоохондоо танилцаад байгаа цорын ганц охин байгаа юм. – Хэсэг зуур дуугуй байснаа Челси нэмэн – Чамайг тооцохгүй бол гэв.

Уилл түүний хэлсэнд баярласангүй, харин ч царайгаа барайлгалаа.

Чи Нинад бидний болзооны тухай ярьсан уу? Үгүй, юу гэж дээ, үгүй. – Челси жолоочийн эсрэг талын хаалгыг нээв. – Энэ чинь бид хоёрын нууц шүү дээ, чи мартчихаа юу? – түүний инээмсэглэхэд залуугийн нүүрнээс ч гэсэн ширүүн байдал ариллаа.

Яалаа гэж, мартаагүй. Уилл машинаа тойрч очоод хаалгаа нээж жолооны ард суулаа. Минутын дараа тэд Шейдисайдын зүг давхиж байв. Хоёулаа дуу чимээгүй, арын өсгөгчөөс аятайхан зөөлөн хөгжим эгшиглэнэ. РиверРиж өөд хаагуур очдог юм бол? гэж тэднийг Шейдисайдад дөхөж ирэхэд Уилл асууснаа өөрөө РиверРоудаар байх аа гэж хариулав. Тийм байх аа гэж Челси батлан хэлээд Ө, Энэ их гоё шүү! “Темптейшенс” хамтлаг байна. – Охин хэдэн хором “Миний бүсгүй” дууг даган чангаар дууллаа. – Уилл, чи дандаа эртний дуу дуулдаг энэ долгионыг сонсдог юм уу?

Тэрбээр салхины шил өөд анхааралтай ширтэж түүний асуултанд хариулсангүй. Түүний бодол санаа хаа нэгтээ алсад л яваа бололтой.

Уилл? – Охин түүний гарт хүрлээ. А! – гэж толгойгоо сэгсэрлээ: Уучлаарай. Юм бодоод. Сайхан дуу байна шүү, тийм ээ? РиверРижд зун хүүхдүүд ирэх дуртай байсан байж болох юм, гэхдээ аравдугаар сарын тэр үдэш хэн ч тэнд байхгүй байна. Уилл машинаа яг хадны ирмэгт тулгаж тавиад гэрлээ унтраалаа. Тэртээ доор гол чимээгүйхэн бараантаж урсана. Цаад талд нь Шейдисайд хот байх бөгөөд одоо хэдхэн байшинд гялбалзах чийдэн, байнга солигдох гэрлэн дохионуудыг эс тооцвол бараг харанхуйд уусжээ. Челсигийн зүрх нь галзуу юм шиг цохилж байлаа. Түүний сэтгэл догдолж, хичнээн жаргалтай байна! Дуу дуулж, хаалгаа онгойлгон машинаас үсрэн буугаад хадан дээгүүр хөөрч, голын цаана нисч гараад харанхуй тэнгэр өөд дүүлэн доор гэрэл нь гялбалзах жижиг хот дээгүүр халин нисмээр санагдна. Уилл жолоон дээрээс гараа аваад инээмсэглэн түүн лүү эргэж харлаа. Дараа нь нэг гараа суудлын ар дээр тавив. “Одоо тэр намайг үнсэнэ гэж Челси баярлан бодлоо. – Би РиверРиж дээр, түүнд таалагддаг хөвгүүнтэй хамт байна гээч! Миний анхны болзоо...” – Охин Уилл өөд инээмсэглэв. Харин тэр түүнийг өөр лүүгээ татан тэвэрлээ. Челси уруулаа долоолоо. Ямар хуурай байна. Сэхээ авч амжаагүй байтал түүний уруул охиныхтой нийллээ. Үнсэлт зоримог биш, түргэн болж өнгөрлөө. Уилл толгойгоо гэдийлгэснээ инээмсэглэв.

Сайхан үдэш байна шүү хэмээн тэр хэлэв. Челси толгой дохилоо. Тэрбээр үнсэлт арай удаан үргэлж лээсэй гэж хүсч байсан билээ. Дахин тэврээд бас үнсээсэй гэж хүсч байлаа. Тэр олон удаа тийм үдэш болохыг төсөөлөн бодож байсан билээ. Тийм болохоор яг төсөөлж байсан шиг тийм байгаасай.

Гэвч Уилл гараа суудал дээрээс аваад жолоон дээрээ дахиад тавьчихав.

Зугаалмаар байна уу? – гэж аяархан асуулаа. Жаахан. Энд үнэхээр сайхан байна. Хотыг харах аятайхан байна шүү. Харин чамд ямар санагдаж байна? – гэснээ хариу хэлэхийг хүлээлгүй хаалга онгойлгоод гарав.

Охин ч гэсэн түүнийг дагалаа.

“Их романтик залуу байна шүү хэмээн Челси бодлоо. – Сургууль дээр маш зориггүй байдаг, харин энд илүү зоригтой, өөртөө итгэлтэй болчихсон юм шиг ээ. Надтай хамт байх нь түүнд таалагдаад л тэгж байгаа байх.”

Челси арай гэж тайвширлаа. Машиныхаа хаалгыг хаачихсан чинь гэрэл нь унтарчихлаа. Бүр харанхуй болчихов.

Уилл? – хором хиртэй охин түүнийг харахаа больчихлоо. Дараа нь харанхуйд нүд дасаад ирэхээр түүнийг хадны ирмэг дээр зогсож байхыг олж харав.

Хоёр гараа хүрэмнийхээ халаасанд хийгээд хотыг хараад зогсож байна.

Энийг хараач, эргэж хараад дохин охиныг дэргэдээ ир гэж дуудлаа. – Яг үлгэрт гардаг шиг юм аа. Тэгээд яаруулан:

Наашаа ирээч! – гэж дуудлаа. Челси нэг алхаснаа:

Чадахгүй нь ээ. Би өндрөөс айж байна. Түүний царай барайв. Гэвч дорхиноо зүгээр боллоо. Уилл яаран түүн дээр ирээд мөрнөөс нь тэврэв. Уучлаарай. Би мэдсэнгүй гээд түүнийг замын цаадах ойруу

дагуулан явлаа. – Тийшээ явъя. Надад шөнийн ой таалагдаж байна. Харин чамд?

Хүйтэн байна хэмээн Челси чичигнэн хэллээ. Түүний амнаас цагаан уур гарна. – Гэхдээ надад таалагдаж байна гэж Челси яаравчлан хэлэв. – Энд нам гүм байна. Гэрээсээ олон бээрийн алсад байгаа юм шиг санагдаж байна шүү.

Ой руу одох шороон зам дээрхи навчис тэдний пүүз доор сэрчигнэж байлаа. Түрүүчийн моднуудын доор ороод ирсэн чинь улам бүр харанхуй болчихов. Гэрэл алга болоод, сар хүртэл харагдахгүй байна.

Уилл явдлаа сааруулж Челсиг хэдэн алхмаар урдаа оруулчихав. Тэрбээр халааснаасаа хэсэг уяа гаргаж ирэн аяархан тэнийлгээд тас хийтэл нь татчихлаа.

## 11-р бүлэг

Уяагаа бэлдчихээд Челсиг гүйцэж очих гэж Уилл алхаагаа хурдасгалаа. Тэр эгчийнхээ тухай бодож байв.

Челси Женифертай адилхан юм. – Үгүй юмаа гэхэд тийм байхыг нь санаж байлаа. – Тэгээд чи ээжтэй хамт яваад өгсөн болохоор азтай байна даа, Женифер. Чамайг шөнө болгон согтуугаараа зоддоггүй байсан. Хаашаа ч зайлахын аргагүй тэр аймшгийг чи туулж үзээгүй. Ээж та хоёр ухаантай хандсан. Намайг хаяад зугтаачихсан. Надад хаашаа зугтсанаа хэлэлгүй. Бүр юу ч бичээгүй гээч. Утасдаагүй. Ээж та хоёр өөртөө үнэхээр сайхан амьдрал зохиосон доо! Тэгээд миний тухай мартчихсан. Харин би чиний тухай санаж байна шүү, Женифер. Би байнга чиний болон ээжийн тухай боддог. Чамаас л болж олон охид үхэх тавилантай болсон. Тэгээд ч тэд нар үхнэ. Эцсийн эцэст та нарыг хоёуланг чинь олох өдөр ч бас ирнэ. Тэгээд та нар ч бас үхнэ. Шөнө болгон миний үхэж байсантай яг адилхан. Шөнө болгон. Та нар өмнө нь үхчихдэг байж хэмээн яг надтай адилхан харамсах болно”.

Тэрбээр амаа ангайгаад цээж дүүрэн амьсгаа авлаа. Дараа нь амьсгаагаа даран Челси рүү араас нь дөхөж очоод охины хүзүүг оосорлох гэж уяагаа өргөлөө.



## 12-р бүлэг

Машины давхар гэрэл тэр хоёрыг хоёуланг нь айлгачихав.

Челси эргэж харлаа, харин Уилл уяагаа яаран хүрэмнийхээ халаасанд нуучихав.

Энэ чинь юу вэ? хэмээн Челси тэдний хуучин “Понтиак” дээр өөр нэг машин хүрээд ирсэнийг ойлгосон хирнээ шивнэлээ.

– Машины гэрэл... хичнээн айваа, хэмээн Челси Уиллын гараас барьж аван хэллээ. Бид хоёулахнаа байлаа, гэтэл...

Энд хэтэрхий олон хүнтэй болж байх шив гэж хэзээ хэзээнийхээс чанга инээн Уилл хэлэв. Явцгаая! Тэгээд түүнийг хурдан гэгч нь машин луугаа гараас нь хөтлөн аваачив.

Түүний зүрх нь дэлсэлж байлаа. Машины гэрэл харангуутаа л цагдаа нарын эргүүлийн машин түүний өдөр хулгайлж авсан хуучин “Понтиак”ийг хайж явна гэж айлаа.

Гэвч энэ цагдаа нар биш байв. Зүгээр л ахлах ангийн хүүхдүүд нялуурах газар хайж ирсэн нь тэр байлаа. Үр дүнд нь түүний төлөвлөгөөг нурааж хамаг үдшийг баллаж орхилоо. “Түүнийг гэрт нь хүргэж өгөөд машинаа хаа нэгтээ хаячихаас. Түүнийг дараа л нэг алахаас даа. Тэвчиж үз хэмээн охинд хаалга онгойлгон өгч инээмсэглэх аядан тэр өөрийгөө тайвшруулж байв. – “Тэвчиж үз. Өмнө маань олон үдэш байна. Түүний цаг нь ч бас ирнэ. Удахгүй”.

Тэрбээр машинаа асаан арагшаагаа ухарч зам руу орлоо. Дараа нь гэрлээ асаахад өмнө нь өтгөн ой хөшилдөн харагдана.

Челси чачвалзсанаа гараа пальтоныхоо халаасанд хийв.

Ямар сайхан юм бэ? хэмээн толгойгоо суудлын аравч дээр тавиад эвтэйхэн шиг тухалж аван мөрөөдөнгүй хэллээ. – Дээр үнэхээр сайхан байдаг юм байна!

Тийм ээ хэмээн Уилл замаа ширтэн хариулав. Челси өөрийгөө хэзээ ч ийм аз жаргалтай байж үзээгүй хэмээн бодлоо. Хуучин сургуульд байхдаа хүртэл үргэлж хүнийрхэж, ганцаарддаг байсан. Бямба ням гарагийн үдэш найз нарыгаа үдэшлэг, болзоонд явж байхад голдуу л гэртээ зурагтаа харж өнждөг байв. “Чи үснийхээ засалтыг өөрчилчихвөл яасан юм? Арай зоригтой, задгай хувцас өмсөж байгаач гэж охидуудтүүнийг шалдаг байлаа”.

Бүгдээрээ л эцэж цуцахгүй зөвлөгөө өгцгөөнө.

Гэвч тэр нь одоо түүнд хэрэггүй болсон. Тэр өөрөө түүнд яг үнэхээр таалагдаж байгаа бандитай болзоонд явдаг болсон. Түүнийг үнсэж, хотоос тэртээ өндөрт, голын эрэг дээр түүний төлөө романтик зугаалга зохион байгуулж өгсөн бандитай.

Аз жаргалдаа мансууран, амарлингуй байдалтайгаар Челси Уиллыг налан:

Хоёулаа манай гэрт очвол яасан юм, хэмээн шивнэлээ. Залуу тэр дор нь хариулсангүй. Бодол санаа нь хаа нэгтээ өөр газар нисч байгаа бололтой. Түүний хэлснийг огт сонсоогүй ч юм шиг Челсид санагдлаа. Эцэст нь Уилл:

Танай гэрт үү? хэмээн асуулаа. Тийм, Челси түүнд инээмсэглэнэ. – Гэрт хэн ч байхгүй. Ээж ажил дээрээ, аав эмнэлэгт байгаа. Тэрбээр нүдээ замаас салгалгүй ширтэж байсан боловч Челси түүний нүүрэнд инээмсэглэл тодрохыг ажиг. Тэгээд үүнээс болж түүний сэтгэл хичнээн тэнийгээд явчихваа! “Миний санал түүнд таалагдах шиг боллоо гэж Челси шийдлээ. Яагаад гэвэл би түүнд таалагдаж байна. Тэгээд би гэртээ ганцаархнаа надад таалагдаж байгаа эрэгтэй хүүхэдтэй хамт байна”. Түүний сэтгэлийг баяр хөөр, унтуурхал, түгшүүр нэгэн зэрэг эзэмдэж байв.

Челси агшин зуурт нүдээ анихад түүнийг харанхуй нөмрөн авлаа. Нүдээ нээвэл арай тайвширсан байв.

Охин Уиллд Аймшгийн гудамжинд байдаг гэртээ хэрхэн явж очихыг хэлж өглөө.

Челсигийн хаана амьдардгийг сонсоод үргэлж доог тохуу хийдэг банди нарыг бодвол Уилл огт тэгсэнгүй. “Тэр гудамжны тухай энэ огт мэддэггүй бололтой гэж охин бодлоо. Энэ хотод шинэхэн ирээд байгаа шүү дээ. Энд болдог гэж ярилцах аймшигт явдлуудын тухай юу ч сонсоогүй бололтой.”

Челси машинаасаа үсрэх шахам буулаа. Аймшгийн гудамжинд тэр ухаангүй хайртай байлаа! Энэ бол түүний амьдарч үзсэн хамгийн аз жаргалтай гудамж. Тэгээд өнөөдөр хамгийн аз жаргалтай үдэш!

Уилл гудамжаар түүний араас явж байлаа. Довжоо, шатан дээр маш харанхуй байв. Челси гэрээсээ гүйн гарахдаа чийдэнгээ асаахаа мартчихжээ.

Цүнхэн дотроо түлхүүрээ тэмтчин хайж байхдаа түүнийгээ шатан дээр унагаачихав. Хоёулаа харанхуйд тэмтрэн хайлаа. Челси түрүүлж шүүрч авав. Үүдээ арайхийж онгойлгохдоо Уилл түүний гар нь чичирч байгааг анзаарахгүй байлгүй гэж найдаж байв. “Би галзуурч байгаа юм байх даа хэмээн тэр бодно. Ингэтлээ сандрах ямар ч шалтгаан байхгүй шүү дээ”.

Челси үүдний өрөөний чийдэн асаав. Хүрмээ шатны хашлага дээр чулуудчихлаа. Мань эр халааснаасаа ямар нэг юм аваад хүрмээ түүний хажууд бас чулуудчихав.

Челси харанхуй зочдын өрөө рүү түрүүлэн орлоо. Буйдангийн хажууд байдаг унтраалга руу гараа явуулахад Уилл гарнаас нь ялдамхнаар барьж холдууллаа.

Охиныг амьсгаа авахын зуургүй тэвэрч аваад амьсгалыг нь боогдтол ухаан жолоогүй үнсэж гарлаа.

Уилл... – хэмээн Челси толгойгоо гэдийлгэн шивнэв. Түүний зүрх нь дэлсэлж, толгой эргэж байна.

Гэвч тэр түүнийг тавьсангүй. Ялдамхан боловч чанга барьж байлаа. Дараа нь буйдан дээр аваачаад дахин үнсэж эхлэв.

Челси чичирлээ. Нүдээ аниад дахиад том гэгч нь харлаа. Охин түүнийг харахыг хүсч байв. Бүхнийг харахыг хүсч байв. Хонгилоос орж ирэх бүдэгхэн гэрэлд ч байтугай, бүхнийг тогтоож авахын тулд харахыг хүсч байлаа. Үүрд тогтоож авахын тулд.

Охин дахиад чичирлээ. Тэгээд сая л чичирч байгаагаа ойлголоо. Машинаар явж, зугаалж байхдаа тэгтлээ даарсан байжээ. “Даарч байгаа тухайгаа бодож яаж болдог юм? гэж Челси өөрийгөө загнана. – Ер нь юуны ч тухай бодож яаж болдог юм?”

Уилл дахин түүнийг үнсэв, бүр хоёулангийнх нь амьсгаа боогдтол үнслээ.

Хонгилын гэрэл сүүмэлзэх шиг болов. Өрөө бүхэлдээ хазайгаад эргэлдэн, тэр хоёр шидэт хивсэн дээр өндөрт хөөрч, доор хөдөлж, эргэлдэж, хаашаа ч юм хөвөх харанхуй руу харна.

Челси амьсгаа авах гэж зайлсхийв. Тэгээд нүдээ анин Уиллын мөрийг дагзараа таатайхан налж суухад цаадах нь жинсэн өмднийхөө арын халааснаас уяа гаргаж ирлээ. Түүнийг хуруунуудаараа тайван гэгч шувтраад охиныг боож алах гэж зэхлээ.

## 13-р бүлэг

Гэнэт Челси год үсрэн хөл дээрээ бослоо.

Уилл уяагаа буйдан дээр унагачихав.

Би бүр ясандаа хүртэл даарчихаж, хэмээн тэр мөрөө тэврэн ноосон цамцныхаа ханцуйг үрдэж хэллээ. – Халуун шоколад бэлдвэл яасан юм бэ?

Уиллын харамссан харцыг хараад тэр гайхлаа. Түүний хацар хоёр тод улаан толбо болж хувирчээ.

Юу? Халуун шоколад хэмээн охин давгаж хэллээ. – Гал зуухны өрөөнд очоод өөрсөддөө халуун шоколад бэлдээдэхье. Тэгэх үү? “Тэр яагаад урвайчихсан байгаа юм бол? Аль эсвэл бишүүрхсэн юм болов уу? Надаас дутахгүй сэтгэл нь догдолж дээ! Тэгэлгүй дээ, түүний ч гэсэн анхны болзоо шүү дээ”. Тийм ээ. Сайн байна гэж Уилл сэргэж ирэн хариуллаа. Би тусалъя. Хэрэггүй гэж Челси хариулаад харанхуй өрөөг туулж гэрэлтэй хонгилын өрөө рүү явлаа. – Гэхдээ надтай хамт явж болно.

Танай нойлын өрөө хаана байна? гэж тэр гэнэт асуугаад босов.

Челси гараараа заачихаад гал зуухны өрөө рүү яравчиллаа. Гэрлээ асаачихаад данхандаа ус хийж пийшингээ асаалаа. Дараа нь сэнжтэй хоёр аяга ширээн дээр гаргаж тавиад шүүгээ рүү очиж дээд талын хаалгыг нь онгойлгоод нунтаг шоколадтай уутыг хайж эхэллээ.

“Анхны болзоо яг зохих номоороо явж байна хэмээн баярлан бодоод шүүгээн дээрхи гал тогооны том зэсэн цаг руу хялайн харлаа. Арван нэг дөч болж байв. – Ийм орой болсон нь харамсалтайяа. Энэ үдэш хэзээ ч битгий дуусаасай!”

Челсиг гоймонтой нимгэн уутнуудыг цаашлуулан шүүгээн дотор уудалж байх хооронд Уилл араас нь гэтэж очлоо. Тэр гартаа уяа барьжээ, гэхдээ чулуудахад амар гэж тэнийлгэн бариагүй. Челсигийн хүзүүнд углачихаараа хамаг чадлаараа тэнийлгээд түүнийг бүтэж үхтэл нь хүлээнэ.

Ингэхэд их цаг орохгүй. Үнэн хэрэгтээ энэ их хялбархан. Түүнийг РиверРижийн хадан дээрээс түлхчихсэн бол илүү хялбар байх байсан л даа. Тэр яг тэгэх гэж байсан. Ганцхан түлхчихэд л хамаг юм болоод явчих байлаа. Тэгээд л бүх юм түргэн, цэвэр болох байсан...

Гэвч охин түүний хүслийг биелүүлээгүй. “За яахав, ярвигтай шийдвэр шаардсан байдал үүсч л байдаг юм хэмээн Челсигийн араас өлмий дээрээ гэтэн бодож байлаа. Гэхдээ ямар нэг зүйл хийх юм бол хийсэн шиг хийх хэрэгтэй.”

Тэрбээр уяагаа өргөөд хулганын өнгөтэй үс рүү ширтэнэ.

Түүний гар салгалахгүй, бүр чичрэх ч үгүй байна.

“Яагаад гэвэл үнэндээ бол энэ миний анхны болзоо биш” гэж Уилл өөртөө тайлбарлаад уяагаа дээш нь өргөлөө. Дээшээ, дээшээ... Тэрбээр бүр охины нимбэгний үнэртэй сүрчигийг үнэртэхээр, цамцных нь захнаас цухуйсан шошгоны бичгийг уншиж болохоор ойртож ирлээ.

Уилл цамцныхаа шошгыг далдладаггүй охидыг үзэж чаддаггүй билээ. Эгч нь ч бас салан задгай байсан. Тэр цамцны шошгон дээрхи “том хэмжээ” гэснийг уншчихаад “Челси минь, баяртай!” – гэж дотроо хэлэн гараа урагш нь сунгалаа.

Гэтэл гэнэт хаалганы хонх дуугарав.

Ө! хэмээн Челси хашгирлаа.

Залуу гараа буулгаад арайхийж нүүрээ төлөв царайтай болгов.

Уилл... би чиний орж ирэхийг чинь сонссонгүй! хэмээн Челси амьсгаадан шивнэлээ. Дараа нь ширээн дээр нунтаг шоколадтай хоёр жижиг уут тавиад – Май. Үүнийг аяганууддаа хийчих. Би тэнд хэн ирсэн байна үзээдэхье.

Тэрбээр хорссондоо болоод шүдээ зуун байж охиныг харцаараа үдлээ, дараа нь тонгойгоод шалан дээрээс уяагаа авав.

Ялимгүй жаахан үлдээд байсан даа. Ёстой ялимгүй!

Уилл цагаа харлаа. “Ийм оройн цагаар хэн ирдэг билээ? Хэн бидний анхны... бас сүүлчийн... болзоог тасалдуулж чаддаг байна? Ээж нь үү? Үгүй. Эх нь хаалга тогшихгүй. Тэгээд ч Челси ээжийгээ шөнөжин ажилтай гэсэн”. Яриаг нь сонсох гэж тэр үүд рүү гэтлээ. Явдал дундаа уяагаа гартаа ороогоод.

Энэ орой болсон хойно хэн ирдэг билээ хэмээн гайхсан Челси хаалгаа угз татан онгойлголоо.

Нина! О, Челси хэмээн Нина гонгинолоо. – Надад чам дээр ингээд гэнэт ороод ирж байгаа маань маш их эвгүй байна. – Түүний нүд нь улайгаад, шулуун цайвар үс нь бүр сэгсийчихсэн байв. Юу болоо вэ? – хэмээн Челси хаалгаа барьсан чигээрээ асуулаа. Найз нь түүний хажуугаар тод гэрэлд нүдээ анивчсаар ороод ирэв. Дуг л байхгүй юу. Бид хоёр аймаар хэрэлдчихсэн. Челси, тэр намайг хаях гэж байх шиг байна. Тэгээд энэ удаа тоглоогүй бололтой. Ор л доо, гэж Челси алмайрсан байртай хэлээд Уиллыг гарч ирээгүй биз хэмээн гал зуухны өрөө рүү хялам хийлээ. “Энэ ч яг л Нина шүү. – хэмээн тэр унтууцан бодлоо. Гэв гэнэт орж ирээд л намайг завтай байна уу, ч гэж асуудаггүй. Гэтэл би болзоотой байвал яах юм? Дуг л гэх юм, өөр юуны ч тухай бодохгүй шүү”. Нина түүний харахыг мэдчихлээ.

О, Уучлаарай, Челси. Танайд хүн байгаа юм уу? Чи ганцаараа биш юм уу? – гээд Челсигийн араас гал зуухны өрөө рүү явлаа.

Би болзоотой байна хэмээн инээмсэглэлээ нууж чадалгүй Челси шивнэлээ.

Болзоо юу? хэмээн Нина лавлаж асуугаад өөрийгөө толинд харах гэж зогсов. Эрэгтэй хүүхэдтэй юу?

Челси найз өөдөө хөгжилтэй харцаар харна.

Уучлаарай хэмээн Нина гараа нүүр лүүгээ өргөн хэлэв. Миний бүр урам хугараад. Хэнтэй ч ярихаа мэддэггүй. Би уйлж уйлж машинаар жаахан явж байгаад, миний толгойд...

Тийшээгээ суу хэмээн Челси зочдын өрөө рүү заалаа. Би одоо хүрээд ирье. Чамайг түүнтэй танилцуулах гэсэн юм.

Нина тээнэгэлзэн зогссоноо найзынхаа үгэнд оров.

Челси гал зуухны өрөө рүү гүйлээ.

Уилл, би үнэхээр их харамсаж байна, хэмээн Нинад сонсогдохгүйг хичээн шивнэн хэллээ. – Бидний нууц уулзалтыг нууц хэвээр нь байлгаж болохгүй нь бололтой. Найз маань хүрээд ирлээ... – Челси зогтусан амаа ангайв.

Гал зуухны өрөөний хаалга дэлгээстэй байгааг хараад тэр их гайхлаа. Уилл алга болчихжээ.

## 14-р бүлэг

Чи арай аяархан тоглож болохгүй байна уу? – хэмээн хатагтай Ричардс мэдээний хэсэг дээр нээлттэй байгаа ням гарагийн сонинхоо дээгүүр харан асуулаа. – Би юм уншмаар байна.

Ээж ээ гэж Челси тэвчээр алдан зөрлөө. Саксофон дээр аяархан тоглож болдоггүй юм. – Тэр буйдангийнхаа өмнө тавьсан тавиур дээрхи нотнуудынхаа хуудсыг эргүүллээ.

Чи наад амгайвчийг нь авчихдаг юм уу? – гэж ээж нь сонингоороо нүүрээ халхлан санал болгов.

Та яагаад л дандаа намайг саксофон дээрээ тоглохоор тохуурхаж байдаг юм бэ? гээд Челси хөгжмийнхөө даруулуудыг хуруунуудаараа аяархан дарлан байж хоолны ширээний ард өмнөө сонингийн хуудаснуудыг дэлгэж тавиад сууж байгаа ээж рүүгээ өрөөний цаад булангаас харан уцаарлалаа.

Чамайг л толгой чинь эргэчихнэ гэж тэгж байна, хэмээн хатагтай Ричардс сонингийн цаанаас хариулна.

Та яагаад намайг хэзээ ч дэмждэггүй юм бэ? гэж Челси дуугаа хэдэн октаваар өндөрсгөн хэллээ.

Чамайг дэмжихийг хүсэхгүй байна хэмээн эх нь хариулав.

Наад саксофонд чинь үнэхээр дургүй! Челси хөгжмөө амандаа ойртуулаад тэгэхээс тэгэх гэж чанга орилууллаа. Эх нь сонингуудаа унагаачих шахан годосхийн босов. Тэгээд түүнийгээ тавиад охин луугаа ууртайгаар харлаа. Тэгснээ хоёулаа хөхрөлдлөө.

За яахав. Энх тайван хэмээн хатагтай Ричардс санал болгов.

Энх тайван. – Челси амгайвчаа хэлээрээ долоогоод Шейди сайдын сургуулийн хөгжөөнт дууны аяны өөрийнхөө хэсгийг давгах гэтэл утас дуугарлаа. Цочсоноо Челси саксофоноо газар тавиад утас луугаа очлоо. Утас л намайг аврах шив дээ! гээд ээж нь амьсгаа авснаа санаа амарсан байдалтай дуу алдав.

Хөөш, энх тайван маш богинохон байлаа шүү! хэмээн Челси хариулснаа утас авав.

Сайн уу! Би хэтэрхий эрт утасдаагүй биз? Челси Уиллыг байна гэж тэр дор нь ойлгосонгүй.

Сайн уу. Үгүй дээ. Бид аль эрт боссон.

Хэн ярьж байна? гэх ээжийн дуу өрөөний цаанаас асуув. Над руу ярьж байна гэж хариулснаа Челси ядахнаа бага зэрэг ч гэсэн тусгаарлах гэж хана руу эргэлээ. – Хүүш, чи өчигдөр хаашаага алга болчихвоо?

Юу? тэгэж асуусанд гайхсан боллолтой байлаа. За боль доо, Уилл гэж охин тэвчээр алдан

хэллээ. – Намайг

гал зуухны өрөөнд эргээд орсон чинь чи байгаагүй ш дээ. Юу болсон?

Юу? Чи намайг баяртай гэж хэлэхийг сонсоогүй юм уу?

Үгүй. Би чамайг дуудсан шүү дээ. Явлаа гэж хэлсэн. Тэгээд чи надад хариулах шиг болсон шүү дээ. Санахгүй байна уу? Тэгээд би бас чам руу өглөө утасдья гэсэн!

Челси ерөөсөө тиймэрхүү юм санахгүй байлаа. Сонсоогүй байж болох уу?

За... – Тэр самгардлаа. Түүний явчихсан байхыг мэдээд Челси маш их гомдсон. Тэгээд дараа нь Уилл бишүүрхээд Нинатай уулзахаас айсан юм байлгүй гэж бодсон. Эсвэл маш романтик болохоороо болзооныхоо нууцыг хадгалах гэсэн ч юм уу.

За яахав, би чамайг утасдсанд чинь баярлаж байна гэж эцэст нь хэллээ.

Наадах чинь хэн юм бэ? Эрэгтэй хүүхэд үү? гэж ээж сонингийн цаанаас асуулаа.

Ээж ээ, боль л доо гэж Челси гараараа утсаа таглаж байгаад гуйлаа.

Өршөөж хайрла! гэж эх нь дамшиглан маш чанга хэлсэн болохоор Челси Уиллын юу хэлснийг сонссонгүй өнгөрөөчихлөө.

Уучлаарай, Уилл хэмээн яриагаа үргэлжлүүлэв. Юу гэнээ?

Би өнөө орой уулзаж болох уу гэж асуусан юм. Ойлгож байна уу, зүгээр л түрүүчийнхээ болзоог дуусгах гэж.

“Тэр ямар эелдэг юм бэ”, гэж бодоод зөвшөөрөх гэсэн боловч завгүй гэдгээ санаад:

Чадахгүй нь ээ гэж тэр хариуллаа. – Би аавыгаа эмнэлэгт эргэх хэрэгтэй. Тэгээд сургууль дээр зөндөө гэрийн даалгавар өгсөн. Би Лаша багшийн бичгийн ажлыг хийж эхлээ ч үгүй байна.

Яасан харамсалтай юм бэ, Уилл үнэхээр харамссан нь дуунаас нь сонсогдоно.

Хм... Чи намайг маргааш орой ажлын дараа угтаж авч чадах уу? хэмээн өөрийгөө ямар их зоригтой болсноо гайхан хэллээ.

За. Тэгье, гэж Уилл зөвшөөрлөө. – Маш догь. Челси түүнд зоогийнхоо газрыг зааж өгөөд, долоон цагт хаана гэж хэлэв. Бас дээрээс нь түүнийг ирэхэд надаас шарсан төмс ханхална шүү, гэж сануулан хэллээ. Ажлын дараа түүнээс дандаа шарсан төмс ханхалдаг билээ. Тосны хиншүү үсэнд нь шингэчихдэг юм шиг байна.

Зүгээр, би шарсан төмсөнд дуртай гэж Уилл хариуллаа. Тэр хоёр бас түрүүчийн үзсэн киноныхоо тухай, сэрүүхэн агаарт голын эргээр хийсэн богинохон зугаалгын тухай,



сургуулийнхаа тухай бага зэрэг чалчлаа. Түүний утсаа тавих дургүй бололтой байгаа нь Челсид таалагдаж байлаа.

Утсаар ярьж дуусаад эргэж харснаа ээж нь сонингоо тавьчихаад түүн лүү харж байхыг ажин гайхлаа.

Чи найзтай болоо юу? гэж хатагтай Ричардс асуулаа. Ээж ээ, тэгтлээ их гайхаж яанаа? хэмээн Челси уцаарлан дуу алдав. – Би ч гэсэн эрэгтэй хүүхдэд таалагдаж болдог юм байгаа биз дээ? Уучлаарай гэж эх нь тэр дорхноо буулт хийж. – Энэ нөгөө чамтай болзоонд явсан хүүхэд үү? Нэрийг нь хэн гэдэг юм? Тийм. Уилл гэдэг юм гэж Челси толгой дохилоо. – Тэр бас манай сургуульд ирээд удаагүй байгаа юм. Ёстой сайн хэмээн ээж баярлалаа. – Би түүнтэй хэзээ танилцаж болох вэ? – Цаг руу харснаа сонингоо чулуудан: О, бурхан минь! Явах болчихож. Би өнөө өглөө бас нэг ээлжтэй гэж хатагтай Ричардс охиныгоо хариулж амжаагүй байхад хэлэв. Тэгээд хэдхэн минутын дараа хаалгаа хаагаад гарлаа. Эхийгээ яваад өгөхийг чагнаж байснаа Челси саксофоноо авлаа. Тэгээд гэнэт цонх руу хартал цас орж байна. “Ямар хачин аравдугаар сар вэ?” хэмээн саксофоноо мартаад үүдний хажуудах цэцэрлэг рүү харсан венец маягийн том цонх руу очлоо. Эрт орсон цас. Шувууны өд хиртэй сагсайсан том том цасан ширхэгнүүд аажуухан, сэлж байгаа мэт үүлгүй тэнгэрээс бууж байв. Ямар гоё юм бэ, яг үлгэрт гардаг шиг юм аа хэмээн охин бахдан харж байлаа. Цасыг сайн харж авах гэж шийдээд Челси үүд рүү гүйж очин хаалгаа угз татан онгойлгосноо дуу алдлаа. Довжооны шатан дээр дулаан оготор шинель өмссөн лагс биетэй бүдүүн эр зогсож байлаа. Тэрбээр давхар шилэн хаалганд бараг нүүрээ наалдуулаад охиныг урд өмнө үзэж байгаагүй хүйтэн харцаар харж байв.

## 15-р бүлэг

Челси арагшаагаа год үсрэн хаалгаа хаах гэлээ.

Эрэгтэй хүн хөх нүдээ онийлгов. Цасан ширхэг түүний цайвар үс, бутлаг цайвар хөмсөг, өргөн мөрөн дээр наалджээ. Тэр гараа өргөнө.

Челси зогслоо. Гарт нь юу байна? Юу харуулаад байна? Ямар нэг тэмдэг байна. Тэмдэгний дээд талд үнэмлэх дээр “ХМТ” гэсэн гурван үсэг байв.

Эрэгтэй хүн түүнд муу юм хийхгүй гэдгээ харуулах гэж байгаа мэт нэг алхам хойшоогоо ухраад, дараа нь дахин нэг ухарлаа.

Зүрх нь цохилж, яахаа шийдэж ядан Челси хаалгаа онгойлгосхийлээ. Гадаа орж байгаа цаснаас хүйтэн чийгтэй байв. Саарал тэнгэр доогуур, газраар хөшилдөнө.

Та юу хүсээ вэ? гэж охин хүссэнээсээ илүү огцом чанга асуув.

Чамайг айлгасанд уучлаарай хэмээн хэдийгээр Челси ийм том биетэй хүн тэнгэрийн нүргээн адил бүдүүн хоолойгоор ярина хэмээн хүлээж байсан ч тэр хүн нарийн дуугаар хэллээ.

– Би Холбооны мөрдөх товчооны төлөөлөгч Мартин байна. Эцэг эх чинь гэртээ байна уу?

Цасны завсраар Челси гадаа хар “Плимут” зогсож байхыг харлаа. Лав түүний машин биз. Төлөөлөгч Мартин өргөсөн гартаа тэмдэг, үнэмлэх хоёроо барьсаар л байна.

Тэд нар гэртээ алга байна хэмээн Челси жаахан саатасхийснээ түүний хөх нүд рүү харан хэллээ. Тэд нь булгийн ус адил тунгалаг байх бөгөөд түүнийг нэвт өрөмдөх мэт харж байв.

Чамд хоёр асуулт тавьж болох уу? Челси толгойгоо дохиод хаалгаа дэлгэсхийлээ. Тэр хүн тэмдгээ оготор шинелийнхээ халаасанд шургуулчихав.

Би удаан саатуулахгүй хэмээн тэр үүдний жижиг өрөөний “Уэлком” пүүсийн жижиг дэвсгэр дээр гишгэн хэллээ. – Чиний нэрийг хэн гэдэг вэ?

Челси нэрээ хэллээ.

Тэрхүнгялалзталньцэвэрлэсэнгутлааүүднийдэвсгэрдээрнямбай гэгч нь арчив. Дараа нь том гараа өргөөд үснийхээ цасыг сэгсэрлээ.

Би асуудалд ороо юу? хэмээн түүний гутлыг тойрон бий болж байгаа жижиг шалбаагыг харан асуув.

Төлөөлөгч инээмсэглэлээ, түүний цэнхэр нүд гэрэлтэж хором зуур зөөлөрлөө. Тэр толгойгоо сэгсрэв.

Яалаа гэж дээ. Хамтрагч бид хоёр энэ дүүргийг самнаж байгаа юм гэснээ, тайлбарлаж, Ойлгож байна уу, нэг байшингаас нөгөө рүү явж... Бид нэг залууг олох даалгавартай явна.

Залуу юу? Челси элгэндээ гараа зөрүүлж барилаа. Хэн нэг нь харсан байж магадгүй гэж бид найдаж байгаа юм хэмээн төлөөлөгч Мартин үргэлжлүүлэв, Тэр хүн Челсигийн толгой дээгүүр гал зуухны өрөө рүү харлаа. – Чи Шейдисайдын сургуульд явдаг уу? Тийм ээ хэмээн охин хариуллаа. – Зөвхөн өнгөрсөн сараас. Бид энэ хотод саяхан нүүж ирсэн л дээ. Сайхан хот шүү, хэмээн Мартин хөндий хэлэв. Челси тэр хүнийг үнэн хэлж байна уу, эсвэл тоглож байна уу гэдгийг хэлж мэдэхгүй байлаа. Тэр хүн охин луу харна. – Магадгүй чи тэр залууг харсан байж болох юм. Тэр хүн дунд зэргийн нуруутай, дунд зэргийн жинтэй, бэлтгэл дасгал хийдэг бололтой. Түүний гар нь сайн хөгжсөн, хүчтэй цээжтэй. Буржгар хар үстэй. Бараан, бараг хар нүдтэй. Түүнийг сүүлийн удаа харахад цэнхэр жинсэн өмд, хар савхин хүрэмтэй байсан. Мэдэхгүй л юм даа, хэмээн Челси хариуллаа. – Олон хүүхэд тийм гадаад төрх байдалтай байдаг шүү дээ. Бодоодхооч хэмээн Мартин гуйлаа. – Сургуульд чинь тийм залуу бий юу? Чи ажилладаг уу? Ажил дээр чинь тийм төрхтэй хүн байдаг юм биш биз дээ?

Энэ үгийг сонсоод Челсигийн санаанд танил нүүр харагдах шиг боллоо.

Тим Спаркс! гэж саналаа. О, Бурхан минь! Тэр чинь энэ дүр төрхөнд яг таарч байна шүү дээ!

Тэр залуу маш аюултай... эсвэл ямар нэг хэрэг тарьчихаа юу? хэмээн хоолойгоо чичирч байгааг нууж чадалгүй асуулаа.

Төлөөлөгч Мартин толгой дохив. Челсиг ажиглаж байх зуурт түүний царай барайж, хүйтэн хөх нүд нь зурвас төдий болтлоо онийлоо.

Тиймээ, маш аюултай гэж тэр мэдээллээ, Түүнийг Шейдисайдад байгаа гэсэн маш ноцтой шалтгаан бидэнд байгаа.

Челси бас өөр юм асуух гэснээ шийдэж чадахгүй байв. Тэр яахаа мэдэхгүй байлаа. Мартинд Спарксын тухай хэлэх үү, яахав?

Хэрэв гаднах төрхөөрөө тиймэрхүү хүнтэй уулзаж байсан бол чи надад түүний тухай хэлэх ёстой хэмээн төлөөлөгч Мартин түүний бодлыг уншсан мэт хэллээ. Тэрбээр хөлөө тавьж гишгэлэн хагас шинелийнхээ халаасанд гараа хийгээд хариу хэлэхийг нь хүлээж Челсигийн нүд рүү анхааралтай ширтэнэ.

Та хар буржгар үс гэсэн үү? хэмээн цаг хожих гэж Челси давтан асуув. – Тэгээд бэлтгэл дасгал хийдэг мэт харагддаг гэв үү?

Тэр толгойгоо дохилоо.

“Спаркс надад дандаа их аюултай юм шиг санагддаг байсан хэмээн тэр бодлоо. – Тэгээд аягүй бол үнэхээр аюултай байх.”

Миний ажилладаг аавын зоогийн газарт хэд хэдэн удаа нэг залуу ирж байсан хэмээн Челси

аажуухан хэллээ. – Тэгээд таны тэр хэлсэнтэй дүр төрх нь тохирч байх шиг байна. – Охин гараа буулгаад, түүнийг яахаа мэдэхгүй байснаа элгэндээ эвхэн барьлаа.

Төлөөлөгч Мартин өврөөсөө жижигхэн тэмдэглэлийн дэвтэр гаргаж ирээд нэг юм бичиж авна.

“Яг телевизийн кинон дээр гардаг мөрдөгч шиг юм аа” – гэж Челсид санагдлаа.

Тэр залуу нэрээ хэлж байсан уу? хэмээн Мартин тэмдэглэлийнхээ дэвтэр лүү харан асуулаа.

Тийм ээ, Спаркс. Тим Спаркс. Надад өөрийгөө Спаркс гэж дуудаж бай гэсэн. Бүгдээрээ түүнийг тэгж нэрлэдэг гэж хэлсэн.

Спаркс, хэмээн давтан Мартин тэмдэглэлийнхээ дэвтэр дээр бичиж авлаа.

Тэр өмнө нь таагүй явдалд орж байсан юм уу? – хэмээн Спарксыг төсөөлөн, хэрхэн уурладгийг нь санаж асуулаа.

Төлөөлөгч Мартин хариулсангүй.

Чи түүнтэй уулзаж байсан уу? Үгүй! хэмээн Челси хүсэж байснаасаа арай чанга хэлчихэв.

– Үгүй хэмээн давтлаа. – Хоёрхон л удаа түүнтэй ярилцаж байсан. Зоогийнхоо газарт. Тэр хоёрхон удаа л ирж байсан. Челси, тэр өөрийгөө хаана амьдардаг гэдгээ хэлж байсан уу? Охин толгой сэгсэрлээ.

Санахгүй байна. Үгүй. Ажил хайж байна гэж хэлж байсан. Охиноос хараа салгалгүй Мартин бас энэ мэдээллийг бичиж авав.

Тэр чиний сургуульд сурдаг уу? хэмээн дэвтрээ буулган шинэ асуулт тавилаа.

Юу? Чиний сургуульд, Шейдисайдын дунд сургуульд. Чи тэр Спаркс гэдэг залууг хэзээ нэг цагт сургууль дээр харсан уу? Тэр хорин настай, гэхдээ арван долоотой юм шиг харагддаг. – Мартин Челсиг юу гэж хариулахыг нь тэвчээртэй хүлээж байлаа.

Үгүй, хэмээн тэр хариуллаа. – Зөвхөн зоогийн газарт л. Тэр бас зоогийн газрын нэрийг, түүн лүү хэрхэн яаж очих тухай асуув. Челси тайлбарлалаа.

Чи бидэнд маш их тусаллаа хэмээн төлөөлөгч Мартин дахин хөлөө солбин гишгэлэн магтаж хэлэв. Тэр тэмдэглэлийнхээ дэвтрийг үзэгтэйгээ цамцныхаа халаасанд шургуулчихаад нэрийнхээ хуудсыг өгч – Хэрвээ ямар нэг анхаарал татсан зүйл санах юм бол миний хамтрагч юм уу над руу утасдаарай. Утасны дугаар энэ хуудсан дээр байгаа.

Дараа нь эргэж хараад зогсож байсан газраа хоёр жаахан бараан шалбааг үлдээгээд гарлаа. – Хэрэв түүнийг дахиж харах юм бол над руу утасдаарай... за юу?

За, хэмээн Челси гартаа нэрийн хуудсыг чанга атган хариуллаа.

Тэгээд өөрийгөө аюулд битгий өртүүлээрэй хэмээн Мартин гудамж руу шагайн хэлэв.

Цас орохоо больжээ. Газар дээр түүнээс ямар ч үл мөр үлдсэнгүй. Мартины хамтрагч нь бололтой бараан өнгийн оготор шинель өмссөн хүн “Плимут”-ын хажууд хүлээж байна.

Аюулд аа? хэмээн Челси лавлан асуув. Хэсэг хугацаанд болгоомжтой байгаарай хэмээн Мартин хоёрдох хаалгыг онгойлгохдоо тайлбарлан хэллээ. – Тэр залуу Спарксыг харах юм бол шууд над руу утасдаарай гээд тэр хаалгаа араасаа чанга саван хаачихлаа. Челси төлөөлөгчийг том том, зөөлөн алхлан хашаагаар цааш явахыг ажин зогслоо. Түүний оготор шинелийн хормой ард нь дэвэрч байв. Дараа нь үүдээ хааж түгжээд, гартаа нэрийн хуудас атгасан чигээрээ түүнийг нүдээ анин налж зогслоо. Спаркс үргэлж түүнд догшин хүн мэт санагддаг байсан боловч түүнийг аюултай, эрэн сурвалжлагдаж байгаа гэж хэзээ ч толгойд орж ирдэггүй байсан. Ямар аймаар юм бэ! Хэрвээ түүнтэй хамт болзоонд явсан бол яах байсан бол? Тэр түүнийг яах байсан бол? Гэтэл “Спаркс зоогийн газар дахиад хүрээд ирвэл яанаа?”

гэсэн аймшигтай бодол түүний толгойд гэнэт орж ирэв. – Тэгвэл би яах вэ?”

## 16-р бүлэг

За тэгээд өнөөх нууцлаг хөвгүүн хаана байна? – гэж Нина сандлаа ширээ рүүгээ татахдаа хөлөөр нь шал зуран сониучлан асуулаа. Тэрбээр бор цаасан уутнаас өдрийнхөө хоол болох ванильтай йогурт, алим гаргаж ирлээ.

Тэр өнөөдөр ангидаа ирсэнгүй, хэмээн Челси баяр хөөргүйхэн хэллээ. Түүний өдрийн хоол – гахайн давсалсан махтай талх, шарсан төмстэй уут, аягатай шоколадны пудинг, кокакола өмнөх ширээн дээр нь байлаа. “Нина намайг жинхэнэ гахай гэж бодно доо гэж түүний толгойд орж ирлээ. – Гэхдээ зөвхөн йогурт, алим идэх юм бол өдөржингөө өлсгөлөн явна шүү дээ!”

Миний йогуртнаас амсах уу? хэмээн Нина асуулаа. – Би яасан ч бүтэн аяга йогурт барахгүй.

Үгүй, баярлалаа хэмээн Челси хачиртай талхнаасаа хазан татгалзлаа. Тэрбээр Нинаг цохиод авахаасаа арайхийн биеэ барьж байлаа.

Цаадахь нь хайнгадуухан гараа ширээний цаанаас сунгаж Челсигийн шарсан төмснөөс авлаа.

Тэгээд надад Уиллын тухай яриач дээ хэмээн хоолны өрөөний давхар хаалганаас хараа салгалгүй асууж байв.

Тэр маш зориг муутай хэмээн Челси эхэллээ. – Тэгээд хөөрхөн. Түүний нүүр нь байсхийгээд л час улайгаад явчихдаг юм.

Хөөрхөн хэмээн Нина сонсон аядан давгаж байлаа. Чи одоо хэнийгээ хараад байна? – хэмээн Челси унтууцан асууснаа кокаколанаас том балгав.

Дугийг хэмээн Нина дахин шарсан төмснөөс атгаж аван хэллээ. Өчигдөр орой бид хоёр эвлэрсэн.

Ёстой догь! хэмээн Челси баярлан өгүүлэв. – Ирэх сайн өдөр дөрвүүлээ нэг юм бодох уу?

Ахаан, хэмээн Нина бараг сонсохгүй толгойгоо дохино. Хүүш ээ, бямбын орой би танайд ороод ирсэн чинь Уилл яасан бэ? Яагаад алга болчихсон бэ?

Челси юу гэж хариулахаа мэдэхгүй байлаа. Тэгээд жаахан азнаснаа энэ бол түүний анхны болзоо байсан, тэгээд Уилл анхныхаа оройн онцгой болзоог нууцлах гэсэн юм хэмээн тайлбарлалаа.

Жигтэй юм хэмээн Нина тайлбарлалаа. Тэгснээ гэнэт үүдэнд Дугийг харснаа огло харайн босоод түүн лүү гүйлээ.

Челси Нинагийн дутуу үлдээсэн йогуртыг харан, Уиллын тухай бодсоор хачиртай талхааажилж байлаа. Өнөөдөр яагаад ангидаа ирээгүй нь ойлгомжгүй байна. Гэнэт өвдчихсөн юм болов уу? Тэгвэл түүнийг ажлын дараа ирнэ гэж найдсаны хэрэггүй болох нь ээ.

Челсид түүнтэй уулзаж, яримаар маш их санагдана. Тэрбээр ХМТ –ын жинхэнэ төлөөлөгчтэй уулзаж ярьсан тухайгаа, Спарксын тухай юу мэдэж байгаагаа, түүнийг маш их аюултай, эрэн сурвалжлагдаж байгаа, түүнтэй хамт кинонд явчих шахсан тухайгаа ярих юмсан гэхээс тэсч ядаж байлаа. “Уиллд миний ярьсан зүйл таалагдана даа хэмээн тэрбээр бодож байлаа. Надад сонирхолтой байгаагийн адил түүнд ч гэсэн таалагдана. Тэр бид хоёр маш адилхан шүү дээ!”

Тэр орой зоогийн газар пиг дүүрэн хүнтэй байв. Челси үйлчлүүлэгч нарт хамаг анхаарлаа хандуулж чадахгүй байлаа. Тэрбээр юм л бол неон гэрэлтэй цаг руу харж, Уилл болсон цагтаа ирэх болов уу гэж тааж ядаж байлаа.

Аваарай! хэмээн гал зуухны өрөөнөөс Эрни хашгираад хоолтой тавгаа тавьдаг төмөр лангууг алгадна, Чи чинь дүлийрчихээ юу?

Уучлаарай гээд тэр хоолтой тавагнуудыг авах гэж яаравчлав.

Чи өнөөдөр ямар хачин байна? хэмээн Эрни шүднийхээ чигчлүүрийг аман дотроо эргэлдүүлэн байж хяхтналаа. – Дурлачихаа юу?

Челси инээгээд нүүр нь шатаад явчих шиг болохыг мэдэрлээ. Тэгснээ дахиад цаг руу харлаа. Дөнгөж зургаа хагас.

Түүнийг гал зуух руу бөөн таваг аваад явж байтал хэн нэг нь түүний мөрийг алгадав.

“Спаркс!” Челси дуу алдан хашгирлаа, тавагнууд нь гарнаас нь тар няр хийн унаад газраар нэг өнхрөлдлөө.

Охин эргээд хартал түүнийг тэвдэн ширтэх дунд насны эрэгтэйг харав. Тэр Спаркс биш байлаа.

О, уучлаарай, авхай хэмээн тэр эр хэллээ. – Би таныг айлгах гээгүй юм. Зүгээр л кетчуп гуйх гэсэн юм.

Челси санаа амран амьсгаа авлаа.

Уучлаарай, би хашгирах гээгүй юм. Зүгээр л... Тэр хүн түүнтэй хамт тонгойн хагархай сав суулганы хэлтэрхийнүүдийг хамж эхэллээ. Хэрэггүй, хэмээн Челси түүнийг болиуллаа. Зүгээр. Би өөрөө үүнийг хийе. Нээрээ шүү. Энэ чинь миний ажил гэсээр түүнийг тасалгаа руу нь явууллаа. Дараа нь том том шаазангуудыг нь хамж аваад жижгүүдийг нь асгарсан хоолны шавхруутай нь хамт хамж шүүрдээд хогийн сав руу хийчихлээ. Зоогийн газар хаагдахын өмнөх хагас цаг Челсигийн амьдралын хамгийн урт удаан хугацаа мэт санагдлаа. Гал зуухны өрөөнд утаа уур савссан шарах тогооны ард зогссон Эрни түүнийг шоолсоор, дотроо инээж, малийтал инээмсэглэн, нүдээ ирмэж байсан болохоор түүнд цаг улам удаан өнгөрч байгаа мэт санагдана.

“Тайван бай, тайвшир” хэмээн Челси өөртөө байн байн хэлэх боловч энэ нь тус болохгүй байв.

Долоон цаг өнгөрөөд зоогийн газар хоосорч ирснээ эцэст нь хүнгүй болов. Челси гэрлүүдээ ихэнхийг нь унтраачихаад касснаас мөнгөө аваад өдрийнхөө орлогыг байрныхаа нөгөө талд байх татдаг нэг нүдтэй шүүгээ рүү аваачлаа. “Гэвч Уилл хаана байна? Аль эсвэл өвдчихсөн юм болов уу? гэж тэр бодно.

– Тэгээд өнөөдөр хичээл дээрээ ирээгүй юм болов уу?” Челси гэртээ очингуугаа түүн лүү утасдахаар шийдлээ. Хэрвээ түүнийг зоогийн газар хүрээд ирэхгүй бол шүү дээ.

Тэрбээр Уиллын тухай бодсон хэвээр мөнгөө тоолох гэж хичээснээ тоогоо алдаад дахиад л тоолж эхэлнэ. Тэгснээ шарах тогоог цэвэрлээгүй, бүр унтраагаа ч үгүй байхыг харлаа. Тогоо чимээгүйхэн шажигнаж байв. Түүнээс өөр чанга дуу гэвэл хананы тэнд байх том хөргөгчний чанга хүнгэнэх дуу, заваан сав суулга дүүрсэн төмөр угаалтуур луу ус зогсоо зайгүй дуслах чимээ байлаа.

Эрни хаачаа юм бол? хэмээн Челси гайхлаа. Бодвол хажуугийн гудам руу хогоо асгах гэж гарсан бололтой байлаа. – Тэр дахиад л тоогоо алдчихлаа. – За яахав, дахиад нэг удаа тоолоодохье” гэж өөртөө хэлснээ орох хаалга дуугарахыг сонслоо.

Хаалганы хонх аяархан жингэнэв. Челси биеээ цэхлэлээ. Уг нь Челси мөнгөө тоолохдоо орох хаалгаа түгждэг билээ. Харин өнөөдөр Уиллыг ирэх байх гээд түгжээгүй юм. Хаалга аяархан хаагдлаа. Ойртон ирэх хөлийн чимээ дуулдав. Уилл? – хэмээн Челси гал зуухны өрөөнөөс чанад сонсогдохгүйгээр аяархан дуудлаа. Алхах нь зогслоо.

Уилл? – хэмээн тэрбээр арай чанга давгав.

Дахиад л хөлний чимээ, ваарласан шалан дээр хөл чирэх чимээ сонсогдоно.

Уилл, энэ чи юу? – “Бурхан минь, тэр яагаад хариу хэлэхгүй байна?” Челси айгаад багцалсан мөнгөө хайрцганд хийж түргэхэн шиг хаагаад түгжчихэв. Тэгээд зүрх нь галзуу юм шиг дэлсэхийг мэдрэн харайж бослоо. Эрни хаана байна? Лав том хогийн савны дэргэд тамхилж байгаа биз. Яахаараа түүнд аюул тулгарах болгонд л алга болчихдог байна?

Уилл, би одоо очлоо! – хэмээн хашгирчихаад толгойгоо бөхийлгөн харанхуй зоогийн газар луу гал зуухны намхан цонхоор шагайлаа. Хэн ч харагдахгүй байна. – Уилл? – Тэнд Уилл байх ёстой. “Энэ Уилл л байгаасай билээ”.



## 17-р бүлэг

Гүнзгий амьсгаа аваад Челси гал зуухны өрөөнөөс гарч урт лангууны ард очоод зогслоо.

Хэн бэ? – хэмээн тайван хэлэхийг хичээн асуулаа. – Уилл?

Сүүдрээс Спаркс гарч ирлээ, тэр нэг гараа нэгдүгээр тасалгааны сандалны түшлэг дээр тавьжээ. Нүүрэнд нь хачин инээмсэглэл тодорно.

Челси лангууны ирмэгнээс зуураад хөшчихөв. Тэр яагаад ингэж хачин инээмсэглэнэ вэ? Түүний нүүрийг сүүдэр халхалж байсан боловч охин түүний гялалзах хар нүд, хорсолтой харцыг харж байлаа.

Спаркс... чамд юу хэрэгтэй вэ? хэмээн Челси айсандаа хоолой нь боогдох шахан хашгирлаа.

Ойртож ирэхдээ тэр асар том харагдана. Тэгээд аймшигтай.

Спаркс түүн лүү нэг алхлаа. Дахиад нэг. Челси түүний бараан нүд ямар ч юм, усархаг болсныг ажиглав. Тэр хөхөрлөө.

“Намайг айлгах гэсэн юм болов уу? хэмээн түүний толгойд зурсхийн орж ирлээ. – Хэрвээ тийм бол энэ нь муугүй болж байх шив”.

Охин гараа хормогчныхоо доогуур жинсэн өмднийхөө халаасанд шургуулаад Мартины нэрийн хуудсыг тэмтэрлээ.

Спаркс? Чи зүгээр үү? Тэр дахиад хөхөрч, ямар ч юм нэг нарийхан, бараг амьтны гэмээр авиа гаргаснаа лангуу руу дахин нэг сулхан алхлаа.

Нааш ир хэмээн Спаркс Челси өөд ширтэн хэлсэн боловч хараа нь тогтож чадахгүй байгаа харагдана.

Спаркс... чи согтуу байна хэмээн Челси хана налтлаа арагшаагаа ухран буруушаангуй хэллээ.

Хэдхэн аяга шар айраг ш дээ хэмээн тэр мөрөө эв хавгүй хавчин тайлбарлав. – Алив наш ир, сайн хүүхэд байгаач.

Үгүй. Зайл хэмээн Челси ширүүн хэллээ. Би тоглоогүй байна шүү.

Залуу толгойгоо сэгсэрлээ. Түүний нүүр уур хилэнтэй болчихож.

Хөөш, чи зүгээр бай хэмээн тэрбээр лангууны хажуугийн мухар сандал налан байж хэллээ. – Би чамд таалагддаг ш дээ.

Спарксаас хараагаа салгахгүй, түүний юу хийх гэж байгааг үл мэдэн Челси төлөөлөгч Мартины захин хэлснийг бодож байлаа. Спарксыг аюултай юу гэж асууж байхад ХМТны

төлөөлөгчийн нүүр царай ямар байсныг тэр мартаагүй. “Тийм ээ, тэр аюултай. Маш аюултай” хэмээн төлөөлөгч хариулсан.

“Тэр ямар хэрэг тарьчихсан юм бол? Ямар гэмт хэрэг хийсэн юм бол? ХМТны төлөөлөгчид хойноос нь хөөцөлдөж явахыг бодоход маш аймаар юм хийсэн байх аа” хэмээн тэр шийднэ.

Хөөш... нааш ир гэм хэмээн Спаркс энэ удаа нилээн шаргуу давгаж хэллээ.

Түүнийг лангуун дээгүүр тэгнэхэд Челси түүний духанд хөлс бурзайсан байхыг ажиглав.

Спаркс, гуйж байна... – хэмээн охин эхэллээ. Түүний нүүр маасайн инээмсэглэв. Гэнэт тэр охин луу ухасхийснээ лангуу мөргөчихлөө. Эрни! – хэмээн Челси орилов. Ухаан жолоогүй айж сандран тэр гал тогооны өрөө рүү гүйгээд орлоо. Хаалгаар гүйн ороод, зогсож, эргэн харав.

Спаркс юу болж байгааг ойлгохгүй, сэхээ авах гэсэн мэт толгойгоо сэгсрэн зогсоно.

Хүүш... би зүгээр тоглож байна ш дээ! хэмээн тэр хашгирлаа.

– Зүгээр тоглосон юм. Нааш ир! Түүний дуудахыг үл тоомсоорлон, айснаасаа ухаан алдах шахаад Челси гал тогооны шалыг бүрсэн урт хар хаймар дэвсрэг дээгүүр таварцаглан байж гүйв. Цаг эрт байна. Найман цаг ч болоогүй байхад Олд Виллижийн гудамжнаа хүмүүс дүүрэн байгаа байх. Намайг уучлаач! – хэмээн Спаркс хашгирлаа. Одоо тэр гал зуухны хаалгыг хүчтэй хоёр гараараа алдлан гарах замыг нь хаагаад зогсож байлаа. Түүний нүд нь хажуугаар нь гүйлгэнэн харна. Зайл! Намайг зөнд нь орхи! хэмээн Челси хариулаад арын хашаа руу гардаг хаалганы бариулыг зууран авч өөр лүүгээ татлаа. Хаалга огт хөдөлсөнгүй. Түүнийг хүнд төмөр оньсоор түгжээд, дээрээс нь түлхүүрээр бас цоожилсон байв. Челси урхинд оржээ. Хүүш, би чамд юу ч хийхгүй хэмээн Спаркс түүн лүү чанга биш хөл дээр алхлан дөхөж ирлээ. Би зүгээр л тоглосон юм. Чи тогломооргүй байна гэж үү? Спаркс... гуйж байна... зайлаад өгөөч! хэмээн хормогчоо тайлан газар хаяад гуйлаа. “Зөвхөн хажуугаар нь зөрж гараад л эндээс гарч болно хэмээн охин шийдлээ. Тэр хөл дээрээ муухан тогтож байгаа болохоор үүнийг хийхэд тийм ч хэцүү биш бололтой”. Тэгээд урт гэгч нь амьсгаа аваад шууд Спаркс өөд гүйв. Тэр нүдээ том хараад инээмсэглэлээ. Челсиг бариад авах санаатай гараа тэнийлгэнэ. Гэвч охин шаржигнасаар байгаа халуун тогоог мөргөх шахан хажуугаар нь бултан гарлаа. Спаркс чанга инээснээ түүний араас ухасхийсэн боловч Челси бултаж амжлаа. Гэтэл тэр чанга цохих, дараа нь чанга шаржигнах чимээ сонсов. Эргэн харснаа Челси Спарксыг утаа суунаглах улайссан халуун тогоо мөргөөд гар нь бүр торон дээр байхыг харлаа.

Спаркс амаа ангайв. Түүнээс нь бөглүү дуу гарснаа дараа нь Спаркс зэрлэг араатан адил гасаллаа.

Миний гар! Миний гар! – хэмээн өвдсөнөөсөө болон бөхийгөөд, өвдгөөрөө газар сөхрөн цангинасан хоолойгоор хашгирлаа.

Челси үүднээ зогтусав.

Миний гар! Яасан их өвдөнө вэ! хэмээн Спаркс газар өнхрөн байж хашгирна.

“Түүнд туслах хэрэгтэй хэмээн Челси шийдэн гал зуух руу эргэлээ. – Би түүнд туслах хэрэгтэй. Дараа нь яахав, ХМТруу утасдья”.

Охин Спарксыг босгоод угаалтуур луу аваачив.

Алив, Спаркс аа, Челси ус гоожууллаа. Хүйтэн ус. Хүйтэн усан доор гараа байлгаж бай. Би 911 – рүү утасдья. Түргэн тусламж дуудья.

Аяархан ёолсноо өвдсөндөө нүдээ аниад Спаркс түлэгдсэн гараа дуулгавартайгаар хүйтэн усан доор тослоо.

Чи хаашаа явах нь вэ? – хэмээн арай ядан тэр асуулаа. “Түргэн дуудья. Одоохон ирнэ. – Челси гүйж гаран, лангууны буланд байсан утас аваад нэрийн хуудас гаргаж ирэх гэж халаасаа уудаллаа. “Эхлээд төлөөлөгч Мартиныг дуудчихья” хэмээн тэр шийдлээ. – дараа нь 911 – залгая.” Чичирсэн гараараа тэр нэрийн хуудсан дээр бичсэн дугаарыг залгачихаад харилцуурыг нь чихэндээ наалдуулаад гал зуухны өрөөний хаалга руу эргэн харлаа. Спаркс өвдсөндөө болоод нүүрээ үрчийлгэн түлэгдсэн гараа усан доор тоссон хэвээр зогсож байна. Дүнгэнэх дуу сонсогдлоо. Нэг, хоёр...

Алив! Утсаа аваач! хэмээн Челси Спарксыг ажиглангаа гуйж байлаа.

Төлөөлөгч Форрест байна, гэх баргил дуу харилцуурын цаад талаас сонсогдлоо.

Мм... төлөөлөгч Мартинтай ярьж болох уу? – хэмээн Челси Спаркст сонсогдохгүй гэж харилцуураа алгаараа халхлан шивнэж асуулаа.

Үгүй, тэр гараад явчихсан, хэмээн эрсхэн хариулт сонсогдлоо. – Юугаар тус болж болохсон бол?

Би Челси Ричардс байна. “Бүх одод” зоогийн газрын. Гуйя...

Түлэгдсэн гараа урдаа бариад Спаркс араас нь хүрээд ирлээ.

О! – хэмээн Челси айсандаа хашгирчихлаа. Яанаа, тэр бүгдийг нь сонсчихсон гэж үү?

Чи утасдав уу? “Түргэн” ирж байна уу? – хэмээн Спаркс сулхан дуугаар асуув, түүний нүүр нь өвдсөндөө болоод үрчийсэн, хөлс нь цутгачихсан байлаа.

Спаркс, буцаж очоод гараа хүйтэн усан доор барьж бай хэмээн Челси харилцуур луугаа, ХМТны төлөөлөгчийг Спарксын нэрийг сонсог гэж хэллээ. Би “түргэн” дуудаж байна.

Харилцуурын цаад талд хэсэг дуугуй байв. Дараа нь төлөөлөгч Форрест:

Бид нар одоохон очлоо. Түүнийг өөр дээрээ байлгаж байгаарай. Бид бас “түргэн” дуудаадахья”. Танд аюул тулгарч байна уу?

Үгүй байх гэж бодож байна, хэмээн Челси шийдэмгий бус хариуллаа.

Бид мөд очно. Холбоо тасарлаа. Спаркс ойролцоох тасалгааны сандал дээр лаг хийн суув.

Түлэгдсэн гарынхаа алгыг ширээн дээр тавьчихаад тэрбээр аяархан ёолж байлаа.

Челси бүх чийдэнгүүдээ асаачихаад, лангууг тойроод тасалгааны хажууд зогсов.

Тэд нар ирж байна уу? хэмээн Спаркс арайхийн сонирхож асуулаа.

Челси толгой дохив.

Гараа харуул даа. Охин түүнийг сайн харах гэж тонгойлоо. Гар нь улайгаад хавдчихаж. Хэдэн газар арьс нь хуулраад задгай шархнаас нь шүүс гарч. Тос наалдсан газар арьс нь түлэгдээд харласан байв. Хэдэн секундын дараа Челси өөрийн эрхгүй

нүдээ бурууллаа. Урт амьсгаа авч дотор муухай оргисныг давах гэж оролдоно.

Маш муу байна хэмээн охин арайхийн хэлэв. Спарксыг босоход тэр их гайхлаа. Тийм ч муу биш байна хэмээн тэр харц бууруулан хэлэв.

Би явсан нь дээр байх аа.

Үгүй! хэмээн Челси хэтэрхий чанга хашгирчихав. Спаркс түүн лүү сэжиг төрсөн байдалтай харлаа. Одоохон энд “түргэн тусламж” хүрээд ирнэ хэмээн Челси тайлбарлалаа. Чамд эмчийн тусламж хэрэгтэй. Энэ чинь маш аюултай түлэгдэлт.

Залуу таварцаглан үүд рүү алхлаа.

Үгүй, бүх юм зүгээр болно. Би гэртээ очоод гараа боочихно.

Хэрэггүй дээ, гуйя хэмээн Челси ятгаж эхэллээ. “Би түүнийг ХМТ иртэл саатуулж байх хэрэгтэй. Тэр аюултай. Маш аюултай. Би түүнийг явулчихаж болохгүй.” Май хэмээн автоматаас аяга дүүргэж өглөө. – Үүнийг уучих, Спаркс аа. Суу.

Тэрбээр шийдэж ядан хэсэг зогссоноо дараа нь эргэж харав. Челси түүн лүү кокаколатай аяга дөхүүлэн өгнө.

Май.

Энэ үнэгүй ундаа юу? Ямар азтай үдэш вэ, хэмээн тэр уйтгартай хошигнов.

Челси ойртон ирэх машины дуут дохиог сонслоо. “Хурдлаарай. Алив... яараач дээ!” – хэмээн тэр дотроо гуйж байлаа.

Ав, Спаркс, уу. Би явах хэрэгтэй байна хэмээн тэр эрүүл гараа өргөөд хүрэмнийхээ ханцуйгаар хөлсөө арчин татгалзлаа. – Миний толгой эргээд байна. Жаал хэвтгье.

Цочирдсоноос болж байгаа юм аа хэмээн охин тайлбарлав.

– Суу. Алив, Спаркс аа! Машины дуут дохио улам чангарсаар байна. “Тэд нар яагаад ингэж удаад байна? – хэмээн Челси гайхаж байлаа. – Ийм их хугацаа өнгөрөөд байхад”. Алив даа, Спаркс аа. Үүнээс уучих. Тэгээд арай гайгүй болно.

Тэр аяга авлаа.

Хүүш, би зүгээр л тоглосон юм байхгүй юу даа. Ойлгож байна уу, энэ бол зүгээр л тоглоом байсан юм. Би мэднэ хэмээн Челси хаалга руу ширтэнгээ толгой дохин,

– “Түргэлээрэй! Түргэлээрэй!” – хэмээн яаруулж байлаа.

Би хэдэн аяга шар айраг уучихсан юм л даа, тэгээд... Санаагаа бүү зовоо хэмээн Челси тайвшруулах гэж хичээж байлаа. – Алив, наад кокаколагаа уучих. Түүнийг хэдхэн балга ч ууж амжаагүй байтал үүд нээгдээд цагаан халагтай хоёр асрагч өмнөө тэрэг түрсээр гүйн орж ирлээ. Тэр хаана байна? – хэмээн тод шаргал үстэй туранхай өндөр залуу нь асуув. Тэгээд Спарксыг харснаа тодотгон: Чи юу? гэв.

Тэр аягаа ширээн дээр болгоомжтойхон тавиад өндөр асрагч руу эргэж харан:

Гараа түлчихлээ гэж аяархан гомдоллоо. Оооо... яаж байгаад чи ингэчихдэг байна? хэмээн нөгөөх асрагч нь түүний гар луу ширтэн ярвайгаад асуув.

Аз тохиолдоод л тэгэхгүй юу хэмээн Спаркс ширүүн хэллээ.

Явж чадах уу? гэж өндөр асрагч асуулаа. Спаркс толгой дохив.

Бид нар чамайг Шейдисайдын эмнэлэгт хүргээд өгье Хүлээж байгаач дээ... хэмээн Челси хэллээ. “ХМТны төлөөлөгч хаана байна? Тэд нарыг ирээгүй байхад би түүнийг явуулчихаж болохгүй шүү дээ.” Гэтэл ашгүй үүдэнд урт хар пальтотой хүн харагдлаа. Төлөөлөгч Форрест байна хэмээн тэр тэмдэг, үнэмлэхээ үзүүлэв. Тэгээд харцаараа Челсиг хайж олоод: Чи зүгээр үү? гэв. Охин толгой дохилоо.

Тийм ээ. Бүх юм сайн. Би таныг ирсэнд баярлаж байна.

Спаркс өвдсөндөө ёолоод, хөл дээрээ арайхийн тогтон Челси өөд эргэн харлаа.

Энд юу болоод байгаа юм бэ? Төлөөлөгч Форрест тэмдгээ халаасандаа хийчихээд асрагч нар дээр очлоо. Түүнийг эмнэлэгт аваач. Би түүнтэй хамт явна. – Дараа нь Спаркст хандан: ХМТны төлөөлөгч Форрест байна. Залуу минь, би чамд хэдэн асуулт тавих гэсэн юм гэв. Юу болоод байгаа юм бэ? хэмээн Спаркс цочирдож бачимдан давгаж асуулаа. Тэрбээр анхаарлаа төвлөрүүлэхийг хичээн Челси өөд ширтэнэ. Охин нүдээ бурууллаа. Форрест гараа Спарксын мөрөн дээр болгоомжтой тавиад:

Алив гарыг чинь хараадахья, дараа нь ярилцья гэлээ. Би юу хийчихсэн юм бэ? хэмээн Спаркс хариулахыг шаардаж байна. – Энэ чинь ямар учиртай юм бэ? Түүнийг хоёр асрагч үүдээр

аваад гарахад эсэргүүцээр байв.

Араас нь ХМТны төлөөлөгч явлаа. Төлөөлөгч Форрест хаалгаар гарснаа дараа нь түүний толгой цухуйн:

Чи яг зүгээр биз? хэмээн асуув. Челси толгой дохилоо.

Чамайг зоогийнхоо газрыг хаатал чинь би хамт байх уу? Үгүй. Бүх юм зүгээр байна хэмээн Челси хариуллаа. – Би одоо хаалгаа түгжээд гэртээ харина. Дараа нь бид ярилцах хэрэгтэй байна, хэмээн Форрест хэлээд хаалганы цаагуур орон алга боллоо.

Челси амьсгаагаа чангаар гаргаад хүндээр хана наллаа. Тэгснээ гал зуухны өрөөнд хүний хөлийн чимээ сонсов.

Хэн бэ? хэмээн цочиж хашгирлаа. Цонхоор Эрнигийн толгой цухуйв. Энд чинь юу болоод байна? хэмээн тэр асууна. – Чи зоогийнхоо газрыг хааж байна уу? Эрни... Чи хаана байсан юм бэ?! хэмээн Челси ширүүн асуулаа. Тэр арын хашаа руу гардаг хаалга өөд заав. Тийм ээ, эндээс явах цаг нь болж хэмээн Челси санаа алдсанаа хэлээд хаалгануудаа хурдан түгжээд авав. Эрни шарсан дэгдээхийний махны үлдэгдэлтэй цаасан уут аваад түргэхэн яваад өглөө. Охин түүний явж байхыг араас нь харж зогссоноо дараа нь зүрх нь тайвширч гүйцээгүй байгааг мэдрэн гэрэлнүүдээ унтрааж эхэллээ. Хачин юм даа, Спарксыг аваад явчихсан байтал айдас хэвээрээ байх юм.

О! – хэмээн гэнэт шилэн хаалганы цаанаас хар сүүдэр байхыг хараад хашгирлаа. Тэрбээр маш их айсан болохоороо гудамжны гэрэлд түүнийг дор нь таньсангүй. Уилл!

Тэр зориг муутайхан инээмсэглэнэ. Охин хаалга онгойлгов.

Намайг хожигдсонд уучлаарай. Уилл, би чамайг ирсэнд ямар их баярлаж байна аа! – хэмээн Челси дуу алдаад бодох юмгүй түүнд тэврүүллээ.

Уиллын нүүрэн дээрхи гайхсан байдал түргэн алга боллоо, охиныг тэврээд тэр чанга гэгч нь өөртөө наалдуулав.

Би ч гэсэн чамайг харсандаа баяртай байна. “Өнөөдөр шийдвэрлэх үдэш болсон” хэмээн тэрбээр охины үснээс үнэртэх хашин тосны үнэрээс дотор нь эвгүйрхэн өөрөө өөртөө давтан хэлж байв.

Түүнийг тэвэрч байхдаа тэр нүдээ анина: “Өнөөдөр шийдвэрлэх үдэш. Өнөөдөр чи үхнэ”.

## 18-р бүлэг

Буйдан дээр Уилл Челсигийн хажууд суугаад түүний яриаг сонсон инээдээ барьж ядаж байлаа.

Түүнд буйдан дээр цовхрон гараад гараа өндөрт өргөн баярласандаа орилмоор санагдаж байлаа.

“Энэ мангар охин ХМТд буруу залууг бариад өгчихсөн. Одоо тэгээд энд суугаад зогсоо зайгүй шулганан хэрхэн айснаа, тэр муу амьтан түүнийг хөөж байхдаа ямар аймаар харагдаж байсан, намайг хараад хэрхэн баярласнаа ярьж байдаг. Маш инээдтэй юм хэмээн тэр бодож байлаа. Гэвч тэр одоохондоо жинхэнэ айдас гэж юу байдгийг мэдэхгүй... Одоохондоо”.

Байшинд тэр хоёроос өөр хэн ч байхгүй байлаа. Челси түүнд ээж нь шөнийн ээлжтэй, аав нь эмнэлгээс гараагүй гэж хэлсэн.

“Маш сайн. Үүнээс сайн юм гэж хаана байх вэ? хэмээн хэдийгээр охин жаахан хайран байсан ч Уилл бодож байлаа. Тэр түүнд таалагдаж байлаа. Тийм болохоор тэр өөрийгөө “Охидыг хайрлана гэдэг бол шал утгагүй зүйл. Эрт орой хэзээ нэгэн цагт тэд нар чамайг заавал хаячихна. Миний эх шиг. Хаячихаад эргэн дурсах ч үгүй. Гэвч би үүнийг хэзээ ч мартахагүй. Би таныг санаж явна шүү, ээж ээ, таныг олон олтлоо... санаж явна. Гэвч би таныг олно. Мөдхөн олно” хэмээн ятгаж байлаа.

Челси түүний гараас атгасан хэвээрээ өнөөдөр ямар сэтгэл догдлуулсан үдэш болсон тухай дуржигнуулсан хэвээрээ л байна.

Сул гараа Уилл арынхаа халаас руу явууллаа. Уяа байрандаа байна. Цагаа хүлээж байна. Гэтэл гэнэт санаанд нь нэг бодол орж ирлээ. Тэрбээр бодоход нь саад болоод байгаа Челсигийн яриаг хэрэгсэхгүй байхын тул нүдээ анисхийлээ. “ХМТны төлөөлөгчид. Тэд нар удахгүй үүний барьж өгсөн хөөрхий амьтныг тэдэнд хэрэгтэй хүн биш байна гээд мэдчихнэ. Тэгээд дахиад л хайж эхэлнэ. Аягүй бол намайг гээд мэдчихсэн байгаа даа. Миний араас явж байна. Миний хаа байгаа газар дагах юм. Гэхдээ би тэднийг үргэлж нэг алхмаар түрүүлж чадаж байсан. Гэхдээ энэ удаа тэд нар маш ойртож ирээд байна. Тэдний нэг нь энэ гэрт ирсэн. Гэтэл би энд зүгээр суугаад л энэ чалчаа охиныг сонсож цагаа алдаж байдаг”.

Чи яасан санаашрангуй байдалтай байх юм бэ? хэмээн Челси түүний гарыг атган хэллээ. – Алив, Уилл, арай хөгжилтэй байгаач дээ! Миний бүх юм сайн байна ш дээ.

“Инээх бас нэг шалтгаан гараад ирж хэмээн түүн лүү юу ч үл харан ширтлээ.

Бүх зүйл нь хэвийн байна гэж горьдож байгаагий нь. Үгүй, энэ бүхнийг дуусгаад арилж өгөх минь.”

Охин түүний хацрыг үнслээ.

Миний төлөө чи ингэтлээ санаа зовж байгаа чинь үнэхээр сайхан байна...

Бүх юм... чи тийм ойрхон очсонд байгаа юм хэмээн хөндий царай гарган хүчлэн хэллээ. Тэгээд дотроо өөртөө тушаал буулган: “Мангартахаа боллоо. Түүнийг дуусгах хэрэгтэй” гэж байв. Гэнэт түүнийг хүйтэн нэвт эзэмдэж авахыг мэдэрлээ. Энэ бол яг түүнд таалагддаг зүйл байв.

Уилл, би чамд хэлэх гэсэн юм хэмээн Челси тэр үеэр нь хэлж байлаа.

Охин түүний юу хэлэх гэж байгаа юм бэ? хэмээн асуухыг хүлээж байгааг тэр ажлаа.

Юу? хэмээн тэр асуув. Би үүнийг хийх ёсгүй байсан гэдгийг мэднэ л дээ хэмээн охин зориг муутайхан хэллээ. – Үгүй, би анхныхаа болзоог нууц хэвээр нь хадгална гэж тохиролцсоноо санаж байна л даа. Гэхдээ... – тэрбээр гүнзгий санаа алдлаа. – Би чиний тухай найз охин Нинадаа ярьчихсан.

Залуу арай ядан тайван байдлаа хадгаллаа. Тэрбээр татвас хийсэн ч үгүй, ярвайсан ч үгүй, түүний нүүрэнд нэг ч булчин хөдөлсөнгүй.

“Бодох хэрэгтэй, бод, бод хэмээн Уилл өөртөө тушаалаа.

– Байдал өөрчлөгдсөн. Юуны өмнө Челсигийн нүүр лүү хамаг шүд нь өрөөгөөр нэг бутран унагал хамаг хүчээрээ цохиод авмаар санагдав. – “Яаж тэр намайг тэгж чадав аа? Хамаг юм тийм сайхан бүтэж байсан шүү дээ”.

Үнэхээр Уилл сайхан ааштай байсан. ХМТ буруу хүнээ бариад авчихсан, тэгээд тэр Челсид хичнээн их андуурсныг нь үзүүлээд өгөх гэж байлаа.

Челси түүнийг юу гэж хариулахыг нь хүлээн харж байв. Түүний нэг ч булчин хөдөлсөнгүй. Уилл биеэ барьж чаддаг байлаа. “Эхлээд бодох хэрэгтэй” хэмээн тэр өөртөө хэллээ.

Шинэ нөхцөл байдалд юу хийхээ шийдье.

Гэнэт нэг санаа төрлөө.

Бүх юм ийм хялбар шүү дээ! Сандраад байх шалтгаан алга. Тэднийг хоёуланг нь л алчих хэрэгтэй”.



## 19-р бүлэг

“Уилл их сайн залуу шүү хэмээн Челсид санагдана. Өнөө орой надад тохиолдсон явдлыг сонсоод тэр ингэтлээ дуугаа хураачихлаа. Надад сайн болоод л миний төлөө ингэтлээ айсан байх”. Ингэж бодсоноо тэр Нинад анхныхаа болзооны тухай ярьснаа хэлчихсэн билээ. Гэтэл ашгүй тэр огтхон ч уурласангүй. Уиллын хацар нь үргэлж тэгдэг шигээ час улайчихсан. Гэхдээ нүд нь эелдэгээр харж, гар нь түүнийхийг чанга атгаж байна.

Би найз охин Нинатай чинь танилцмаар байна, хэмээн Уилл аяархан хэллээ. Шейдисайдад хүнтэй нөхөрлөнө гэдэг чинь тийм ч хялбар биш шүү дээ, тийм ээ? Эндхийнхэн нэг нэгнийгээ бүр цэцэрлэгт байхаасаа л таньдаг бололтой. Тэдний дунд өөрийн болох тийм ч хялбар биш дээ.

Тийм ээ, би үүнийг мэднэ хэмээн Челси зөвшөөрөв. Өдий хүртэл би ганцхан Нинатай л найзалсан. Бусад охидууд нэг их биеэ тоочихсон юм шиг байна лээ.

Уилл түүний гарыг тавиад урагшаа боллоо.

Ер нь Нинаг урьвал яасан юм бэ? Би түүнтэй танилцахыг маш их хүсч байна.

Челси инээмсэглэлээ.

Тэгэлгүй яахав. – “Сайхан санаа байна хэмээн тэр бодлоо. Нинагийн өмнө Уиллаар гайхуулж, ганц өөрийг нь хөвгүүд хөөрхөн гэж боддоггүй гэдгийг үзүүлээд өгье”. – Охин бослоо.

– Би гал зуухны өрөөнөөс түүн лүү утасдья... За юу? Кокакола ч юмуу өөр ямар нэг юм авах уу?

Тийм ээ. Ёстой сайхан хэмээн тэр хариу инээмсэглэв. – Түүнийг түргэл гэж хэлээрэй.

Челси бушуухан гал зуухны өрөө рүү өчих юмсан гэхээс тэсч ядаж байв. Уилл түүнтэй хоёулхнаа үлдэх гэж нэг их хүсэхгүй байгаа нь хачирхалтай санагдсан боловч сайн найзтай нь танилцах гэж тэмүүлж байгаа нь таалагдаж байна. Энэ удаа Нина биш, тэр өөрөө эрэгтэй хүүхэдтэй хамт байна гэсэн бодол ч бас аятайхан санагдаж байлаа.

Нина утсаа тэр дор нь авлаа.

Хүүш ээ, чи над дээр одоо хүрээд ирж чадах уу? хэмээн Челси амьсгаагаа даран ядан хэллээ. – Манайд чамтай танилцуулах гэсэн зочин байна.

Танай ангийн нөгөөх эрэгтэй хүүхэд үү? хэмээн Нина таачихав.

Тийм ээ. Тэгээд тэр чамтай танилцах гэж тэсэн ядан хүлээж байна. Харин би чамд үнэхээр сонирхолтой түүх ярьж өгөх гэж тэсэн ядаж байна. Ирэх үү? Яг одоо?

Ийм урилгаас яахин татгалзаж болох билээ дээ хэмээн Нина хариулаад аяархан инээлээ. –

Челси, чи үнэхээр зүгээр биз? Чиний хоолой чинь нэг л хачин байх чинь. Чинийхтэй адилгүй.

Би зүгээр л догдолсон байна хэмээн Челси тайлбарлалаа.

Түргэлж үзээрэй. За юу?

Би одоо очлоо гэж хэлээд Нина утсаа тавьчихав. Челси хөргөгчнөөсөө хоёр лааз кокакола гаргаад зочдын өрөө рүү явж байтал утас дуугарлаа. Лаазнуудаа гал зуухны ширээн дээр тавьчихаад тэрбээр утсаа авлаа.

Байна уу? Энэ Челси Ричардс уу? ХМТны төлөөлөгч Мартин ярьж байна.

О, сайн уу! хэмээн Челси хариулав. Би таныг утасдана гэж хүлээж байгаагүй шүү...

Тим Спаркс миний хайж байгаа залуу биш байна хэмээн Мартин түүний ярихыг намхан нэг хэвийн дуугаар тасаллаа.

Юу? тэрбээр харилцуураа алдаад унагаачих шахав. Тэр залуу биш байна хэмээн Мартин тод дуугаар давтан хэллээ. Анхандаа мөн юм шиг санагдсан. Гаднах байдал төрх нь тохирч байсан юм. Гэвч бид нар андуурсан байна. О! – Челси юу ч хэлж чадахаа байжээ. Түүний хоолой нь давчдаж байв. Тэр залуу, Спаркс хэсэг хугацаанд эмнэлэгт хэвтэнэ хэмээн төлөөлөгч Мартин үргэлжлүүлэн ярина. – Түүний гар нь хүнд байдалтай байгаа, тэгээд ч тэр цочролоос гараагүй байгаа бололтой. Харамсалтай байна гэж хэлээд, Челси толгойгоо эргэж байгааг мэдэрлээ. Охин гараасаа харилцуураа тавилгүй хонгил руу утасныхаа уртын хирээр шагайн харлаа. Зочдын өрөө рүү шагайвал Уилл догдолсон байдалтай алхалж байлаа, нүд нь хөөрснөөсөө болж гялалзаад, хар буржгар үс нь унжлагатай чийдэнгийн гэрэлд гялалзана. Хүчтэй гараараа тэр богинохон олс тэнийлгэн барьжээ. Челси байрандаа зогтусав. Тэгээд гэнэт бүгдийг нь ойлголоо.

О, Бурхан минь! хэмээн тэр харилцуур луу дуу алдан шивнэв.

## 20-р бүлэг

Челси, юу болов? хэмээн Мартин өнөөх баргил, тод дуугаараа асуулаа.

Би... би энд түүнтэй хамт хоёулахнаа байна! хэмээн Челси гартаа уяа барьсан чигээрээ догдлон алхалж байгаа Уилл өөд нэг хяламхийснээ гал зуухны өрөө рүү аяархан ухрав.

А? Чи юу хэлнэ вэ? – Мартин мэргэжлийнхээ дууны хөг аялгыг мартсан бололтой байв. – Түүний дуунд түгшүүр сонсогдож байна.

Энэ бол миний ангидаа танилцсан нэг хөвгүүн байгаа юм, хэмээн Челси, Уиллыг юу ч сэжиглэхгүй, гал зуухны өрөөнд ороод ирчихгүй байгаасай хэмээн найдан хаалга руугаа харан харан түргэн шивнэж хэллээ. – Тэр энд байна. Шинэ хөвгүүн. Уилл Бейкли. – Тэрбээр түүний гаднах төрх байдлыг тоочин хэлэв.

Тэр мөн юм шиг байна хэмээн Мартин түүний яриаг тасаллаа.

Арай ч дээ хэмээн Челси халаглав. Дахиад л түүний толгой эргэлээ. Тэрбээр ширээнээс зуурч авгал гал зуухны өрөө эргэлдэхээ болилоо. – Одоо би яах вэ?

Даруйхан гэрээсээ зугт хэмээн төлөөлөгч Мартин хэллээ.

– Харилцуураа тавиад зугт. Челси, аль болох хол зугт. Арван минутын дараа гэхэд бид тийшээгээ өөрийнхөө хүмүүсийг явуулна.

Гэхдээ... хэмээн охин зөрөх гэв.

Гэрээсээ яг одоо зугтаа! хэмээн түүний үгийг тэр тасаллаа. Холбоо тасрав. Чичирсэн гараараа Челси харилцуураа тавилаа. Галзуухны

өрөө дахиад л эргэлдэж эхлэв. Кокаколатай хоёр лааз ширээн дээрээс гулсаад унах гэж байгаа мэт санагдана. Дараа нь гал зуух хэлтийлээ.

Челси гэтэн хонгилын өрөө рүү оров. Уиллын зочдын өрөөгөөр холхих алхаа сонсогдоно.

“Тэр юу хийх гэж байга юм бол? яагаад тийм аюултай гэж? Яагаад Мартин тэгтлээ их түгшсэн бэ?”

Энэ бүх асуултанд хариуг нь хайх юм бол тэр зугтааж чадахгүй нь гэдгээ ойлгож байлаа.

Хамаг бие маань хөшчихлөө гэж үү? Хөдөлж чадахгүй нь ээ? Уилл ёстой нэг сайн санаатай, зориг муутай, эелдэг, ялдам хүн шиг санагдсан шүү дээ. Тэгээд ч охин түүнд жинхнээсээ таалагдаж байх шиг байсан. Түүний таалагдсан анхны хүн байсан. Үүнд л тэр итгэхийг хүсч байлаа. Бүгд хоосон санаа. Үгүй. Бүр дор. Энэ бүхэн худал хуурмаг. Мангар худал хуурмаг. Тэр өөрөө мангар байж.

“Өөр хүнд... Спаркст, итгэхийг улайран хүсч байсан худал хуурмагаас болж муу зүйл хийтлээ мангартсан байна”.

“Хөдлөөч хэмээн Челси бүдэг гэрэлтэй хонгилын өрөөнд зоогдчихсон мэт зогсоод, Уиллын алхааг чагнан өөртөө тушаалаа. – Хөдлөөч, хөдлөөч, хөдлөөч!” Дараа нь гал зуухны өрөө рүү шурхийн, хаалга угз татан харанхуй, хүйтэн шөнө рүү год үсрэн гараад арын жижиг хашааны хатуу, хөлдүү газар дээр гараад ирэв. Модод найган ганхаж, шөнийн тэнгэр харанхуй, бүр од ч үгүй байна.

“ Би хаашаа явах вэ? Юу хийх вэ? гэтэл Челси гэнэт Нинагийн тухай саналаа. – Нина наашаагаа ирж байгаа шүү дээ. Энд хэзээ хэзээгүй хүрээд ирнэ. Түүнд хэлэх хэрэгтэй. Түүнийг энд ирүүлж болохгүй. Болохгүй”.

Охин цардмал замаар гүйлээ, пүүз нь хүнд таржигнан, гар нь унжиганаж, нүүр өөд хүйтэн салхи үлээж байсан боловч Челси харанхуй дундуур урагшаагаа нисч байлаа. Тэгснээ гэнэт зогтусан айсандаа хашгирчихлаа. – Түүний өмнө Уилл сүүтгэнэн харагдав.

## 21-р бүлэг

Челси... чи хааччих нь вэ? хэмээн Уилл намхан дуугаар зэмлэсэн байдалтай асуулаа.

Тэр хүнд амьсгалсан хэвээр хариу хэлсэнгүй.

Хэсэг хугацаанд тэр хоёр зүгээр л өөд өөдөөсөө харан зогсож байлаа.

Дараа нь Челси цааш нь юу хийхээ бодох гэж оролдон нүдээ зам руу буулгав.

Чи хаашаагаа гүйж байгаа юм бэ? хэмээн Уилл үргэлжлүүлэн асууна. – Яагаад чи энд байгаа юм?

“Хариулахаа больё, хэмээн охин бодлоо. – Мангар тайлбар бодож олоод яах юм. – Тэртэй тэргүй юу ч гэж хэлсэн итгэх биш”.

За яахав. Хариулсны хэрэггүй хэмээн залуу мөрөө хавчин хэллээ. – Энэ ямар ч хамаагүй. Хоёулаа гэртээ ороод ярилцъя хэмээн Уилл урагш нэг алхан хэлэв. – Бидний болзоо дуусаагүй байна шүү дээ.

Үгүй хэмээн охин ухран хэллээ. – Би чамайг хэн гэдгийг чинь мэднэ! Намайг зөнд нь орхиоч! – Түүний дуу цангинасан, догдолсон сонсогдоно. “Гүйх хэрэгтэй. Хажуугийн байшин луу гүйе. Хаалгыг нь нүдээд тусламж гуйя”. – Челси Уиллын хажуугаар, машинаар хүрч ирж байгаа ХМТны төлөөлөгчдийг олж харъя хэмээн найдаж ширтэнэ. Охин тэднийг түргэхэн шиг хүрээд ирээсэй гэж залбирч байлаа.

Гэвч Аймшгийн гудамжнаа харанхуй байна. Зөвхөн ганхаж байгаа модны хяхнах дуу л сонсоно.

Челси, битгий зугтаагаач хэмээн Уил аяархан хэлэв. Түүний хэлсэн нь шөнийн салхины исгэрэх дуунд баларна. – Гэртээ хариад санааг чинь юу зовоож байгаа тухай ярилцъя.

Үгүй! – хэмээн Челси цангинасан дуугаар хашгирлаа. Түүний хамаг айдас энэ ганц үгэнд багтжээ. Дараа нь тэгээд гүйлээ.

Залуу харайх гэж байгаа араатан адил ууртай, зэрлэг хашгирав. Тэгээд тэр дор нь гүйцэж очоод америк хөл бөмбөгчин бөмбөг булааж байгаа мэт бэлхүүснээс нь барьж авлаа.

О! Үгүй! хэмээн Челси урагш нь хүйтэн, хагуу шороон дээр унахдаа орилоод духаараа газар хүчтэй мөргөж уналаа. Толгой нь хагарсан мэт өвдөв.

Залуу түүн лүү дайрлаа. Челсигийн хүзүүг уяа хялбархан ороогоод авав. Уиллыг уяагаа чангалж байхад тэр арайхийн эргээд дээшээгээ харчихаад түүн лүү зэрлэг нүдээрээ ширтэж байв.

“За, яахав хэмээн тэр бодлоо. Надад хамаа алга, над руу харж л байг”. Булчингаа чангалан

уяагаа татахад охин эцсийн удаа бөглүү хяхтнав.

Челсигийн гар нь арчаагүй агаар цохилно. Биеэ тавиулах гэж оролдон учир зүггүй нэг тийш нь, дараа нь нөгөө тийшээгээ мушгирна. Гэвч төдөлгүй тэмцэлдэхээ болилоо.

Челсиг дахин амьсгалахгүй байгааг магадлан шалгаад “Үхчихлээ хэмээн Уилл бодов. – Ямар ч амархан юм бэ дээ. Нэг минут ч хүрэхгүй хугацаа орлоо. Хялбархан гэдэг нь. Хүүхдийн тоглоом л гэсэн үг. Ёстой амархан!” Сүүлчийнх нь үгс түүнийг уяагаа гартаа ороогоод халаасандаа хийж байхад толгойд нь эргэлдэж байлаа. Дараа нь дасал болсон баяр хөөр мэдрэн бослоо. Ялсан. Өш хонзонгоо авсан.

Тэгснээ гэнэт цаг бага байгаагаа саналаа. Дараагийн аллагад бэлтгэх хэрэгтэй. Нинагийн. Түүнийг тэгж нэрлэдэг биз дээ? Бас л алахаас биш. Тэгээд энэ байшингаас аль болох хол явах хэрэгтэй... тэгээд аль болох түргэн.

ХМТ хэзээ хэзээнээс илүү ойрхон ирчихээд байна. Энэ бол түргэн ажиллах хэрэгтэй гэсэн үг. Маш түргэн. Найз охиныг нь алчихаад гялс эндээс зайлна.

“Жигтэй юм хэмээн Уилл бодлоо. – Уг нь би алах хүнтэйгээ ойр дотно танилцсаныхаа дараа л алдаг байсан. Гэхдээ энэ бол онцгой тохиолдол. Үнэн хэрэгтээ надад зүгээр л өөр арга алга байна. Ямар ч сонголт алга. Дараагийн удаа илүү анхааралтай байх хэрэгтэй. Тэгээд Челсигээс илүү ганцаардмал охин олж сонгох хэрэгтэй”.

Тэр тонгойгоод түүний хоёр гарнаас барин цогцсыг нуухын тулд байшин луу чирлээ.

Цогцос хүнд байх ажээ. Түүнийг зүлгэн дээгүүр чирч явахдаа тэр бүр ёолж байлаа. Арай хөнгөхөн хүн сонгож болоогүй юм байх даа?

Уилл хүүрийг байшин луу чирч авчираад намхан бутны доор аваачаад орхичихлоо. Амьсгаадан байж түүнийг хажуунаас нь хүн харах нь уу гэдгийг шалгав. “Ёстой хялбархан юм хэмээн тэр дахин бодлоо. – Хүүхдийн тоглоом л гэсэн үг”.

Түүнийг зам дээр зогсож байтал гэнэт машины гэрэл гудамж гийгүүллээ. Машин ирж харагдана.

Машин зам руу аажуухан орж ирэхэд Уилл сүүдэрт нуугдчихлаа. Дараа нь байшингийн дагуу гэтсээр дэлгээстэй байгаа хаалгаар оров.

“Нэг нь газар хэвтэж байна, нөгөөх нь ч удахгүй тэнд хэвтэх болно” хэмээн тэр баярлан бодно. – Олон хүнд энэ таалагдахгүй л дээ гэж тэр сэтгэнэ. – Гэхдээ энэ бол тийм амархан. Тэгээд хичнээн тааламж авч ирнэ вэ!”

Энэ нь түүнийг хүнд ачаа болон дарамталдаг үзэн ядах хорсолоос, өглөө бүр сэрэхэд, шөнө болгон унтахад, хамт байдаг хорслоос, унтмаар байхад унтуулдаггүй, тал тал тийш нь харан тийчлүүлдэг, аймшгийн, зовлонтой зүүд зүүдлүүлдэг хорсолоос ангижруулдаг билээ. Үгүй ядахнаа хэсэг хугацаанд ч гэсэн.

Уилл уяагаа байрандаа байна уу хэмээн халаасандаа гараа хийж үзлээ. Спорт загварын зузаан цамцаа засаад, духан дээр бурзайх хөлсөө алгаараа арчаад зочдын өрөөнд яг гол хаалга чанга тогших агшинд орж ирэв.

## 22-р бүлэг

Хэн бэ? хэмээн Уилл хаалганы зэс бариулаас атган асуулаа.

Нина байна гэсэн эмэгтэй хүүхдийн дуу сонсогдов. Залуу хаалгаа өөр лүүгээ татаад түүнд инээмсэглэнэ.

Сайн уу! Тэрбээр намхан нуруутай, аятайхан, сэргэлэн байрын, богинохон, шулуун, цайвар өнгийн үстэй охин байв. “Надад таалагддаг охин биш байна. Надад огт таалагдахгүй байнаа. Гэхдээ түүнийг алахаас өөр замгүй.” Нина инээмсэглэв.

Чи Уилл уу? – Залуу зориг муутайхан толгой дохино. Охин түүний хажуугаар хонгилын өрөө рүү ороод, зочдын өрөө рүү шагайн Челси хаана байна? хэмээн асуулаа.

Дээр байгаа. Одоохон буугаад ирнэ хэмээн хариулав. Гол хаалга хаахдаа Уилл гадагшаа шагайлаа. Ямар ч машины гэрэл алга. Нам гүм байна. Маш сайн. Тэрбээр уяагаа гаргаж ирлээ. Түргэн ажиллах хэрэгтэй гэдгийг ойлгож байв. “Түүнийг энд хонгилд багалзуурдчихаж болох л юм. Цаг сунжруулаад яахав”. Гэвч Нина зочдын өрөө рүү орон, хөх хүрмээ газар хаячихаад, дэртэй буйдангийн эсрэг талд байх том зөөлөн сандал дээр хөлөө дороо хумиад суучихав. Тэр бие барьсан нимгэн хар өмд, том размерын богино ханцуйтай цамц өмсжээ. Нина үсээ тэнийлгэх гэж сэгсэрснээ Уиллыг орж ирэхэд инээмсэглэв.

Чи Челсигийн ангид байдаг юм уу? хэмээн тэр сонирхон асуулаа.

Тийм ээ. – Тэр толгой дохив. Уилл түүний араас нь очоод зөөлөн сандал дээгүүр тонгойн охины хүзүүгээр уяагаар оосорлоод авмаар санагдаж байлаа. Гэвч болохгүй нь ээ. Нина түүнийг ширтэж байна. Алхам бүрийг нь ажиж байна. Тэрбээр тэднийг түүн лүү ингэж микроскоп доорхи хорхойг харж байгаа мэт байхыг үзэж чаддаггүй билээ. Челси надад чиний тухай бүгдийг нь ярьж өгсөн хэмээн Нина хөгжилтэй хэллээ. “Мэднэ хэмээн Уилл шүүрс алдан бодно. – Чухам тиймээс л би чамайг алах хэрэгтэй байгаа юм”. Харин чангаар зориг муутайхан: Чиний тухай ч гэсэн. Та хоёр үерхээд удаж байгаа юм уу? хэмээн хэллээ. Одоо тэр цаг хожиж хэрхэн мэдэгдэхгүйгээр дөхөж очихоо бодож байлаа. Тийм ч удаагүй хэмээн Нина хариуллаа. – Челси саяхан энд шилжиж ирсэн шүү дээ, чи мартаа юу? А! Нээрээ тийм. Би ч бас. – Түүний хацар улайж байгааг тэр мэдэрлээ.

Чи бэлтгэл дасгал хийдэг юм уу хэмээн охин түүний гарыг харан асуув.

Бага зэрэг л хэмээн Уилл бувтнав.

Гимнастикийн танхимд уу? Цаг гарах юм бол. Надад таалагддаг юм хэмээн тэр үнэнээ хүлээлээ. – Хөлсөө гаргах сайхан шүү. Би ачаалалд дуртай. Хамаг биеэ чангалах.

Чамайг бэлтгэл дасгал хийдэг гэдэг нь шууд л харагдаж байна хэмээн охин тухалж аван хэллээ. – Чи маш хүчтэй харагдаж байна.

“Би үнэхээр хүчтэй шүү хэмээн Уилл бодно. – Мөчийн дараа чи үүнд итгэх болно”.



Түүний нүд зочдын өрөөний цонх руу шилжлээ. – Гадаа машины хоёр бүдэг гэрэл харагдана. Уилл хамаг бие нь халуу оргин цонх руу түргэн гүйж очив. Аз болоход хажуугаар олон суудалтай хуучин суудлын машин тарчигнан өнгөрч байв. Тэрбээр сэтгэл уужран санаа алдлаа.

Юу болов? хэмээн Нина гайхав. Юу ч биш ээ. Зүгээр нэг юм харлаа гэж бодлоо гэснээ Уилл Нинагийн ард гараад ирчихсэнээ ойлголоо. Зөөлөн сандлыг цонх руу буруу харуулж тавьсан байв. Уяагаа гаргаж ирснээ тэнийлгээд чимээгүй түүн лүү алхлаа.

Гэтэл Нина гэнэтхэн займчсанаа түүн лүү эргэн харчихав.

Уяа Уиллын гараас нь мултран газар унав.

Би дээшээгээ гараад Челси яагаад ирэхгүй удаад байгааг мэдээд ирдэг юм уу? гээд Нина зөөлөн сандал дээрээс бослоо. Уилл хурдхан шиг тонгойгоод уяагаа хамж авав.

Үгүй. Хэрэггүй. Тэр одоохон буугаад ирнэ гэсэн. Нина буйдан өөд очив. Түүн лүү хараад зах дээр нь суучихлаа. Зөөлөн сандал аягүй тух муутай юм аа хэмээн тэр дургуйлхсан царай гарган гомдоллов. – Харахад зөөлхөн, эвтэйхэн юм шиг мөртлөө үнэн хэрэгтээ бүр шал эсрэг шүү. Уилл тэсч ядсан байртай цонх руу хяламхийв. Юу ч алга. Дан харанхуй л байна.

Нина хуруунуудаараа буйдангийн түшлэг тогшилно.

Наашаагаа ирээд хажууд суугаач хэмээн тэрбээр Уилл өөд инээмсэглэн урилаа. – Чи намайг айлгаад байна. Уучлаарай хэмээн хариулаад дуулгавартай хүрч очин зөөлөн сандалны ирмэг дээр суулаа.

Чи намайг энэ зөөлөн сандалны тухай үнэн хэлж үү гэдгийг шалгаж үзэх гэсэн юм уу? хэмээн охин асуув. Чи лавхан суу л даа. Зөвхөн лавхан сууж байж л гэм үүнийг мэдэж болно.

Уилл зөөлөн сандал дээр дуулгавартай лавхан суугаад аажмаар уцаарлаж эхэллээ “Би цагаа хий дэмий үрж байна. Энэ охин зүгээр л миний цагийг үрэх юм. Дуусгах цаг нь болсон. Эндээс явахгүй бол болохгүй.”

Хөөш.. Челси! – хэмээн Нина цагаан хоолой адил гараа амандаа барин дээшээгээ хашгирлаа. – Челси, чи тэр дээр юугаа хийгээд байна аа?

Хэн ч хариулаагүй нь мэдээж.

Уилл Челсиг боож алахад нүд нь хэрхэн бүлтийгээд ирснийг санаж байлаа. Түүний нүд нь хэрхэн хялайгаад, бие нь хэрхэн зөөлрөөд, хэрхэн тэмцэлдэхээ больсоныг нь тэр харж байна. Дараа нь түүнийг байшингийн арын намхан бутан доор хэвтэж байгаагаар төсөөлнө. “Түүнийг эд бад хийхэд маш хялбар байсан хэмээн тэр бодно. Хялбараас хялбар. Яг хүүхдийн тоглоом шиг. Энүүнийг яахаар ийм хэцүү байдаг байна?”

Хөөш, Челси! хэмээн Нина толгойгоо шат руу эргүүлээд дахин хашгирлаа. – Уилл, чи юу гэж бодож байна, түүнтэй юу ч тохиолдоогүй болов уу?

Үгүй. Бүх юм зүгээр. – Тэр хуруугаа тас хийлгэн дуугаргаснаа, Ө, би мартчихсан байна шүү дээ. Челси гарсан.

Юу? хэмээн Нина түүн лүү сэжиглэнгүй харцаар харав. Тийм ээ. Тэр гарсан хэмээн Уилл хааш яаш үргэлжлүүлэн хэллээ. – Зайрмаг авах гэж. Зайрмаг аа? – Нинагийн харц улам сэжигтэй болоод явчихлаа. – Үгүй, ингэхэд гадаа аймаар хүйтэн байна шүү дээ. Тэгээд ч Челси зайрмагт дургүй...

Тэр чамайг иднэ байх гэж бодсон юм хэмээн духан дээрээ хөлс бурзайж байхыг мэдрэн Уилл хэллээ.

Яасан хачин юм бэ? хэмээн Нина бодлого болон хэлэв.

– Тэгээд зайрмаг авах гэж хаашаа яваа вэ?

Гудамж руу хэмээн Уилл хэлээд хөхрөв. “Боллоо, хэмээн тэр бодно. – Би цагаа дэмий үрж байна. Би түүнийг ямар ч шуугиангүй төгсгөө гэж бодож байсан юм. Гэвч үүнтэй эвлэрхээс биш. Тэртэй тэргүй ойр зуур хэн ч байхгүй юм чинь. Тийм болохоор хэн ч сонсохгүй. Надад сонголт алга.” Тэрбээр босоод гараараа уяагаа тэнийлгэлээ. Энэ юу вэ? хэмээн Нина гайхав. Буйдан дээр эвхрээд тэр гэнэт айсан байдалтай харлаа. Уилл хариулсангүй. Тэгэхийн оронд гэнэт дайраад буйдангийн налуур луу шахав. Охин учиргүй чарлан эсэргүүцэл үзүүлж, түүнийг зангидсан хоёр гараараа түлхэж, өвдгөөрөө цохин, мултарч гарах гэж оролдоно. Гэвч залуу илүү хүчтэй байлаа. Тэгээд хүзүүнд нь түргэхэн олсоо ороогоод авав.

## 23-р бүлэг

Гэвч Уиллыг олсоо чангалж татах гэтэл Нина өвдгөө өргөөд байдаг тэнхээгээрээ цээж рүү нь цохьчихлоо. Залуу гайхсандаа болоод дуу алдан ганхаад, амьсгаа авахын тулд гэдийлээ. Түүний цээж чичирч байв.

“Уяа! Би уяагаа алдчихлаа!”

Нина байдгаараа чарлан буйдан дээрээс босох гэж хичээнэ.

Харин Уилл тэдний чарлаж хашгирхыг огт тэвчиж чаддаггүй билээ. Түүнд саад учруулахыг огт тэвчиж чаддаггүй. “Түүнд сургаад өгөхөөс дөө” хэмээн шийдлээ.

Нина мултарч чадлаа. Харайж босоод кофены намхан ширээ мөргөлөө. Уилл дээрээс нь цэцэгний хүнд шавар ваар шүүрч аваад түүгээрээ савлан түүний араас тэмүүлнэ.

Охин өрөөний голд оччихоод хаашаа явахаа мэдэхээ байлаа. Тэгснээ дахин цөхрөнгүй чарлав. Дараа нь хүндээр амьсгалан зогтусаад эргэж харснаа нүдээ том болгон түүнийг ширтлээ.

Яагаад? хэмээн түүний гарт байгаа ваарыг харан байж асуув. – Яагаад?

Уучлаарай хэмээн Уилл хэллээ. Тэрбээр өөр юу ч бодон олж чадсангүй. Үүнийг түүнд хэрхэн тайлбарлах билээ? Тэгээд энэ бүхнээ үгээр илэрхийлж чадах байсан ч тэгж байх цаг түүнд байхгүй байв. Челси хаана байна? хэмээн Нина асуулаа. Тэгснээ гэнэт айсандаа амаа ангайчихав. – Чи түүнийг алчихсан уу? Чи Челсиг алчихсан уу?

Тэрбээр толгойгоо дохилоо. “Худлаа хэлээд ч яах юм билээ”.

Челси! хэмээн охин ориллоо. – Челси! – Түүнд итгээгүй мэт байна.

Уилл түүн лүү түргэн алхана.

Нина эргээд хонгилын өрөө лүү орлоо, тэгснээ модон шалан дээгүүр халтиран байж гал зуухны өрөө рүү гүйв.

“Би түүнийг алдаж болохгүй. Арын хаалгаар түүнийг яасан ч гаргаж болохгүй. Гадаа гарвал тэр тусламж дуудан орилоод, хүн амьтан сонсчихож мэднэ. Үүнийг тэр ойлгохгүй байна гэж үү? Надад өөр сонголт байхгүй гэдгийг тэр ойлгохгүй байна гэж үү?”

Челси! хэмээн Нина хашгирсаар байлаа. Туслаарай! Туслаач дээ! Туслаач... хэн нь ч яахав!

Түүний пүүз жижигхэн хонгилын өрөөний шалан дээгүүр тарчигнана.

Уилл түүнийг гал зуухны өрөөний хаалганы тэнд гүйцээд очив. Араас нь мөрийг нь барьж аваад хүчтэй түлхчихлээ. Охин гал зуухны намхан ширээ мөргөчихөөд, амьсгаа нь бөглөрчихлөө. Уилл түүнд сэхээ авах цаг өгсөнгүй. Нинаг амьсгаа авч чадахгүй ширээн

дээрээс өндийх гэж оролдож байхад нь тэрбээр хүнд ваараа далайгаад дагз руу нь буулгачихав. Охин аяархан гиншсэнээ сөхрөн уналаа. Түүнийг дор нь гүйцээчих хэрэгтэй байв.

## 24-р бүлэг

Гэтэл Уилл Нинаг багалзуурдах гээд тонгойтол хэн нэгний хүчтэй гар түүний мөрнөөс нь зуураад хойш нь татлаа. Залуу айсандаа болоод таварцаглаад тэнцвэрээ алдчихав. Гэтэл түүнийг чанга түлхсэнд тэр хана мөргөлөө. Гэвч дор нь сэхээ аваад халдсан хүн лүүгээ эргэн харснаа айсандаа хар нүдээ бүлтийлгэн дуу тавин ориллоо.

Челси! – Тэр цочирдсон байв. – Нуруугаа тэнийлгэснээ уначихгүйн тулд гараараа хана түшлээ. – Челси! Үгүй байлгүй дээ! Би чамайг алчихсан шүү дээ!

Хулдаасан дээр ухаан алдчихаад тэрийн хэвтэх Нинагийн Өмнө зогсоод Челси түүн өөд догшин харцаар харна. Түүний даахирсан үсэнд хатсан хүрэн навчис наалдан, жинсэн өмдөнд нь хар шавхай наалдсан байна.

Би чамайг алчихсан! Чи үхчихсэн! хэмээн Уилл хана налсан чигтээ давган хэлнэ.

Челси хүнд амьсгалан түүнлүү харж байв.

Уилл түүнээс хамгаалах гэсэн мэт нүүрээ гараараа дарлаа.

Үгүй! Чи үхчихсэн! Үхчихсэн! гээд охиныг бусдын адил үхчихсэн гэдгийг нотлох хүзүүн дээрхи бараан улаан зурвас өөд ширтнэ.

Би эргээд ирчихсэн хэмээн Челси хүндээр амьсгаадан хэллээ.

Гэнэт Уилл түүн лүү ухасхийн дайрав.

Чи үхчихсэн! Чи үхчихсэн! гээд охиныг бэлхүүснээс нь барьж авснаа хатуу бие байхыг мэдэрлээ. “Жинхэнэ юм байна. Хий үзэгдэл биш юм байна. Үхчихсэн. Гэхдээ жинхэнэ”.

Уилл түүнийг хөдөлсөн боловч нүдээ нээгээгүй Нинагийн хажууд шалан дээр унагаагаад дарлаа.

Чи үхсэн! Чи үхсэн! Челси чанга хашгирснаа түүний гараас мулталчихав. Уилл түүнийг бариад авах гэсэн боловч охин босчихоод угаалтуур луу ухарч байлаа.

Залу босоод... хөшчихлөө.

Челси гал зуухны өрөөний ширээн дээрээс хуйнаас нь томоос том хутга гаргаж иржээ. Түүний нүд нь хорссондоо зэрлэг мэт гялалзаж, ам нь ангалзаж байна, тэрбээр хутгаа өргөөд түүн лүү дайрав.

Челси Уиллын хажууд нь ирээд гялтганах ирээр нь түүний цээж өөд онилоход залуу ухраад гар луу нь өшиглөчихлөө.

Челси өвдсөндөө болоод чанга ёолон хашгирлаа. Гар нь халуу оргин дорхиноо мөрлүү нь

шилжлээ. Хутга түүний гараас мултран хана мөргөөд Уиллын хөлний дэргэд уначихав.

Тэрбээр хутга аваад:

Энэ удаа би чамайг бүр ална гэв.

## 25-р бүлэг

Баруун гартаа хутгаа чанга атгаад Уилл хананаас түлхэн хөндийрөөд Челси өөд давшилна.

Уилл, чи намайг хоёр дахиа алахгүй юм байгаа биз дээ хэмээн Челси түүнийг даажигнах мэт тайван хэлнэ. – Би чинь үхчихсэн шүү дээ. Чи мартчихаа юу? Чи намайг хоёр дахиа алж чадахгүй.

Үгүй! хэмээн Уилл орилов. – Энэ худлаа! Тэгснээ гэнэт Челси түүн лүү харахгүй байгааг мэдэрлээ. Түний харц ард нь болж байгаа үйл явдал руу тэмүүлсэн байна. Зөнгөөрөө эргэж харвал үүдэнд хар богино шинель өмссөн том биетэй хоёр хүн байв. Хоёулаа шууд түүн лүү ирж байсан бөгөөд царай нь баргар, шийдэмгий байлаа.

“Тэдний гарт нь юу байна аа? Гар буу. Тэд нар гар буугаа зэхээд барьчихаж”.

ХМТ байна хэмээн Мартин Уилл руу хүрч ирээд хэллээ.

– Хутгаа хая. Тэрбээр хутгаа хаяснаа Челси өөд заагаад:

Би түүнийг алчихсан хэмээн хэллээ. Мартин нэг гартаа буу барьсан чигтээ нөгөө гараа Уиллын мөрөн дээр тавьлаа. Залуу чанга санаа алдсанаа бууж өгөв бололтой. Нөгөөх төлөөлөгч нь Нинаг босоход нь тусална.

Бүх юм зүгээр үү? Дагзаа илэн Нина шийдэмгий бус толгойгоо дохив. ХМТны төлөөлөгч Челси өөд харлаа.

Миний ч гэсэн бүх зүйл хэвийн байна хэмээн Челси тайлбарлалаа. – Би яг үхдэгийн даваан дээр байсан, гэхдээ одоо зүгээр.

Би түүнийг алчихсан хэмээн Уилл хэнд ч хандалгүй давтан хэлнэ. Түүний нүд нь сүүмийж, нүүр нь өнгөө алджээ. Тэрбээр гал зуухны өрөөнд асах өдрийн чийдэнгийн гэрэлд цайчихсан, сульдсан мэт харагдана. – Би түүнийг алчихсан.

Тайван бай хэмээн төлөөлөгч Мартин Уиллын бугуйнд гав зүүгээд гайхалтай зөөлөн шаардав. – Дараа нь бүгдийг яриарай.

– Тэрбээр Челси өөд эргэн хараад: Юу болсон юм бэ? Чи ярьж чадах уу?

Тийм гэж бодож байна хэмээн Челси мухар сандал дээр суун хэллээ. – Тэр намайг гадаа гүйцэж очсон. Намайг тантай утсаар ярихыг сонссон бололтой. Намайг зам дээр зогсоогоод боож алах гэсэн. Энүүгээр. – Охин газар хэвтэж байгаа олсны тасархайг заав.

Би чамайг боогоод алчихсан шүү дээ хэмээн Уилл давтсаар байлаа. – Би чамайг алчихсан. Би тэгсэн гэдгээ яг мэдэж байна.

Би чиний бодож байгаа шиг тийм мангар амьтан биш хэмээн түүний өөдөөс Челси ууртай

хэлэв. Би зүгээр л үхэж байгаа дүр үзүүлсэн юм. Намайг боохыг чинь болиулах цорын ганц арга гэдгийг ойлгосон

Гэхдээ би шалгасан шүү дээ хэмээн Уилл өөрийхөөрөө зөрөөд байна. Чи амьсгалахгүй байсан. Би шалгасан.

Би саксофон дээр тоглодог хэмээн Челси тайлбарлав. Энэ нь уушигны багтаамжийг их болгодог юм. Би амьсгаагаа удаан түгжиж чадна. Бүтэн дөрвөн минут. Би бэлтгэл сургууль хийдэг байсан. – Охин төлөөлөгч Мартин өөд эргэн хараад үргэлжлүүлэн: Би их айсан, ёстой ухаангүй их айсан. Гэхдээ үхсэн хүний дүр эсгэсэн. Нүдээ хялайгаад, хүндээр газар унаад амьсгалахаа больчихсон. Тэгээд бүтсэн шүү. Намайг тэр үхчихлээ гэж бодсон.

Дараа нь тэгээд яасан? хэмээн Нина асуугаад найз охиныхоо араас очоод бэлхүүсээр нь тэвэрлээ.

Би босох гэсэн. Гэхдээ ухаан алдчихсан юм шиг байна. Айснаасаа болж. Ухаан орсон чинь чиний хашгирахыг сонссон. Гэр лүүгээ яаран орсон. Чамайг түүнээс аврах хэрэгтэй гэдгийг ойлгож байсан.

Нина Челсиг улам чанга тэвэрлээ.

Би дахин хэзээ ч чамайг саксофон тоглолоо гэж шоолж байхгүй. Чамайг лимбэ сонгох хэрэгтэй байсан гэж хэзээ ч хэлэхгүй. Амлая, хэмээн Нина найз охиндоо ая тал засаж ядан хэллээ.

\* \* \*

Би их буруутай хэмээн Челси эвхэгддэг сандал дээр ёсорхон суун хэлснээ халдваргүйжүүлэх бодисны эвгүй үнэрийг авч чадахгүй амьсгаагаа хураалаа. Би ч гэсэн буруутай хэмээн Спаркс хариулав. Тэрбээр орныхоо толгойг налан сууж байлаа. Түлэгдсэн гар нь зузаан гэгч боолттой байлаа.

Хоёулаа нэг нэгэндээ ичингүйрэн инэмсэглэв.

Тийм болохоор бид хоёр хоёулаа буруутай юм байна хэмээн

Спаркс дүгнэн хэлээд чимээгүйхэн инээв.

Цагаан хувцастай сувилагч түргэн орж ирээд, өвчтөн рүү очин дуслын тариаг нь шалгачихаад юу ч хэлэлгүй гараад явчихлаа.

Энэ чинь ямар зориулалттай юм бэ? хэмээн Челси ярвайн асуув.

Антибиотик бололтой хэмээн тэр хариуллаа. Түлэнхий рүү бохир орсон. Тийм болохоор намайг энд байлгаад байгаа юм. Дуслын тариа өвтгөдөггүй юм. Жигтэй харагддаг юм л даа, гэхдээ би түүнийг мэдэрдэг ч үгүй.



Тэгвэл сайн байна хэмээн Челси толгой дохиод эмнэлгийн жижигхэн өрөөний цонх руу харлаа.

Сонс доо, ийм юм болсон нь надад үнэхээр харамсалтай байна хэмээн өөр хэлэх үг олж хэлж чадахгүй байна.

Эмнэлгийн эргэлт үргэлж их хүнд байдаг. Челси аавыгаа эргэж Шейдисайдын эмнэлэгт их ирж байсан. Гэхдээ тэнд дандаа л сэтгэл таагүй байдаг байсан.

Үгүй энэ бол миний буруу хэмээн Спаркс эрүүл гараараа үсээ илбэн зөрөв.

Тэр үдэш би хэдэн аяга шар айраг уучихсан байсан. Гэтэл би хэзээ ч уудаггүй. Хэзээ ч. Яагаад ч тэгсэнээ ойлгохгүй юм... Маш их ганцаардаж байсан болоод тэгсэн байх. – Тэрбээр нүдээ буруулаад үргэлжлүүлэн:

Тэр орой ямар дүр эсгэх гэсэнээ ойлгохгүй юм. Өөрийгөө жинхэнэ эр хүн гэдгийг харуулах гэсэн юм байлгүй. – Спаркс боолттой гар луугаа харснаа аяархнаар нэмэн – Тэгээд таарсан шангий нь хүртсэн нь энэ. Гэхдээ би чамайг айлгах гээгүй юм шүү. Тэр ч, өөр ч орой.

Одоо надад чамайг солиотой алуурчин гэж бодох ямар ч шалтгаан байхгүй хэмээн Челси мэдээлсэнээ.

Би чиний өмнө их буруутай гэж хэллээ. Би чамд бүгдийг нь хэлээгүй байгаа хэмээн Спаркс түүний нүд рүү харан үнэнээ хүлээв. Би гэрээсээ оргочихсон юм. Эцэг эх маань хүүгээ хаана явааг ч мэдэхгүй. Тэр хоёрын хэрэлдэхийг би харсаар байгаад залхаж гүйцсэн юм. Тийм болохоор би ийшээгээ ирж бие даан амьдрах гэж оролдсон юм. Дахиад сургуульд орно. Оройн. Ажилд орчихсныхоо дараа. Гэхдээ надад үнэхээр аймаар байна. Би урд өмнө нь хэзээ ч ингэтлээ ганцаардаж байгаагүй. Тийм болохоор л би тийм хачин зан гаргасан биз. Чи бид хоёр хоёулаа хачин зан гаргасан юм шиг байна хэмээн Челси хариулав. Залуу өндийгөөд арынхаа том хавтгай дэрийг засна.

Хөөе,

Спаркс хөгжилтэй болоод ирлээ,

Хоёулаа нэг уулзалдах уу? Чиний тэр зоогийн газар биш ээ, өөр газар.

Челси дуугуй байснаа тодотгон:

Чи намайг... болзоонд урьж байгаа юм уу?

Тийм. – Тэр толгойгоо дохисноо зориг муутайгаар:

Хэрвээ чи зөвшөөрвөл шүү дээ гэж нэмэн хэллээ. Охин чанга инээв. Хоёр дахь болзоо маань нэгдэхээсээ илүү амжилттай болно гэж найдья!

# Table of Contents

<a href="#">1-р бүлэг</a>
<a href="#">2-р бүлэг</a>
<a href="#">3-р бүлэг</a>
<a href="#">4-р бүлэг</a>
<a href="#">5-р бүлэг</a>
<a href="#">6-р бүлэг</a>
<a href="#">7-р бүлэг</a>
<a href="#">8-р бүлэг</a>
<a href="#">9-р бүлэг</a>
<a href="#">10-р бүлэг</a>
<a href="#">11-р бүлэг</a>
<a href="#">12-р бүлэг</a>
<a href="#">13-р бүлэг</a>
<a href="#">14-р бүлэг</a>
<a href="#">15-р бүлэг</a>
<a href="#">16-р бүлэг</a>
<a href="#">17-р бүлэг</a>
<a href="#">18-р бүлэг</a>
<a href="#">19-р бүлэг</a>
<a href="#">20-р бүлэг</a>
<a href="#">21-р бүлэг</a>
<a href="#">22-р бүлэг</a>
<a href="#">23-р бүлэг</a>
<a href="#">24-р бүлэг</a>
<a href="#">25-р бүлэг</a>